



ХӨВСГӨЛ аймгийн ЭРДЭНЭБУЛГАН сум

ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

(2013-2021 он)

Булган тал 2013 он

Эрдэнэбулган сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Засаг дарга Д.Батхүрэлийн удирдлага дор ЗДТГ-ын дарга М.Оюумаа даргатай сумын Төлөвлөлт, хяналтын хороо, Засаг даргын орлогч Б.Эрдэнэнаран ахлагчтай Ажлын хэсэг хамтран 2013 оны 08 сараас 2014 оны 03 дугаар сард сумын төв- Булган талд боловсруулав.

Төлөвлөгөөг сумын Төлөвлөлт, хяналтын хороо, Ажлын хэсгийн хамтарсан үр дүнгийн семинараар 2014 оны 03 дүгээр сарын 29-нд хэлэлцэв.

Хөгжлийн стратеги төлөвлөгөөг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж батлав.

Тогтоолын дугаар 14



ХӨВСГӨЛ аймгийн ЭРДЭНЭБУЛГАН сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө нь тус сумын төр, нутгийн удирдлагын болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийт, аж ахуйн нэгжийн хамтын бүтээл бөгөөд өмчлөх, зохиогчийн эрх тус суманд хадгалагдана.

Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Төлөвлөлт, хяналтын хороо жил бүр хэлэлцэж, төлөвлөгөөний явцыг үнэлэх, шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох байдлаар сайжруулж байна.

ЭРДЭНЭБУЛГАН сумын хөгжлийн энэхүү төлөвлөгөөг Мерси Кор олон улсын байгууллага болон Монголын нутгийн удирдлагын холбооноос хэрэгжүүлж буй **“Иргэдийн оролцоо ба орон нутгийн хөгжлийн төлөвлөлт”** төслийн хүрээнд тухайн байгууллагуудын арга зүй, зохион байгуулалт, санхүүгийн дэмжлэгтэйгээр боловсруулав.

Зөвлөх баг: Г.Маналжав, **С.Цогтоо**



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 03 дугаар сарын 30ны өдөр

Дугаар 14

Булган тал

**2013-2021 онд Эрдэнэбулган сумыг
хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн “А” дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус IV хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1.Эрдэнэбулган сумыг 2013-2021 онд хөгжүүлэх хөгжлийн төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, Сумын төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааны журмыг хоёр дугаар хавсралтаар, “Эрдэнэбулган сумын дүрэм”-ийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3.Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэхийн дээр засаглалын хугацааны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан боловсруулан мөрдөж ажиллахыг сумын Засаг даргад даалгасугай.

4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөв, гадаадын төсөл, хөтөлбөр, хандив, тусламжийн хүрээнд зохион байгуулан шийдвэрлэж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдлыг жил бүр танилцуулан шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулж тодотгон ажиллаж байхыг сумын Төлөвлөлт хяналтын хороонд даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгдчэд үүрэг болгосугай.

ИТХ-ын ДАРГА

П.АРИУНСАН

ХӨГЖЛИЙН ГАРААГ БИД ЭХЛҮҮЛНЭ

... Хөгжлийн үндэс нь сайтар боловсруулсан хөгжлийн цогц төлөвлөгөө юм...

Эрхэм хүндэт Эрдэнэбулганчууд болон Эрдэнэбулган суманд ажиллаж амьдарч байсан нөхөд та бүхний түмэн амар амгаланг айлтгаж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Мөн та бүгдийн өмнөөс Сум хөгжүүлэх төлөвлөгөөг санхүүжүүлж, арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн тусалсан АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас санхүүжих Мерси Кор Монгол Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөөх Идэвхитэй түншлэл ба Иргэдийн оролцоо” (ARPEAL) төслийн хамт олон болон Монголын нутгийн удирдлагын холбооны хамт олонд гүн талархал илэрхийлье.

Манай сум нь ойрын ирээдүйд нутаг орноо хүн ардтайгаа бүх талаар нь хөгжүүлэх бодлогын баримт бичигтэй болж өнгөрсөн одоо үеийн ажлаа дүгнэн ололтоо бататган, дутагдлаа засч, ирээдүйгээ гэрэл гэгээтэйгээр төсөөлж, иргэд, айл өрх, албан байууллага, сум орон нутгаа хэрхэн хөгжүүлэх, ямар үр дүнд хүргэж ажиллах арга замаа тодорхойлох төлөвлөгөөтэй болж байна.

Бид сум хөгжүүлэх төлөвлөгөөтэй болсноор зүг чигээ олох луужинтай болж хүний нөөц, хөрөнгө мөнгөө зөв тооцон зарцуулах бөгөөд цаг хугацааг хэмнэж эдийн засгийн талаар бие даан хөгжих бололцоо бүрдэнэ.

Энэхүү төлөвлөгөөгөө иргэдийнхээ оролцоотойгоор тодорхойлохын зэрэгцээ бүгдээрээ зүтгэж байж үр дүнд хүрэх тул, та бүгдийн оновчтой санаа бодлоор ямагт баяжигдан чанаржиж байх тул та бүгдийг нутаг орныхоо хөгжил дэвшилд үнэтэй санал бодлоо оруулж хамтран зүтгэнэ гэдэгт итгэж байна.

Сайн үйлс дэлгэртүгэй.

СУМЫН ЗАСАГ ДАРГА



Д.БАТХҮРЭЛ



ЗОРИЛГО БОЛ ХӨГЖИЛ



Эрхэм хүндэт Эрдэнэбулганчууд та бүхний минь ажил амьдрал сайн сайхан байхын ашидын ерөөлийг өргөн барьж мэндчилье.

Сумын хөгжлийн төлөвлөгөө батлагдлаа. Энэхүү төлөвлөгөөг боловсруулахад хүчин чармайлт гаргасан нийт албан хаагчдадаа болон хэлэлцүүлэгт оролцсон иргэд, нутгийн зөвлөлүүддээ баярласан талархсанаа илэрхийлье.

Сум илүү хурдаар илүү хөгжил рүү очих зорилгоо тодорхойллоо. Өнөөдөр бид хөгжлийн хувьд хаана яваа юм, ирээдүйд хаана очих тухай тодорхой тусгасан чиг зүгтэй боллоо. Энэхүү хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэн таны оролцоо хамгаас чухал.

Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй бүлээн усаар угаавал хиргүйн сургаалиар иргэн та бүхнээсээ асууж, шүүн тунгааж боловсруулсан энэхүү төлөвлөгөө нь Эрдэнэбулган нутгийн минь цаашдын хөгжлийн үндэс болно гэдэгт ИТХ-ын даргын хувьд эргэлзэхгүй байна.

Эвийг дээдэлж эх нутаг минь хөгжих болтугай.
ИТХ-ЫН ДАРГА П.АРИУНСАН



ЭРДЭНЭБУЛГАНЧУУДЫН ХӨГЖЛИЙН САНААЧИЛГЫГ АЙМАГ ДЭМЖИНЭ


Эдийн засаг, нийгмийн хөгжлийн залгамж чанарыг хангах зорилгоор хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийг сумынхаа онцлогт тохируулан боловсруулах нь нутгийн удирдлага, төрийн байгууллагын тулгамдсан асуудлын нэг болж байна.

Энэ цаг үед Эрдэнэбулган сумын ИТХ, ЗДТГ, ард иргэд хамтран сумынхаа “Хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулан гаргаж байгаа нь ихээхэн ач холбогдолтой юм. Өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хөгжлийг бодитойгоор судлан үнэлэлт дүгнэлт өгч сумынхаа хөгжлийн гарц, алсын хараа, тэргүүлэх чиглэлээ тодорхойлон хөтөлбөр төслүүдээр томъёолон гаргасан нь Хөгжлийн төлөвлөгөөг илүү ойлгомжтой хэрэгжих үндэслэлтэй болохыг харуулж байна.

Сумын хөгжил айл өрхөөс, Аймаг, Улсын хөгжил сумаас эхтэй учраас Эрдэнэбулганчуудын энэхүү хөтөлбөрт тусгагдсан асуудлуудыг бодитой ажил болгоход Хөвсгөл аймгийн төрийн байгууллагууд, олон нийт дэмжин ажиллана гэдгээ илэрхийлж байна.

Байгалийн үзэсгэлэнт газар нутаг, ажилсаг хөдөлмөрч зан чанараараа манлайдаг Эрдэнэбулган нутгийн ард түмэн та бүхэнд өөрсдийн боловсруулсан хөтөлбөр, төлөвлөгөөг бодит ажил болгоход нэгдмэл хүч, санаа бодолтой, нэгэн үзүүрт сэтгэлээр хамтран ажиллаж амжилтанд хүрэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Хөвсгөл аймгийн засаг дарга



А.Эрдэнэбаатар

ГАРЧИГ

- 1 УДИРТГАЛ
- 2 СУМЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ
- 3 Төлөвлөгөө боловсруулсан үндэслэл
- 4 Төлөвлөгөөний зорилго, зорилтууд
- 5 Хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулсан арга зүй
- 6 Хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын зохион байгуулалт, зарчим, үйл явц
- 7 Төлөвлөгөө боловсруулсан бүрэлдэхүүн
- 8 СУМЫН ХӨГЖЛИЙН ОДООГИЙН БАЙДАЛ
- 9 Сумын товч танилцуулга
- 10 Нутгийн удирдлагын зохион байгуулалт
- 11 **Эдийн засгийн ерөнхий үзүүлэлтүүд**
- 12 Эдийн засгийн салбаруудын хөгжил
- 13 Нийгмийн салбарын хөгжлийн байдал
- 14 Байгаль орчны салбарын хөгжил
- 15 Сумын эдийн засгийн чадавхийн үнэлгээ
- 16 Сумын бизнесийн орчны судалгааны үр дүн ба дүгнэлтүүдийн тойм
- 17 СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
- 18 СУМЫН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД
- 19 Сумын хөгжлийн зорилго, зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн тойм
- 20 Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамаарах талууд, тэдний оролцоо, хүлээх үүрэг
- 21 Хөгжлийн төсөл хөтөлбөрт оролцох хөрш зэргэлдээ сумдтай хамтран ажиллах
- 22 ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ
- 23 ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ
- 24 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТУУД

УДИРТГАЛ

Эгийн голын хөвөөнд 83 жилийнхээ хөгжлийн хуудсыг эргүүлж буй манай сум газар тариалан, мал аж ахуйдаа түшиглэн хөгжиж, эрүүл мэнд, боловсрол, соёлын салбар болон төрийн албаны шинэчлэлийн энэхүү цаг мөчид иргэдийн оролцоонд тулгуурласан сумын хөгжлийн урт хугацааны анхны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх эрхэм үүргийг хүлээж, өөрсдийн оюун ухаан, хүч хөдөлмөрийг дайчлан ажиллаж, та бүхэндээ толилуулж байгаадаа баяртай байна.

Энэхүү чухал баримт бичгийг боловсруулахад гар бие оролцсон төр захиргааны ажилтан, төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид, иргэд 2021 онд өөрсдийгөө дүгнүүлэх түүхийн хуудсыг нээж үлдээв.

Сумын хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсанаар хөгжлийг урт хугацаанд харах, нутгийн захиргааны байгууллага болон иргэдийн санал санаачлагыг хослуулан үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх, тодорхой хугацаанд хийх ажлаа нэгтгэн эрэмбэлэх боломж бүрдэж байна.

Уг төлөвлөгөө нь цаашдаа тасралтгүй хөгжлийн баримт бичиг болж, та бидний хөгжлийн чиглүүлэгч, хөтөч байхаас гадна иргэн бүр чин сэтгэлээсээ хамтран ажиллаж, дэмжиж, амжилтанд хүрэх нь та бидний хамгийн гол зорилго юм.

Энэхүү төлөвлөгөө нь Эрдэнэбулган сумын иргэдийн өмч бөгөөд төлөвлөгөөг жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн нэмэлт, өөрчлөлт оруулах эрх зөвхөн хуралд хадгалагдах бөгөөд үр дүнг мэдээлж байх үүрэг Засаг дарга, түүний Тамгын газарт байх болно.

Үүнээс гадна 2021 онд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, орон нутгийн нөөцөд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжсөн, бизнес эрхлэх боломж, дэмжлэг бүрдсэн, иргэдийн эрүүл мэнд, боловсролын түвшин дээшилсэн, байгаль орчны зохистой хэрэглээ төлөвшсөн зэрэг үр дүнд хүрэхийн тулд иргэн бүрийг чадварлаг үйлдвэрлэгч, суралцагч байхыг уриалж, Эрдэнэбулганчуудынхаа эрхэмлэх 9 зүйлийг тодорхойлон дэвшүүлж байна.

Эрдэнэбулганчуудын эрхэмлэх 9 зүйлс:

1. Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэнэ.
2. Эрүүл мэндийг эрхэмлэнэ.
3. Боловсролыг эрхэмлэнэ.
4. Иргэн бүрийн оролцоог эрхэмлэнэ.
5. Ёс заншил, соёл, өв уламжлалаа эрхэмлэнэ.
6. Байгалиа унаган төрхөөр нь хойч үедээ өвлүүлэхийг эрхэмлэнэ.
7. Бүтээлч, хариуцлагатай, гадаад дотоод хамтын ажиллагааг эрхэмлэнэ.
8. Хууль ёсыг сахиж, үнэнч шударга, ил тод байдлыг эрхэмлэнэ.
9. Цахим хэрэглээний хурдацтай хөгжлийг эрхэмлэнэ.

Сайн үйлс дэлгэрэх болтугай!

**ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
БОЛОВСРУУЛСАН:
СУМЫН Б.ЭРДЭНЭНАРАН АХЛАГЧТАЙ ”АЖЛЫН ХЭСЭГ”**



Нэг. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУРААНГУЙ Төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага

Монгол улс нь улс, аймаг, бүс, сум, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж ирсэн арвин туршлагатай ард түмэн юм. Эрдэнэбулган сум нь 2009-2013 он хүртэлх дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллаж ирсэн. Гэвч энэхүү хөтөлбөр нь иргэдийн оролцоо бага, тооцоо судалгаа хомс боловсруулагдсан учир өнөөгийн хурдацтай хөгжлийн явцад шаардлага хангахгүй байна. Иймд төрийн бодлого шийдвэртэй уялдуулан олон нийтийн оролцоон дээр тулгуурлан, тооцоо судалгааг нарийвчлан гаргаж, шинэчлэн боловсруулах шаардлага тулгарч байна. Сумын ИТХ, Засаг даргын санаачлага, Мерси-Кор Олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр сумын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан гаргаж байна. Хөгжлийн төлөвлөгөөнд сумын хөгжлийг хангах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, ая тухтай ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлэх ажил үйлчилгээг эрэмбэлэн нэрлэж, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, хэрэгцээт санхүүг тооцоолон, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, иргэдийн оролцоог бүх талаар хангах хөтөлбөр төслүүд тусгагдах юм.

Төлөвлөгөөний зорилго:

Сумынхаа онцлог давуу тал, нөөц боломжинд түшиглэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бие даасан байдлыг хангаж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих, ая тухтай, амар тайван ажиллаж амьдрах, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг урьдчилан төлөвлөхөд оршино.

Төлөвлөгөөний зорилтууд:

- Төрийн бодлого шийдвэр, улс, аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдуулан, орон нутгийн онцлог, давуу талд түшиглэсэн хөгжлийн хэтийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох
- Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл болсон ХАА-н бүтээгдэхүүний тогтвортой өсөлтийг хангах, орон нутгийн нөөцөд суурилсан ЖДҮ-ийг хөгжүүлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх.
- Төрийн удирдлагын залгамж чанар, ажлын уялдаа холбоог сайжруулах, төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлж, төр, иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэх.
- Эрүүл, оюунлаг, бүтээлч сэтгэлгээтэй, өв соёлоо дээдэлсэн иргэнийг төлөвшүүлэх.
- Гадаад, дотоод хамтын ажиллагааг сайжруулах, үйлдвэрлэл үйлчилгээ болон бусад чиглэлээр хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх.
- Байгалийн нөөц баялгийг хайрлан хамгаалах, зүй зохистой хязгаарлалттай ашиглах, ээлтэй үйл ажиллагааг дэмжих.

Төлөвлөгөөний хамрах үе шат

Сумын эдийн засгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2013-2021 оны хугацаанд хамран хэрэгжих бөгөөд хугацааны хувьд гурван үе шаттай байна.

- Эхний үе шат -2013-2015 он
- Хоёр дах үе шат -2016-2019 он
- Гуравдах үе шат -2020-2021 он

Төлөвлөгөө боловсруулсан үйл явц, зохион байгуулалт

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө боловсруулахад төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, нийгмийн бүхий л салбар, бүлгийн төлөөллүүдээс бүрдсэн Төлөвлөлт Хяналтын Хороо, Ажлын хэсэг гэсэн 2 бүрэлдэхүүнийг байгуулж, Мерси-Кор ОУБ-ын дэмжлэгтэйгээр мэргэжлийн зөвлөх багшаар удирдуулан ажиллалаа. Төлөвлөгөөнд сумын хөгжлийн өнөөгийн түвшинг тодорхойлон, судалсны үндсэн дээр хэрэгцээ шаардлагаа тодорхойлон гаргаж, хөгжлийн алсын хараа, зорилго, зорилтууд тэдгээрийг хангахад чиглэсэн хэрэгжих боломжтой хөтөлбөр, төслүүдийг тодорхойлон тусгасан болно. Төлөвлөгөөнд олон нийтийн оролцоог хангах, тэдний санал санаачилгыг тусгах, сумын хөгжлийн гарцыг хамтдаа эрэлхийлэх зорилгоор давхардсан тоогоор 2309 хүний санал сэтгэгдлийг сонсож, гол гол саналуудыг төлөвлөгөөнд тусгасан болно.

Олон нийтийн оролцоог хангасан байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

№	Оролцооны үнэлгээ	Хэдэн удаа	Хамрагдсан хүн
1	Фокус бүлгийн ярилцлага, судалгаа	7	175
2	БОС	2	25
3	SWOT шинжилгээ	12	350
4	Олон нийтийн хэлэлцүүлэг	5	200
5	Санал асуулгын хуудас	4	183
6	Сумын чадавхийн үнэлгээ	2	68
7	Ганцаарчилсан ярилцлага	35	35
8	Мэдээллийн самбар	1	199
9	Зохион бичлэгийн уралдаан	2	41
10	ИТХ-ын төлөөлөгч сонгогчидтой уулзах	4	400
11	Багийн засаг дарга айл өрхөөр явж санал авах	2	570
12	Саналын хайрцаг	3	84
13	Санал авах дэвтэр аялуулах	2	59
Д Ү Н		81	2309

Эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөний онцлог

Сумын стратеги хөгжлийн төлөвлөгөө \2012-2021\ нь сумын өнөөгийн түвшний тооцоо судалгааны үндсэн дээр тодорхойлогдож, олон нийтийн оролцоог ханган, тэдний санаа бодлыг тусгаж, МУ-ын хэмжээнд мөрдөж

байгаа стандартын дагуу мэргэжлийн баг, зөвлөх багшийн арга зүйн дэмжлэгтэйгээр хөгжлийн алсын хараа, зорилго, зорилтууд тэдгээрийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийг нэг бүрчлэн нэрлэж, хамрах хүрээ, хариуцах эзэн, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах төсөв санхүүг нарийвчлан тооцож боловсруулснаараа онцлог, хэрэгжих үндэслэлтэйг батлан харуулж байна.

Төлөвлөгөө боловсруулсан бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Дарга: - Б.Эрдэнэнаран - Сумын Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга: - О.Нанжид -Цэцэрлэгийн эрхлэгч
- Б.Энхмаа -Газрын даамал
- Д.Энхцэцэг -Татварын улсын байцаагч
- Г.Энхтуяа -ЕБС-ийн багш
- Ө.Батжаргал -Малын эмч
- Д.Дагва -4-р багийн иргэн
-Д.Гантуяа -ЭМТ-ийн ахлах сувилагч
-Х.Оюунбаатар -Сумын ерөнхий ня-бо

Төлөвлөлт, хяналтын хорооны бүрэлдэхүүн:

Дарга: - М.Оюумаа - Сумын ЗДТГ-ын дарга

Эдийн засгийн хөгжлийн ажлын бүлэг

Д.Батхүрэл -Ажлын бүлгийн ахлагч, сумын Засаг дарга
Ч.Оюунчулууун -Хувиараа бизнес эрхлэгч
Б.Давааням -4-р багийн иргэн
Э.Идэр -ЗДТГ-ын ЖДҮ-ийн мэргэжилтэн
А.Мөнхтөр -Багийн Засаг дарга
Б.Түвдэндорж -Багийн Засаг дарга
Д.Энхцэцэг -Татварын улсын байцаагч
Ж.Оюунбилэг -Төрийн сангийн төлөөлөгч
Ө.Батэрдэнэ- -Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Бизнес орчны хөгжлийн ажлын бүлэг

Б.Эрдэнэнаран -Ажлын бүлгийн ахлагч, сумын Засаг даргын орлогч
М.Оюумаа -ЗДТГ-ын дарга
Б.Цэцэгмаа -Хувиараа газар тариалан эрхлэгч
Ө.Батжаргал -Малын их эмч
Б.Мандахбаяр -Хувиараа хөдөлмөр эрхлэгч
Д.Болдбаатар -Хувиараа бизнес эрхлэгч
П.Ариунболд -“Үүрийн долгио” ХХК-ийн захирал

Нийгэм, төрийн үйлчилгээний ажлын бүлэг

Э.Батбаатар -Ажлын бүлгийн ахлагч, сумын сургуулийн захирал

О.Нанжид	-СӨББ-ын эрхлэгч
Д.Тулга	-Соёлын төвийн эрхлэгч
Г.Энхтуяа	-ЕБС-ийн багш
Д.Цолмон	-ЭМТ-ийн эрхлэгч эмч
З.Алимаа	-Хувиараа бизнес эрхлэгч
Б.Анхбаяр	-Оюутан, залуусын төлөөлөл
Б.Ням-Осор	-Оюутан, залуусын төлөөлөл
Д.Гантуяа	-ЭМТ-ийн ахлах сувилагч
Д.Батбаяр	-Холбооны эрхлэгч
Б.Наранцэцэг	-Ахмадын төлөөлөл
И.Энх-Амгалан	-ЕБС-ийн багш

Байгаль орчны ажлын бүлэг

П.Ариунсан	-Ажлын бүлгийн ахлагч, сумын ИТХ-ын дарга
С.Баярсайхан	-Байгаль, орчны улсын байцаагч
М.Мөнх-Эрдэнэ	-Багийн Засаг дарга
Д.Дагва	-4-р багийн иргэн
Р.Бадрах	-Багийн Засаг дарга
Д.Сайнбат	-Хувиараа бизнес эрхлэгч
М.Эрхбаяр	-Багийн Засаг дарга



Сумын Засаг даргын 2014 оны ____ сарын ____ өдрийн ____ тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг

Хоёр. СУМЫН ХӨГЖЛИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

СУМЫН ТҮҮХ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум 469,4 мянган га нутагтай, төв нь Улаанбаатар хотоос 710 км зайтай оршдог. Нутгийн ихэнх нь Хөвсгөл орчмын бэсрэг уулс, Бадар, Дуургын нуруудын хоорондох Эг-Үүрийн голын дагуух нутаг, газар нутгийн 89.2 орчим хувь нь ой модоор бүрхэгдсэн тайгын бүс юм.

Хөвсгөл нуураас эх авсан цорын ганц Эгийн гол, нутгийн төв хэсгээр баруунаас зүүн тийш урсан өнгөрч, Монголын уулын том голын нэг Үүрийн голтой нийлэн Сэлэнгэ мөрөнд цутгадаг. Үүнээс гадна Чичин, Бургалтай, Буурал, Зэрлэг, Удган зэрэг олон арван гол горхи, рашаан булагтай, хүн малын ундны ус арвинтай нутаг юм.

Хамгийн өндөр цэг Зэрлэгийн голын урд нурууны “Хөөгийн асга” нь далайн түвшнээс дээш 2024,2 м, хамгийн нам цэг болох сумын төв 1151,4 м, эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвлийн улиралд хасах 40 хэм хүртэл хүйтэрч, зуны улиралд нэмэх 34 хэм хүртэл халж, өвлийн дундаж тунадас 218 мм, өвөл зуны үргэлжлэх хугацаа төвийн нутгуудтай ижил байна. Чулуун нүүрс, алт, шар ногоон хаш, гантиг, шохой зэрэг өнгөт металлын болон ашигт малтмалын нөөцтэй, төмөр зэвсгийн үеийн томоохон булш элбэгтэй.

Ой хөвчийн бүхий л модлог бутлаг ургамлууд, эдгээр дотроос хаа ч ховор хуш, нарс, гацуур модны зохих нөөцтэй, төрөл бүрийн жимс, эмийн ургамал элбэгтэй. Бүх төрлийн мэрэгчид, гахай, буга, хандгай, гөрөөс, хүдэр, чоно, үнэг, хэрэм зэрэг тайгын амьтдын нөөц ховордож байгаа ч устаж үгүй болоогүй. Томоохон голуудад тул, зэвэг, гутиар зэрэг загастай.

2733 хүн амтай, 784 өрхтэй, 55423 толгой малтай, үүнээс хонь 18877, ямаа 18753, адуу 4319, үхэр 14474 мянга байна.

Тус суманд Эрүүл мэндийн төв, 12 жилийн ахлах сургууль, цэцэрлэг, соёлын төвтэй, 34 аж ахуйн нэгж, 40 худалдааны цэгтэй, арилжааны 2 банк, хилийн хээрийн застав, жуулчны 5 отогтой байна.

Хөвсгөлийн хязгаар нутаг нь 13-р зууны үед Монголын эзэнт улсын хувь эзэмшил буюу Чингис хааны ууган хүү Зүчийн харьяалал Дайчин Мэргэд аймагт, 14,15-р зуунд өрнөд Халхад, 16-р зууны дунд үеэс Батмөнх Даян хааны отгон хүү Гэсрэнз жалайр хун тайжийн захиргаанд хамрагдаж, Манжийн ноёрхлын үед (1691-1911 он) халх дөрвөн аймаг шавь таван газар байгуулагдахад Засагт хан аймаг, Сайн ноён хан аймгуудад харьяалагдах болжээ.

Богд хаант Монгол Улсын үед Өвөр ширхтэн Урианхайн бүгд буюу Жавзандамба хутагтын бага шавьд захирагдан байсан бөгөөд Ардын хувьсгал ялсны дараа 1923 онд Засгийн газраас аймаг хошуудыг эмхэлж, хошуу нутгийг үе улиран өмчлөн захирч байсан засаг ноёдын эрх мэдлийг халах, шинэ хошуу сум байгуулах, орон нутгийн засаг захиргааны байгууллагын тухай хууль батлан гаргаснаар засаг ноёдынх нь хэргэм зэргээр нэрлэдэг байсан аймаг хошууг орон нутгийн томоохон уул, ус,

газрын нэрээр нэрлэх болжээ.

1925 онд Их шавийг халахад Хөвсгөлд Наранжаргалант, Хөвсгөл далай-Дэлгэрхан –Уул, Рашаант, Дэлгэрхаан –Уул гэсэн 4 хошуу бий болсон.

1928 онд хуралдсан улсын V их хурал орон нутгийн Засаг захиргааг шинэчлэн байгуулах бодлогыг чухалчлан боловсруулсантай холбоотойгоор тус сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Хөвсгөл далай Дэлгэрхан уулын хошууны Сант-Өндөр сум нэртэйгээр зохион байгуулагдаж, даргаар нь Зуны голоор нутагтай Жамьян гэдэг хүн томилогдон, удалгүй нэрээ өөрчлөн Эрдэнэбулган гэх болж, даргаар нь Намдагийн Нанзад, Жамсран хурц зэрэг хүмүүс ажиллаж байжээ.

БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хуучин хошуудын захиргааг 1931 оны 04 дүгээр сарын 05-ны дотор татан буулгаж, мөн сарын 10-ны дотор шинээр зохион байгуулах тухай 5 дугаар тогтоолыг баримтлан, Хөвсгөл аймгийг байгуулах түр хорооноос 1931 оны 04 дүгээр сарын 11-30-ны өдрүүдэд Хатгалд Хөвсгөл аймгийн анхдугаар их хурлыг хуралдуулж, БНМАУ-ын 16 дугаар бага хурлын шийдвэр, үндэстэн ястан, аймаг нутгийн зохион байгуулалт, шинэ захиргаа удирдлагыг сонгох зэрэг асуудлыг хэлэлцэж, Цэцэрлэг мандал-Уул, Хантайшир уулын аймгийн 5 хошуу 55 сумыг нэгтгэн, Хөвсгөл аймгийг 24 сум, 439 хоринтой, 69201 хүн, 17431 өрх, 1 сая гаруй мал, 106,2 мянган хавтгай дөрвөлжин километр нутагтай байхаар тогтоол гарган баталсан байна.

Ийнхүү 1931 онд Монгол Улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны шинэчилсэн зохион байгуулалтаар тус суманд Намнан-Уулын хошуунаас гөрөөчин отгийг нийлүүлэн Эрдэнэбулган сум байгуулагдан, сумын анхны хурлыг удирдуулахаар Хурган гэдэг хүн томилогдон ирж, сумын анхны даргаар Нямын Готовыг томилон, сумын төвийг одоогийн оршин байгаа Булган талын эх, Эгийн голын хөвөө, Бургастайн тохойн ард суурьшуулж, сум одоогийн өнгө төрхөө олон хөгжиж иржээ.

Сум байгуулагдах үедээ 9 багтай байснаа 1948 онд Хужирбулан, Шөөл, Тэрхэнийг Түнэл суманд шилжүүлж өгснөөр 7 багтай болж, хилийн дээс одоогийнхоо хэв маягаар тогтжээ.

1950-аад оны дундуур Энхтайван нэгдэл, 1959 онд Эг-Үүрийн сангийн аж ахуй байгуулагдаж, 1990 он хүртэл оршин тогтнож байв. Энэ хугацаанд 2 удаа татан буугдаж, Цагаан-Үүр, Тариалан сумтай нийлж байсан хэдий ч 1985 оноос хойш Эрдэнэбулган нэрээрээ засаг захиргааны зохион байгуулалтанд орсон байна.

НУТАГ ДЭВСГЭР

Эрдэнэбулган сум зүүн хойд талаараа ОХУ-ын Закаменск мужтай, зүүн урд талаараа Булган аймгийн Тэшиг, өмнө талаараа Тариалан, баруун урд талаараа Их-Уул, баруун талаараа Түнэл, баруун хойд талаараа Чандмань-Өндөр, хойд талаараа Цагаан-үүр сумын нутаг дэвсгэртэй залган оршдог.

ХҮН АМ ЗҮЙ

Тус сумынхан удмаараа харуулын халхууд, урианхай, буриад, хотгойд үндэстэн бөгөөд сүүлийн үед шилжин ирэгсдийн дотор дархад, казах, ариг-урианхай зэрэг ганц нэгээрээ буюу хэд гурваараа, гэр бүлээрээ орших бусад ястан ч бий. Үүнээс харуулын халхууд 40 гаруй хувийг эзэлж байна.

2000 онд Монгол улсын иргэний үнэмлэх сольж олгоход олгосон бүртгэлийг үндэслэн тус суманд 2008 оны эцэст тоологдсон 2772 иргэнд ургийн овгийн судалгаа хийж үзэхэд тус сумаас 329 буюу 11,9 хувь нь Боржгон овог авсан байгаа бөгөөд 100-аас дээш тооны гэвэл:

- Өндөр нөр-189
- Бэсүд-197
- Их мэргэд 280
- Харуул 230
- Мэргэд 213 гэх мэт 179 овог бүртгэгдсэн байна.

ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСНИЙ БҮТЭЦ

Эрдэнэбулган сум нь ерөнхийдөө уулархаг, тэр дундаа ой тайга нутгийн газрын гадаргын ихэнх хэсгийг бүрдүүлэх бөгөөд тал орчмоор харьцангуй нам доор тал хээр нутаг зонхилно. Эгийн голын сав дагуух нутаг нь хүнд шавранцар хөрстэй, тал нутгаараа чулуу бага, хар хүрэн, хатуу хөрстэй. Тус сумын хөрс бол хээрийн хүрэн хөрс бөгөөд хэд хэдэн хэв шинж хар хүрэн, хүрэн цайвар, хүрэн, уулын хүрэн, нугын хүрэн, ойн хүрэн хөрсөөр хөгжжээ.

Сумын нутаг дэвсгэр Хангайн уулархаг бүсэд хамрагдах Буурал болон Дуургын нуруу нутгийн дийлэнх хэсгийг эзэлнэ. Уулс хоорондох д.т.д 1100-1500 м-ийн өндөртэй, 1-3 км орчим үргэлжлэх тэгшивтэр тал хөндийн болон уулын энгэр бэлээр зуны улиралд мал бэлчээрлүүлэх, мөн газар тариалан эрхлэх гол нутаг багтана.

ЦАГ АГААРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрдэнэбулган Сумын нутаг Эгийн голын тайга, ойт хээрийн бүсэд хамаарагддаг.Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Өвлийн улиралд -40 °С хүртэл хүйтэрч, Зуны улиралд + 34°С халж, өвлийн дундаж тунадас 218 мм, өвөл, зуны үргэлжлэх хугацаа Төвийн нутгуудтай ижил юм.

Тус сум чийглэг, сэрүүн бүсийн уур амьсгалын мужид багтдаг. Энэ нутагт ордог хур тунадасны ихэнх нь 7-р сард, хамгийн бага нь 9 сард ордог бол улирлын байдлаас хамаараад үүлшлийн байдал өөр өөр байдаг. Хүйтний улиралд үүлшил бага, цэлмэг байдал илүү ба дулааны улиралд үүлшлийн хэмжээ ихэсдэг. Хүйтний улиралд гол төлөв дээд, дунд, мандлын үүл ажиглагдана. Дулааны улиралд гол төлөв конвекцийн үүл болох бөөн ба борооны бөөн үүл, давхраат бөөн үүл ихэвчлэн ажиглагддаг.

ГАДАРГЫН БОЛОН ГҮНИЙ УСНЫ НӨӨЦ

Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэр дээгүүр Эг, Үүр гэсэн Монголын томоохон 2 гол урсан, Сэлэнгэ мөрөнд нийлж, улмаар ОХУ-ын Буриад Улсын нутаг дэвсгэрт орших Байгаль нуурт цутган, цэнгэг усаар тэжээх эх

үүсвэр нь болдог байна.

Мөн Чичин, Удган, Сэрүүн, Урт, Улиад, Архан, Зад, Буурал, Асайт зэрэг 20 гаруй нарийн гол, Харгана, Өлөнт, Сөрт, Шивэрт зэрэг 60 гаруй горхи, Ганц мод, Улиадын хөх хад, Улаан хад, Наран, Цагаан чулуут зэрэг 90 орчим газрын булаг ус хүн ард, ургамал мод, мал амьтныг ундаалан урсаж байдаг байна.



Үүнээс гадна олонд тустай, эмчилгээний ач холбогдол бүхий Долоон булаг, Өтөгт, Шар шорооны зэрэг рашаан ус байдаг ба зуны улиралд буюу жилдээ 90-150 хүн очиж, биеэ сувилан, тэнхэрдэг байна.

Мөн Арханы нуур, Хирвэстэйн нуур, Эг давааны нуур зэрэг байгалийн үзэсгэлэнг цогцоор нь гайхуулсан, хүний хөл ховорхон хүрдэг гайхамшигт нуурууд ч 10 орчим бий.

Хүн амын төвлөрөл бүхий 4-р багийн нутаг дэвсгэр дээр 1 гүний худаг, малчдад зориулсан буюу бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгын хүрээнд баригдсан 18 гүний худаг байна.

УРГАМАЛ, АМЬТНЫ АЙМАГ

Сумын нутаг дэвсгэрт шинэс, хус, бургас зонхилно. Гэхдээ ой хөвчийн бүхий л модлог, бутлаг ургамлууд, хуш, нарс, гацуур модны зохих нөөцтэй.

Ойт хээрийн бүсэд амьдардаг 20 гаруй зүйлийн амьтан нутагшин байдаг ч сүүлийн жилүүдэд нийтдээ ховордож, зарим зүйл амьтад устахад хүрч байгаа нь нэн харамсалтай.

Манай нутагт баавгай, хандгай, буга, гахай, гөрөөс, чоно, хүдэр, шилүүс, нохой зээх, үнэг, хярс, дорго, мануул, чандага, туулай, тарвага, хэрэм, жирх, үен, солонго, өмхий хүрэн зэрэг 20 гаруй зүйлийн амьтаас гадна хур, сойр, ятуу, тоодог зэрэг агнуурын шувууд нутаглана.

Нуур голд хун, галуу, ангир, нугас нүүдэллэн ирэх ба, тас, бүргэд, харцага, шонхор, элээ, хэрээ гээд л талын махчин шувууд элбэг.. Эг, Үүр, Чичин, Зэрлэг, Архан, Буурал зэрэг голуудад тул, зэвэг, гутиар, алгана, цурхай зэрэг загастай.

Мэргэжилтнүүдийн судалснаар тус сумын нутагт хиаг, толгой улалж, улаан толгойт, сөөгт, тал хээрийн бэлчээрт үндэслэг ишт үетэн, дэгнүүлт үетэн, ботууль, агь, ганга, годил өвс, дааган сүүл, засаа өвс, ерхөг, согоовор, хазаар өвс, хялгана, хиаган сүүл, тайжийн жинс, цагаан суль, ямаан сахал гээд бэлчээрийн зүйл зүйлийн ургамал ургаж, яргуй, саадгай цэцэг, тэмээн уруул, цагаан уул гэхчлэн олон төрлийн цэцэг, ургамал алаглана.

Алтан хундага, алтан мөнгөн гагнуур, алтанзул, бамбай, булган таваг,

ванжингарав, жамъянмядаг, намуу цэцэг, хөх, шар дэгд, цагаан ягаан цээнэ, тарваган шийр, таван салаа, чонын хэл, нохойн хошуу, сөд зэрэг эмийн болон эмэнд ашиглаж болох 50 гаруй нэрийн ургамал бий.

Эг-Үүр, Чичин, Зэрлэг, Зад, Бургалтай, Буурал, Унгиагийн голуудын битүү шугуй, Дуурга, Овгор, Сэрүүн, Удган, Бөөрөлж, Бургалтай, Баянгол, Барсага, Горхин, Гачуурт, Овоонт, Буурал, Хушт, Хайрхан, Унгиа, Хонгио зэрэг том уул нуруудад нэрс, аньс, хад, үхрийн нүд, улаалзгана, гүзээлзгэнэ, долоогоно, мойл, самар зэрэг ой тайгын бүхий л төрлийн жимс арвинаар ургадаг билээ.

БАЙГАЛИЙН ҮЗЭСГЭЛЭНТ БОЛОН ДУРСГАЛТ ГАЗРУУД

Тус сумын орон нутгийн хамгаалалтанд авсан газар нутаг 1-р багийн нутагт “Сонгинохайрхан” уулын орчим 1709 га, 3-р багийн нутагт “Буурлын голын бэлчир” орчмын нутагт 9259 га, “Задын эх” 0,5 га, 1-р багийн нутаг “Бүрэг хад” орчмын газар 1086 га тус тус байна.

Бүрэгийн хад, Сонгины хясаа, Хирвэстэйн нуур, Сэнжит хад, Эг-Үүрийн бэлчирийн Ишгэн толгой, Сандаг цахир, Дани толгой, Долоон булагийн рашаан зэрэг олон олон байгалийн үзэсгэлэнт, онгон дагшин газрууд байдаг ба Даян дээрхийн хийд орчмын нутаг, Удганы хүрээний туурь, Арханы хүрээний туурь, 58 орчим тооны томоохон булш хиргэсүүдүүд соёлын биет өвд бүртгэгдсэн байдаг байна. Мөн 50-р өргөргөөс хойшхи нутаг дэвсгэрийг аймгийн орон нутгийн хамгаалалтанд авсан нь манай сумын нийт нутаг дэвсгэрийн 90 орчим хувийг хамарч байгаа юм.

СУМЫН БАХАРХАЛ

1) Төр, нийгмийн зүтгэлтнүүд

	Овог нэр	Эрхэлж байсан ажлууд
1	О.Цэнд	Сангийн Яаманд зааварлагч, хэлтсийн дарга, МУИС-д багш, эрдэмтэн, Статистикийн төв газрын дарга, Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дарга, БНСВУ, БНАСАУ-д суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, эдийн засгийн ухааны доктор
2	Л.Амарсанаа	Дархан хотын Байшин үйлдвэрлэх комбинатын эдийн засагч, хэлтэс, комбинат, үйлдвэрлэлийн нэгдлийн дарга, Дархан хотын АДХГЗ-ны дарга, ИТХТ-ийн дарга, Дархан-Уул аймгийн Засаг дарга, МАХН-ын нарийн бичгийн дарга, БНХАУ-д суух онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, Монгол Улсын ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, МАН-ын ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөх
3	Д.Дашцэдэн	Бүгд Найрамдах Унгар, Бүгд Найрамдах Румын улсад суух элчин сайд
4	Л.Зантав	Монголын Радио телевизийн Улсын хорооны МОНЦАМЭ эрхэлсэн орлогч дарга, МРТУХ-ны дарга, АИХ-ын 2 удаагийн депутат, МАХН-ын Төв Хорооны гишүүн

5	Б.Дамдинсүрэн	Ардын Боловсролын Яаманд хэлтсийн дарга, орлогч сайд, УБ хот дахь Багшийн коллежийн захирал, БСШУЯ-ны бага дунд боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга, дэд эрдэмтэн
6	Д.Жамц	Ховд отрядын дарга, Улсын ЦСГ-ийн дарга, Булган, Өвөрхангай аймгийн дарга, Хүнсний Яамны сайд
7	О.Дагважамц	Гандантэгчлэн хийдийн дэд хамба, шашны философийн ухааны доктор, 14 дүгээр Далай ламын хамтран зүтгэгч

2) Цэрэг, цагдаагийн зүтгэлтнүүд

1. Хошууч генерал С.Ванчиндорж- МАХН-ын Төв хороонд хэлтсийн эрхлэгч, Ардын армийн Улс төрийн газрын даргаар ажиллаж байсан
2. Хурандаа Р.Бадарч- Халх голын байлдаанд домогт 22 дугаар хороог командалж явсан
3. Хурандаа Л.Жамъян- Арми командлагчийн техникийн орлогч дарга, анги нэгтгэлийн дарга
4. Дэд хурандаа Б.Пүрэвжав- Цэргийн дуу бүжгийн ансамблийн удирдаач
5. Хурандаа П.Хаянхярваа- Монгол Улсын Ардын жүжигчин, УГЗ, хөгжмийн зохиолч
6. Хурандаа И.Дамдинжав- Монгол Улсын ууган нисэгчдийн нэг
7. Хурандаа Ш.Дашдорж- НАХЯ-ны хэлтэс, газрын даргаар ажиллаж байсан.
8. Цагдаагийн хошууч С.Жавзмаа- ахмад хуульч
9. Хошууч Ж.Чимиддорж

Хурандаа Х.Сэтэв- цэрэг, иргэний байгууллагад олон жил удирдах алба гүйцэтгэсэн

3) Монгол Улсын хөдөлмөрийн баатар

- Намжилын Бямбацогт- трактор комбайнч, атрын анхны

хөдөлмөрийн баатар

- Хярваагийн Амармэнд-авто тээврийн салбар
- Сэрдамбын Нямдорж- барилгын салбар

Ардын жүжигчин

- Пүрэвжавын Хаянхярваа- Ардын жүжигчин

Гавьяат цолтнууд

- Лувсан-Осорын Нямсүрэн- Гавьяат жүжигчин
- Цэрэнжамцын Ямааранз- Гавьяат тээвэрчин
- Доржпаламын Балжир- Соёлын гавьяат зүтгэлтэн
- Бандийн Пүрэвжав- Урлагийн гавьяат зүтгэлтэн
- Монхоогийн Жавхлантуяа- Гавьяат багш
- Батмөнхийн Товуу- Гавьяат багш

ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ
Сумын хөгжлийн зарим үзүүлэлтүүд

а. Ерөнхий мэдээлэл

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
Байршлын үзүүлэлтүүд		
Улсын нийслэлээс	Км	710
Хүн ам төвлөрсөн зах зээл	Км	240
Хилийн гарц	Км	-
Бүсийн төв	Км	80
Нийт нутаг дэвсгэр	Га	469.4 мян.га
ХАА-н газар	Га	11044,6
Бэлчээрийн газар	Га	150.0
Тариалангийн талбай	Га	6254.5
Үүнээс: Тариалдаг талбай	Га	2772.0
Усан сан бүхий газар	Га	1835.0
Тусгай хамгаалалттай газар	Га	-
Зам, шугам сүлжээний газар	Га	356.2
Хот, суурины эдэлбэр газар	Га	312.96
Уул уурхайн газар	Га	-
Далайн түвшнээс дээш хэдэн метр өндөр	М	2024.2
Байгалийн ямар бүсэд хамардаг		Ойт хээрийн бүс
Жилийн дундаж температур	Градус	-4.7
Зуны дулааны температур дунджаар	Градус	+34
Өвлийн хүйтний температур дунджаар	Градус	-40
Жилийн дундаж хур тундас ОЖД	Мм	301.0
Хуртай жилийн хур тундас тах	Мм	291.1
Нөхөрлөл	Тоо	2
Компани	Тоо	29
Хоршоо	Тоо	6
Улсын үйлдвэрийн газар	Тоо	2
Төсөвт байгууллага	Тоо	6
Төрийн бус байгууллага	Тоо	8
Шашны байгууллага	Тоо	2
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Тоо	41

б. Хүн ам, зүй, нийгмийн хөгжлийн зарим үзүүлэлтүүд

	2009	2010	2011	2012	2013
Сумын нийт хүн ам	2762	2766	2769	2745	2733
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	1390	1407	1390	1371	1368
Ажил эрхэлдэг хүн ам буюу ажиллагчид	1081	1079	1092	1063	1058
Ажиллагчид, үйлдвэрлэлийн салбараар:	1081	1079	1092	1063	1058
Мал аж ахуй	880	888	831	809	815
Цахилгаан дулаан	7	7	2	2	2
Холбоо , тээвэр	8	6	11	14	15
Худалдаа үйлчилгээ	27	27	30	32	32
Төрийн байгууллага	37	37	35	35	35
ЕБС	67	64	57	58	56
СӨББ	13	16	16	18	20
Эрүүл мэнд	28	28	28	28	28
Бусад	14	6	82	67	55
Хөдөлмөрийн насны хүн ам:	1804	1802	1802	1794	1789
Ажилгүйчүүдийн тоо	330	328	298	281	286
Үүнээс: эмэгтэй	167	123	167	156	159
Ажилгүйдлийн түвшин,%	23.7	23.3	21.4	20.4	20.9
Сумын өрхийн тоо	740	764	766	765	784
Ядуу	112	121	126	119	126
Нэн ядуу	136	127	115	98	92
Малтай өрхийн тоо бүгд, үүнээс:	577	571	539	502	492
50 хүртэл малтай	242	246	231	203	209
51-100 малтай	136	133	110	109	112
101-200 малтай	117	114	124	119	106
201-500 малтай	45	35	37	34	31
501-ээс дээш малтай	37	43	37	37	34
Малчин өрхийн тоо	430	429	416	402	391
Малчдын тоо	937	920	896	881	855

в. Мал аж ахуйн салбарын хөгжлийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013
Малын нийт тоо	64620	60471	53795	55535	55423
Адуу	3436	3657	3846	3718	4319
Үхэр	13115	14109	13400	12995	13474

Хонь	22188	20908	18064	18934	18877
Ямаа	25881	21797	18485	19888	18753
Цэвэр. Эрлийз малын тоо	0	0	0	0	0
Адуу	0	0	0	0	0
Үхэр	0	0	0	0	0
Хонь	0	0	0	0	0
Ямаа	0	0	0	0	0
Малын хашааны тоо	782	782	771	760	679
Бэлчээрийн усан хангамжийн хувь	75	85	90	95	100
Тэжээл бэлтгэл, тн\тэжээл нэгжээр	9890	9900	8980	9500	9053
Үүнээс: Хадсан өвс	9890	9900	8980	9500	9053

г. Газар тариалангийн салбарын хөгжлийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013
Үр тариа талбай. га	2813	2294	2294	2256	2577
Ургац. тн	3753.4	3378.5	3315.0	1355.2	2934.0
Тариалсан талбай, га	18.7	17.9	16.1	18.0	19.8
Төмс	15.3	15.3	9.7	12.1	12.4
Хүнсний ногоо	3.4	2.3	5.4	5.9	7.4
Хураасан ургац, тн	75.5	93.2	125.4	97.2	150.5
Төмс	47.2	73.8	95.2	74.1	115.0
Хүнсний ногоо	28.3	19.4	30.2	23.1	25.5

д. Орон нутгийн төсөв, сая төгрөг

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013
Орон нутгийн төсвийн орлого	41.4	34.1	62.4	55.6	79.1
Хүн амын орлогын албан татвар	1.5	2.5	1.6	2.2	2.9
Бууны албан татвар	0.4	0.4	0.5	0.5	0.6
Ойн гоожин	16.4	17.0	20.4	27.3	54.2
Газрын төлбөр	13.9	9.5	4.5	5.2	-
Ус ашигласны төлбөр	-	-	-	-	0.2
Хүү торгууль	4.6	4.7	5.6	4.3	8.9
Бусад орлого	4.6	-	29.8	16.0	12.3
Орон нутгийн төсвийн зарлага	164.8	171.4	188.3	285.6	309.8
Цалин	107.8	107.8	129.2	192.6	194.6
НДШ, ЭМД	11.8	11.8	14.2	20.8	21.4

Гэрэл цахилгаан	1.2	1.5	1.8	2.4	2.3	
Тээвэр шатахуун	9.4	10.6	14.2	15.9	18.7	
Шуудан холбоо	0.8	1.0	1.7	2.2	2.1	
Албан томилолт	3.0	3.0	3.4	6.8	5.7	
Бусад зарлага	30.8	35.7	24.8	44.9	65.7	
Төсвийн санхүүжилт	Аймгаас	129.3	117.5	165.9	218.4	227.4
	Улсын төсөв	-	-	-	-	-

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ SWOT ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
<p>Орон нутгийн онцлог, нөхцөл байдалд тохирсон шийдвэрийг холбогдох хууль журманд нийцүүлэн гаргах эрх нээлттэй</p> <p>Санхүү нягтлан бодох бүртгэл төрийн сангийн нэгдсэн системд холбогдсон</p> <p>Өндөр хурдны өргөн зурвасны шугаманд холбогдсон</p>	<p>ААН, байгууллага төвлөрсөн халаалтанд холбогдоогүй</p> <p>Хот суурин газрын төлөвлөлт хийгдээгүй</p> <p>Эрчим хүчний хангалтын хүчин чадал муу</p> <p>Гадаад харилцаа сул</p> <p>Эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангагдаж чадаагүй</p>
<p>Унаган төрхөөрөө хадгалагдаж үлдсэн байгалийн өвөрмөц тогтоц бүхий уул, гол, нуур, рашаанууд, биологийн төрөл зүйл, байгалийн нөөц баялаг сайтай үүнээс шинэс модны арвин их нөөцтэй.</p> <p>Загасны нөөцтэй</p> <p>Газар тариалан, МАА-г хослуулан эрхэлдэг</p> <p>Байгалийн хадлан бэлтгэх нөөцтэй</p> <p>Төвийн эрчим хүчний цахилгаан дамжуулах агаарын шугамтай</p>	<p>Төрийн байгууллагуудын барилга байгууламж муудаж хуучирсан</p> <p>Төрийн үйлчилгээний байгууллагуудад ажиллагсдын мэдлэг, чадвар, харилцаа хандлага сул</p> <p>Иргэдийн нийгмийн харилцаанд оролцох идэвхи муу</p> <p>ЖДҮ, үйлчилгээний хөгжил сул, эхлэлийн шатанд байгаа</p> <p>Ажилгүйдэл, ядуурал дорвитой буурахгүй, иргэдийн амжиргааны түвшин доогуур, амиа аргацаасан байдалтай</p>

<p>Суманд үүрэн телефоны 2 оператортай Багууд үүрэн телефоны жи мобайлийн сүлжээнд холбогдсон Нисэх онгоц буух хамгаалалтын зурвас газартай Дани улстай уламжлалт харилцаа, хамтын ажиллагаатай Даяндээрхи хийдийн түүхийн дурсгалт газартай Далийн цэцэг ургадаг</p>	<p>Иргэдийн ажиллах сонирхол дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс салаагүй Аялал жуулчлал хөгжөөгүй Зам харилцаа муу хөгжсөн Сүргийн бүтэц алдагдсан /хонин сүрэгт эзлэх ямааны тоо их/ Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо алдагдсан Мал эмнэлэгийн үйлчилгээ сул</p>
<p>Боломж</p>	<p>Саад бэрхшээл</p>
<p>Байгалийн үзэсгэлэн бүрдсэн газруудыг түшиглэн аялал жуулчлал спорт загас агнуур, хөгжүүлэх Гадаад харилцааг хөгжүүлэх Хадлан бэлтгэж тэжээл үйлдвэрлэх Ойн цэвэрлэгээний аргаар мод бэлтгэж, боловсруулах Арьс шир, ноосонд анхан шатны боловсруулалт хийж жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх</p>	<p>Түлш шатахууны үнэ зэргэлдээ сумдаас харьцангуй өндөр Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, өртөг өндөр Төв суурин газраас алслагдсан</p>
<p>Байгалийн жимс, жимсгэнэ бэлтгэж чанамал, дарс үйлдвэрлэх Төмс, хүнсний ногоо тариалах Улаан буудайн гурил, халтар арвайн гурил, хөц будааны үйлдвэрлэл эрхлэх Тооноос илүү чанарт анхаарсан эрчимжсэн МАА-г хөгжүүлэх Мод үржүүлэг эрхэлж зах зээлд нийлүүлэх Үхэр сүргийг өсгөх Туслах аж ахуйг хөгжүүлэх /гахай, тахиа, зөгий/</p>	<p>Усан цахилгаан станцыг засварлаж ашиглаж чаддаггүй Газрын хөрсний бүтэц хүнд шаварлаг Хот суурин газрын ашиглагдах талбайн хүрэлцээ байхгүй Худалдан авах чадвар сул, зах зээлийн багтааж бага</p>

3.2. Нутгийн удирдлагын зохион байгуулалт

СУМЫН ИТХ-ЫН ТАНИЛЦУУЛГА 2012-2016 ОН



Монгол Улсын шинэ үндсэн хуулийн дагуу 1992 оноос үүсгэн байгуулагдаж, нутгийн өөрөө удирдах ёсыг орон нутагт хэрэгжүүлэн ажилллаж ирлээ.

Тус сумын ИТХ нь төлөөллийн зарчмыг хангасан тухайн нутгийн иргэдийн өөрсдөө сонгож байгуулдаг Үндсэн хуулийн статустай Нутгийн Өөрөө Удирдах байг ууллага юм.

Сумын ИТХ-ын удирдлагын талаарх мэдээлэл: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага үүсгэн байгуулагдсанаас хойш ИТХ-ын даргаар 1992-1996 онд Д.Ренчинбямбаа, 1996-1998 онд С.Ванчиндорж, 1998-2004 онд Д.Шагдар, 2004-2005 онд Я.Эрхэмбаяр, 2005-2008 онд Д.Батхүрэл, 2008-

2009 онд Х.Очирпүрэв, 2009-2012 онд Н.Энхбаяр, 2012 оноос П.Ариунсан сонгогдон ажиллаж байна. ИТХ-ын орон тооны нарийн бичгийн даргаар 2004-2006 онд М.Батхорол, 2006-2008 онд Ц.Сосорбурмаа, 2008-2011 онд У.Гансүх, 2011 оноос Б.Эрдэнэ-Оюун нар ажиллаж байна

Тус сумын ИТХ нь 4-н байнгын хороо 7 Тэргүүлэгчтэй.

Хурлын Төлөөлөгчдийн талаарх мэдээлэл: 2012 оны аймаг, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 6 дахь удаагийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд 21 төлөөлөгч сонгогдож, үүнээс АН-аас 18 төлөөлөгч, МАН-аас 3 төлөөлөгч сонгогдсон.

- Боловсролын түвшингээр ангилбал: Дээд-10, Тусгай дунд- 2, Бүрэн дунд-6, бүрэн бус дунд-3,
- Насжилтаар нь ангилбал:20-30 нас -6, 30-40 нас -4, 40-50 нас-7, 50-60 нас-4, Хүйсээр нь авч үзвэл:эр-18, эм -3
- ИТХ-д сонгогдсон байдлаар нь авч үзвэл: 5 удаа сонгогдсон -1, 3 удаа сонгогдсон -3, 2 удаа сонгогдсон -4,

Тэргүүлэгчдийн талаарх мэдээлэл: Тэргүүлэгчдээр П.Ариунсан, А.Батболд, Б.Гансүх, Г.Батчулуун, Б.Саруул, Д.Ичинхорлоо, Я.Батганаа нар сонгогдон ажиллаж байна. Боловсролын түвшингээр нь авч үзвэл дээд боловсролтой 5, Тусгай дунд боловсролтой 2.

Хороодын талаарх мэдээлэл: ИТХ-ын дэргэд Эрх зүй нутгийн удирдлага болон өргөдөл гомдлын хороо, Төсөв санхүү эдийн засгийн хороо, ХАА байгаль орчин экологи, дэд бүтцийн хороо, Нийгмийн бодлогын хороо гэсэн хороод ажиллаж байна. Хороод эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт хийж заавар зөвлөмж өгч ажилладаг.

Багийн ИНХ-ын талаар: 5 багийн ИНХ-тай бөгөөд МУЗЗНДНТУТХ-д заасан бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулж ард иргэдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргадаг, чадварлаг ИНХ болж үйл ажиллагаагаа тогтмолжуулахын төлөө ИТХ-ын ажлын албатай нягт уялдаа холбоотой ажиллаж байна.

.Хурлын хуралдааны талаар:ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан юм. Сумын ИТХ нь МУЗЗНДНТУТ хуулинд заасны дагуу жилд ээлжит хуралдааныг 2-3 удаа хуралдуулж сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Үндсэн чиглэл, Газар зохион байгуулалт, Төсөв батлах гэх мэт асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Цаг үеийн зайлшгүй шаардлагатай асуудал гарсан тохиолдолд ээлжит бус хуралдаан зарлан хуралдуулдаг.

Алсын хараа:

Нийтлэг эрх ашигт үйлчилсэн, ил тод, тунгалаг төсөвтэй төрийн үйлчилгээг Иргэний бодитой оролцоо, сэтгэл ханамжийн түвшингээр үнэлэх боломжийг бүрдүүлнэ.

Эрхэм зорилго:

Хойморь нутгийн хийморьлог Эрдэнэбулганчуудынхаа нийтлэг эрх ашгийг дээдлэн, хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч,

эрх чөлөөт, ажилтай орлоготой иргэд бүхий байгальд ээлтэй, ногоон эдийн засагтай, аялал жуулчлал, газар тариалангаар Хөвсгөл аймагтай тэргүүлсэн жишиг сум болгоход оршино.

Сумын ИТХ-ын SWOT шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Үндсэн хуулийн статустай • Мэргэшсэн цомхон бүтэцтэй • Техник тоног төхөөрөмжөөр хангагдсан • ИТХ-ын төлөөлөгчдийн идэвхи оролцоо сайн • Насжилт залуу • Орон нутгийн онцлог тухайн нөхцөл байдалд тохирсон шийдвэрийг гаргах эрхтэй • Салбар бүрийн төлөөлөлтэй • ИТХ нээлттэй хуралддаг тул иргэд сонгогч хэн боловч санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг • Ажлын албаны үйл ажиллагаа тогтмолжсон 	<ul style="list-style-type: none"> • Жендерийн харьцаа алдагдсан • Ажлын албанд ажилтан дутмаг • Хороодын үйл ажиллагаа жигд бус • ИНХ-ын дарга нарын мэдлэг боловсрол харилцан адилгүй тул үйл ажиллагаа жигд бус • Намын бүлгүүдийн санал санаачлага сул • Мэдээллийн систем бүрэн хангагдаагүй • Цаг үеийн мэдээлэллийг хожимдож авдаг • ИТХ түүний Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хянах тогтолцоо байхгүй • ИТХ-ын мэдлэг боловсрол харилцан адилгүй
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Төсөв батлахдаа төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, хороодын үйл ажиллагааны зардлыг тусгах • Давсан орлого батлахдаа иргэдэд чиглэсэн үйл ажиллггааны зардлыг тусгах • ЗЗНДНТУТ хуулиар олгогдсон бүрэн эрх • НӨУЁБ-д иргэдийн итгэх итгэл нэмэгдэж байгаа явдал • Иргэдийн дуу хойлоог сонсож шийдвэрт тусгах, тусгуулах арга хэмжээ авах 	<ul style="list-style-type: none"> • Иргэний танхимын байрны хүрэлцээ муу, тоног төхөөрөмж байхгүй • Төсвийн төслийг харгалзахгүйгээр хайрцагласан төсөв хуваарилж батлуулдаг • Иргэдийн идэвхи санаачлага, оролцоо дутмаг • ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажиллах нөхцөл төдийлөн бүрдээгүй • ТББ-уудын үйл ажиллагаа тогтворжоогүй • ИТХ-ын Төлөөлөгчдийг ажиллуулах эдийн засгийн хөшүүрэг байхгүй • НӨУЁБ-ын бүрэн эрхийн асуудал онолын түвшингээс хэтрэхгүй байна • Цалингийн сан байхгүй • Хариуцлагын тогтолцоо байхгүй

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
-------------------------	--

БИНХ-ын дарга нарыг чадавхижуулах	Сургалт зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулна
Төлөөлөгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх	Сургалт зөвлөгөөнийг тогтмол зохиож, аар аймгийн ИТХ, МНУХ-той хамтран ажиллана
Ажлын албаны орон тоог нэмэх	Цалингийн санг төсөвт суулгаж батлуулна
Иргэдэд мэдээлэл түгээх байдал хангалтгүй	Мэдээлэл түгээх менежмент боловсруулах, санаачлага өрнүүлэх, ОНХС-ийн хөрөнгөөр мэдээлэл түгээх асуудлыг шийдвэрлэнэ
“Иргэний танхим”-ыг хүртээмжтэй байр, тоног төхөөрөмжтэй болгох	Өрөө тасалгаа, техник хэрэгсэлтэй болох талаар УИХ-ын гишүүнд хандана
Иргэдийн идэвхи санаачлага, оролцоо дутмаг	Иргэдийг идэвхижүүлэх тал дээр байгууллагын түвшинд бодлого боловсруулж ажиллана.
Жендерийн харьцаа алдагдсан	Эмэгтэйчүүдийн нийгмийн идэвхи оролцоог нэмэгдүүлнэ
ТББ-уудын үйл ажиллагаа тогтворжоогүй	ТББ-уудыг дэмжиж ажиллана
ИТХ-ын Төлөөлөгчдийг ажиллуулах эдийн засгийн хөшүүрэг байхгүй	Давсан орлогоос шийдвэрлүүлнэ

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн нийгэмд шилжиж, нийгмийн харилцаа өөрчлөгдөн, ард иргэдийн эрэлт хэрэгцээ нэмэгдэж, өмнө нь үйлчилж байсан хууль журам, дүрмүүдээр тухайн нийгмийн харилцааг зохицуулах боломжгүй болсон үед Монгол улсын үндсэн хууль 1992 онд өөрчлөгдөн батлагдаж, засаг захиргааны нэгжид өөрчлөлт орсонтой холбоотойгоор АДХ-ын гүйцэтгэх захиргаа гэсэн нэр томъёо өөрчлөгдөн, Засаг даргын Тамгын газар гэсэн нэртэй болж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага тухайн шатны хурал байхаар хуульчилж өгсний дагуу сумын Засаг даргын тамгын газрын дарга томилогдсон ч зарим албан тушаалд хуучин орон тоогоороо ажилласаар байсан байна. Тухайлбал: Үндсэн хууль батлагдсаны дараа, 1992 оны сүүлчээр тус сум:

- Засаг дарга Д.Шагдар
- Орлогч дарга Ч.Нэргүй
- Нарийн бичгийн дарга Д.Сүхбаатар
- Тамгын газрын дарга С.Эрдэнэсан
- Хөдөлмөр, нийгмийн халамжийн байцаагч Д.Ренчинбямбаа



- Орлого, улсын татварын байцаагч Я.Мэндбаяр
- Татварын байцаагч Д.Дагва
- Ня-бо М.Ганцоо
- Бичээч Р.Гантуяа
- Жолооч С.Ганбат
- Цагдаа а/ч А.Батхуяг
- Цагдаа а/ч Н.Энхтайван
- Төлөөлөгч а/х Д.Баасанцэрэн
- Галч О.Очирбаатар нар ажиллаж байжээ.

Сумын 80 жилийн ойн босгон дээр тус сумын Засаг даргын Тамгын газар нь Аймгийн Засаг даргын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/376 тоот захирамжинд заасан 14 хүний орон тоогоор ажиллаж байсан бол сумын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах энэ цаг үед доорхи орон тоотойгоор ажиллаж байна.

1. Сумын Засаг дарга Д.Батхүрэл
2. Сумын Засаг даргын орлогч Б.Эрдэнэнаран
3. Сумын ЗДТГ-ын дарга бөгөөд ерөнхий менежер М.Оюумаа
4. Төрийн сангийн мэргэжилтэн Ж.Оюунбилэг
5. ЗДТГ-ын иргэний бүртгэл, дотоод ажил, эрх зүйн сургалт хариуцсан түшмэл Х.Гэрэлтуяа
6. Газрын даамал Б.Энхмаа
7. ЗДТГ-ын ерөнхий нягтлан бодогч Х.Оюунбаатар
8. Сумын нийгмийн ажилтан А.Мөнхжаргал
9. Архив, бичиг хэргийн эрхлэгч, бичээч Р.Гантуяа
10. БОХ-ын улсын байцаагч С.Баярсайхан
11. Сумын мал эмнэлэг, үржлийн тасаг, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Ө.Батжаргал
12. МЭҮТасгийн мал аж ахуй, үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн Д.Болормаа

13. МЭҮТасгийн бэлчээр, газар тариалан, жижиг дунд үйлдвэр, хоршоо, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Э.Идэр
14. Ойн мэргэжилтэн Д.Дагва
15. Нярав, аж ахуйн ажилтан Х.Долгорсүрэн
16. Жолооч С.Ганбат
17. Галч зарлагаар Б.Түмэндэмбэрэл, улирлын чанартай галч А.Батхуяг, Р.Бат-Өлзий, үйлчлэгч Д.Даваасүрэн нар ажиллаж байна. Босоо удирдлагатайгаар Засаг даргатай гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч д/ч М.Энхболд, цагдаа а/а Б.Наранбаатар, олон нийтийн цагдаа Б.Өлзий, татварын улсын байцаагч Д.Энхцэцэг, нийгмийн даатгалын байцаагч Д.Мянган, байгаль хамгаалагч Я.Лхагваа, Н.Жавхлант, Б.Цэрэнлхам, улсын бүртгэгч Ц.Сосорбурмаа, халамжийн мэргэжилтэн М.Ганцоо, хөдөлмөрийн мэргэжилтэн Д.Анхбаяр нар ажиллаж байна.

Сумын ЗДТГазрын SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Удирдах, манлайлах чадвар сайн • Улс төрийн, төрийн захиргааны, тусгай алба, үйлчилгээний албатууд ажиллаж байгаа • Санхүү, нягтлан бодох бүртгэл төрийн сангийн нэгдсэн системд холбогдсон • 2 давхар барилгатай, олон жил ашиглах боломжтой • Мэргэжилтэй боловсон хүчнээр бүрэн хангагдсан 	<ul style="list-style-type: none"> • Интернет, цахим орчин бүрдээгүй • Нэгдсэн халаалтанд холбогдоогүй • Ажлын байрны тав тухтай орчин бүрдээгүй • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин бүрдээгүй • ЗДТГ-ын барилгад болон сантехникийн их засвар хийгдээгүй 5 жил болж байгаагаас 1-р давхарын халаалт муудсан • Босоо удирдлагатай албад, байцаагч, мэргэжилтнүүд байгаа нь ажлын давхардал үүсэх, ачааллыг жигдрүүлэхэд хүндрэл үүсгэж байна.
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Залуу боловсон хүчин нийт ажиллагсдын 50 орчим хувийг эзэлж байна. • Шилэн кабелд холбогдох • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх боломж бүрдэх • Нэгдсэн халаалтанд холбогдох 	<ul style="list-style-type: none"> • Төсөв хөрөнгийн хангалт муу • Ажлын байрны эд хогшил, тоног төхөөрөмж дутмаг

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
-------------------------	--

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчин бүрдээгүй	1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, шатыг бий болгох, төсөл хөтөлбөрт хамрагдах замаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх
• ЗДТГ-ын барилгад болон сантехникийн их засвар хийгдээгүй 5 жил болж байгаагаас 1-р давхарын халаалт муудсан	2.Их засварын төслийн боловсруулан санхүүжүүлэгч байгууллагад хандах, шийдвэрлүүлэх, засвар хийх
• Босоо удирдлагатай албад, байцаагч, мэргэжилтнүүд байгаа нь ажлын давхардал үүсэх, ачааллыг жигдрүүлэхэд хүндрэл үүсгэж байна.	3. Албадуудыг хэвтээ удирдлагад оруулах талаар холбогдох газруудад саналхүргүүлэх, гурвалсангэрээндтавих хяналтыг сайжруулах, хариуцлагын асуудлаар санал хүргүүлэх, орон нутагт шийдвэрлэх боломжоор ханган ажиллана.
• Төсөв хөрөнгийн хангалт муу	4.Орон нутгийн төсвөөр 100% санхүүждэг тул орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, далд эдийн засгийн орлого нөөцийг нэмэгдүүлэх
• Ажлын байрны эд хогшил, тоног төхөөрөмж дутмаг	5. орон нутгийн төсвийн орлого, байгууллагын санхүүжилтийг нэмэгдүүлэх
• Нэгдсэн халаалтын системд холбогдоогүй	6.Сумын нэгдсэн халаалтанд холбогдоно.
• Интенэт, цахим орчин	7. Интернэтэд холбогдсоноор дотоод сүлжээг бий болгож, ажлын цагийн хийдэгдэл, Дотоод Хяналт Шалгалтын ажил жигдэрнэ.

БӨӨРӨЛЖ БАГ

1 дүгээр багийн товч танилцуулга:

Одоогийн 1-р баг нь Өвөр ширхтэн Урианхайн нутгийг хамарсан Тарган ноён буюу Хишигжаргалын хошуунд харьяалагдаж байгаад 1931 оны засаг захиргааны өөрчлөлтөөр Эрдэнэбулган сумын 4-р баг, 1960 оны өөрчлөлтөөр МАА-н 1-р бригад, 1975-1985 онд Тариалан САА-н МАА-н 4-р ферм, 1985-1992 онд Эг-Үүрийн САА-н 1-р ферм, 1992 оноос Эрдэнэбулган сумын 1-р баг болж өөрчлөгдөж байлаа.

Тус баг нь 136 өрхтэй, 475 хүн амтай, 12973 толгой малтай, хүн амын орлогын гол эх үүсвэр нь МАА эрхэлдэг. Сүүлийн жилүүдэд иргэдийн ахуй амьдрал эрс дээшлэн сууриншиж, худалдаа эрхлэх, барилга байшин барих, тээврийн үйлчилгээ, төмс хүнсний ногоо тариалах зэргээр орлогоо нэмэгдүүлдэг болсны улмаас нийт өрхийн 95 хувь нь телевизор, 32 автомашин, 16 трактор, 75 хувь нь мотоциклтой болжээ.

Багийн төв нь сургалтын танхим, эмчийн үзлэгийн өрөө, чийрэгжүүлэлтийн танхим, соёлын төв, 2 айлын орон сууц зэрэг төрийн үйлчилгээ явуулах



тохилог байр, байшингуудтай, төрийн ажил үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжоор бүрэн хангагдсан.

Тус баг нь байгалийн баялаг ихтэй, төрөл бүрийн жимс, жимсгэнэ, эмийн болон цайны ургамлаар элбэг

баян бөгөөд өвчин эмгэгт сайн рашаан ус элбэгтэй, нэн алдартай Сонгино уулын рашаан, Цагаан уулын рашаан, бөөрөлжийн рашаанууд, мэдрэл, ходоод гэдэс, уушигний өвчинд нэн тустай. Мөн олон төрлийн амьтан, загас элбэгтэй, байгалийн үзэсгэлэнт газрууд буюу Сонгино уул, Бүрэг уул, Ацын цахир толгой гэх зэргийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газар олонтой.

Тариалангийн атаржсан 1000-аад га талбай ашиглалтгүй байдаг нутаг юм. түүхийн дурсгалт Удганы хүрээний туурь тус багийн нутагт байдаг.

Бөөрөлж багийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Иргэдийн идэвхи оролцоо сайн • Мараа, хужир шүү элбэг • Байгалийн дагалт нөөц баялаг элбэг • 	<ul style="list-style-type: none"> • Хадлангийн талбай муу • Бэлчээрийн хүрэлцээ муу • Иргэд мэдлэг боловсрол муутай • Сургалт сурталчилгаа сул-давтамжгүй, тасралтгүй бус, цогц бус • Газар нутгийн маргаан
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Байгалийн баялагийг зөв ашиглах, эзэмших • Сүү цагаан идээ боловсруулах үйлдвэрлэл • Малын үүлдэр угсааг сайжруулах • Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Зам харилцаа муу • Төрийн үйлчилгээг явуулахад нөхцөл хангамж хангалтгүй.-унаа

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
-------------------------	--

• Хадлангийн талбай муу	Инженерийн хийц бүхий худагуудыг барих, газрыг хаших, хөцөөг сайжруулах /орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, иргэдийн санаачлагаар/
• Бэлчээрийн хүрэлцээ муу	Ашиглагддаггүй бэлчээрийг ашиглах, бэлчээрийн даацаас шалтгаалан отрынхныг оруулахгүй байх
• Иргэд мэдлэг боловсрол муутай, • сургалт сурталчилгаа сулдавтамжгүй, тасралтгүй бус, цогц бус	Насан туршийн боловсролыг тасралтгүй явуулах, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр бүлгийн сургалтыг явуулах
• Зам харилцаа муу	1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Өлийн давааг засварлах 2.Зүр хүзүүний давааг /орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр, нутгийн залуучуудын дэмжлэгээр/ засварлах
• Төрийн үйлчилгээг явуулахад нөхцөл хангамж хангалтгүй.-унаа, цэцэрлэгийн байр	1.Мотоциклтой болгох /орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр/ 2.Зуны нүүдлийн цэцэрлэгийн байртай болох /орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг, иргэдийн оролцоо, дэмжлэг/

ЧИЧИН БАГ:

2 дугаар багийн товч танилцуулга

Тус баг нь 1936 онд 9 дүгээр баг нэртэйгээр одоогийн Чичин, Хувт, Өлөнт, Удган, Булган тал зэрэг нутаг хамрагдан байгуулагдаж байжээ.

1959 онд атрын САА байгуулагдаж, багийн зохион байгуулалт өөрчлөгдөн, ферм, хэсгийн зохион байгуулалтанд орж, 2 дугаар ферм нэртэйгээр ажиллах болсон байна. Анхны фермийн даргаар Ч.Бямбацогт ажиллаж, улмаар Зэрлэг, Архан буурлын нутгаас одоогийн иргэд нүүн ирж суурьшиж байв. Хэсгийн ахлагчаар Д.Тангад, У.Цэгмэд, Ц.Сосорбарам, Б.Лувсанбаяр, М.Дагвадорж, Ж.Мягмар, Г.Доржхүү, Ш.Орос нарын хүмүүс ажиллаж байжээ.

Сум, САА байгуулагдсан хугацаанд ажил үйлсээрээ бусдыгаа хошуучлан ажиллаж байсан Х.Чимиддорж /улсын хошой аварга хоньчин/, Ш.Орос /улсын аварга хоньчин/ нарын олон хүмүүсийн нэрийг дурддаж болно.

Тухайн үеийн фермийн даргаар Ч.Бямбацогт, А.Лүндэнбазар, М.Дагвадорж, Д.Ренчин, Б.Пүрэвдорж нар ажиллаж байсан ба багийн зохион байгуулалтанд эргэн орсон цагаас багийн Засаг даргаар 1986-1992 онд П.Сэнгээ, 1992-1997 онд О.Эрдэнэбаяр, 1997-2012 онд М.Лундаажав, 2012 оноос М.Эрхбаяр нар ажиллаж байна.

Энэ хугацаанд малын эмч, зоотехникч, нярав, нягтлан бодогч, холбоочин зэрэг албан тушаалд Цэрэнжав, Г.Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Аюуш, Г.Самдан, З.Цэвэг, Л.Алтангэрэл, Д.Мог, Оюунцэцэг нарын хүмүүс ажиллаж байсан байна.

Тус баг нь 440,0 км² нутагтай, 122 өрх, 449 хүн амтай, малын тоогоороо сумандаа тэргүүлдэг ба адуу 1158, үхэр 3324, хонь 7229, ямаа 5381, нийт 17092 толгой малтай бөгөөд сумын нийт малын 50 орчим хувийг эзэлдэг.

Чичин багийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Сумын төвд ойрхон • МАА, газар тариалан хосолмол • Орон нутагт хэрэгжиж байгаа ямар нэгэн арга хэмжээнд бүрэн хамрагдах боломжтой • МАА хамгийн их өсөлттэй • Багийн цэцэрлэгийн байртай • Цэцэрлэгт хамгийн олон бага насны хүүхдийг хамруулдаг 	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн нийгмийн идэвх, оролцоо муу • Малчид хэтэрхий төвлөрсөн • Бэлчээрийн даац хэтэрсэн
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Иргэдийн нийгмийн идэвх оролцоог сайжруулах • Зам гүүрүүдийг сэргээн засварлах • Малчид тариаланчдын хоорондох маргааныг шийдвэрлэх боломжтой • Бэлчээрийн зохицуулалт хийх боломжтой • Гэрэл цахилгааныг шийдвэрлэх /Чичин/ • Цагаан идээ боловсруулах цех ажиллуулах • Зам дагаж аялал жуулчлалыг хөгжүүлэх • Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх • Жишиг баг болох 	<ul style="list-style-type: none"> • Сумын төвийн модны мэргэжлийн байгууллагууд бүгд модоо авч байна. • Хавар намартаа нүүхэд зам, гүүр маш муу • Малчид тариаланчдын хооронд үүсэх маргаан, зөрчилдөөнийг зохицуулах арга замыг шийдвэрлэж чаддаггүй

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
1.Зун нь сумынхаа төвөөс алслагдсан, зам харилцаа муу	1. Чичингийн замыг засварлах 2. Гүүр /3/-ийг засварлах
2.Иргэдийн нийгмийн идэвх, оролцоо муу	Сургалт сурталчилгааг сайжруулах, давтамжийг нэмэгдүүлэх
3. Бэлчээрийн даац хэтэрсэн	Отрын айл оруулахгүй байх талаар хуулинд тусгуулах, эрх зүйн үндэслэлд санал оруулах, бэлчээрийн зохицуулалт хийх, отор нүүдэл хийх
4. Сумын төвийн модны мэргэжлийн байгууллагууд бүгд модоо авч байна.	Ойн сэргээлтэнд хяналт тавих, иргэдийн хяналт, оролцоог сайжруулах Нөхөрлөлүүдийг олноор байгуулах, ойн санг эзэнтэй болгох

4. Малчид тариаланчдын хооронд үүсэх маргаан, зөрчилдөөнийг зохицуулах арга замыг шийдвэрлэж чаддаггүй	Эрх зүйн зохицуулалтыг сурталчлан таниулах, тариаланчидтай хамтран ажиллах
5.Багийн төвийг тохижуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, иргэдийн оролцоо дэмжлэг
Жишиг баг болно	Иргэдийн оролцоо, дэмжлэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө

ЗЭРЛЭГ БАГ

3 дугаар багийн товч танилцуулга

Тус багийн нутаг дэвсгэр нь анх сум байгуулагдахад 6,7,8 дугаар багт хуваагдаж байсан бөгөөд 1960 оны үед САА-н захиргаа, нэгдлийн удирдлагыг нэгтгэн, багууд суурь, фермийн зохион байгуулалтанд ороход мал аж ахуйн 3 дугаар бригад, 1992 онд 3 дугаар баг болжээ. 1948 онд одоогийн багийн төв байгаа газарт 3 багийг хариуцсан хүний бага эмчийн салбар байгуулагдаж, Пүрэв доктор, сувилагч Д.Тангад нар ажиллаж ирсэн байна.

1960-аад оноос бригадын төв Зэрлэгийн голд төвлөрч бага эмчийн салбар агент, контор, улаанбулан, агуулах, сүү, тосны завод, холбооны шугам, дизель станц, халуун ус, багийн хариуцлагатны байр гээд төвлөрсөн жишиг багийн төв байснаа сүүлийн жилүүдэд ихэнх барилга байгууламжийг Хирвэстэйн хилийн заставын төв рүү нүүлгэн шилжүүлсэн байна. Одоогоор багийн улаан буланг засварлан, эмчийн үзлэгийн байрыг шинээр барьж, ашиглаж байна.

3 дугаар баг нь одоогийн байдлаар 105 өрхтэй, 376 хүн амтай, адуу 823, үхэр 3372, хонь 2399, ямаа 1684, бүгд 8278 толгой малтай, аймгийн төвөөс 296, сумын төвөөс 56 км алслагдсан, хойд талаараа Цагаан-Үүр сум, зүүн талаараа ОХУ, өмнө талаараа Тариалан, Булган аймгийн Тэшиг сумдтай хиллэн оршдог. Эрдэнэбулган сумын нутаг дэвсгэрийн 50 орчим хувийг эзлэн оршдог баг юм. Хүн амын хувьд харуулууд буюу халх үндэстнүүд голлон суурьшжээ.

Зэрлэг багийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Байгалийн нөөц баялаг /ой, ан, самар жимс, ургамал/ ихтэй • Хөдөлмөрч • Хадлан тэжээл бэлтгэх талбай сайтай • Байгалийн үзэсгэлэнт болон дурсгалт газар нутагтай • Жуулчны бааз, отогтой 	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн идэвхи оролцоо муу • Хүйсийн тэнцвэрт байдал алдагдсан • Төвлөрсөн газраас хэтэрхий хол, алслагдсан
Боломж	Саад бэрхшээл

<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалыг хөгжүүлэх / байгалийн болон спорт, загас агнуур/ • Байгалийн баялагийг зүй зохистой ашиглах 	<ul style="list-style-type: none"> • Зам харилцаа муу • Алслагдсан • Томоохон голын цаана оршдог, зун, хавар намрын зорчиход хэцүү • Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс хараат
---	---

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Завьчны цалин	Багийн ИНХ-р хэлэлцэж, үнэ тарифыг тогтоох, зохицуулалт хийх
Зэрлэг, Бургалтайн голуудад гүүр барих	ОНХ-ийн сангийн хөрөнгө, олон нийтийн иргэдийн санал санаачлага, оролцоо, дэмжлэг
Багийн төв дээр цэцэрлэгийн байр байхгүй	Иргэдийн оролцоо, орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэг

ДУУРГА БАГ: ТАНИЛЦУУЛАГА

Тус баг нь 1959 онд Эг-Үүрийн САА-н төв болсон бөгөөд 1985 оноос хойш Эрдэнэбулган сумын төв, 1992 оны шинэ үндсэн хуулиар засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжид өөрчлөлт орсоноор 1993 онд Дуурга буюу 4-р баг болгосон.



Тус баг нь Эгийн голын эрэг дагуу Дуургын нурууны ар хормойд Хүрэн уулын зүүн урд байрладаг. Далийн ягаан цэцэг, Дани хад, Хагархай толгой Эгийн гол, зэрэг байгалийн үзэгслэнт тогтоцтой, жимс жимсгэнэ, цэцэг ногоогоор арвин гадаад дотоодын жуулчдын сэтгэлийг татсан ХАА, газар тариалан, АЖ-ыг хослуулан хөгжүүлсэн бахдам сайхан нутаг юм.

Багийн засаг даргаар 1993-1994 онд А.Эрдэнэбилэг, 1994-1996 онд М.Өлзийсайхан, 1996-2004 онд А.Ганбаатар, 2004-2008 онд Д.Эрдэнэчимэг, 2008-2012 онд М.Ганбаатар, С. Дэлгэрдалай нар, 2013 оноос Б.Түвдэндорж иргэдэд төрийн үйл ажиллагааны шударга, ардчилсан, хууль дээдлэх, ард түмэнд үйлчлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж байна.

2013 оны эцсийн байдлаар 340 өрх, 1201 хүн амтай ба 4818 толгой малтай. Үүнээс адуу- 374, үхэр- 1707, хонь-1226, ямаа- 1511 байна. Ихэнх өрхүүд нь сумын төвдөө төвлөрөн суудаг, төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон, ЗДТГ, ЕБС, СӨБ, ЭМТ, Хилийн цэргийн дугаар застав, ус цаг уурын станц, Эг-ийн голын усан цахилгаан станц, газар тариалангийн компаниуд, арилжааны ХААН болон Төрийн банк, халуун ус, аялал жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээний байгууллага төвлөрөн үйл ажиллагаагаа явуулж байна.

Дуурга багийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Төрийн болон төрийн бус байгууллагууд төвлөрсөн • Интернет орчин бүрдэж цахимд холбогдож шинэ техник технологи нэвтэрч эхэлж байгаа • Хүн амын 40 хувь нь суурьшсан • Байгаль экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнтэй 	<ul style="list-style-type: none"> • Төрийн болон хувийн хэвшлийнхний үйлчилгээний чанар хүртээмж, харилцаа муу • Иргэдийн санхүүгийн чадвар сул • Төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй ч төсөл хийх аргаа мэддэггүй • Халамжийн үйлчилгээг хүссэн, бэлэнчлэх сэтгэлгээтэй • Эрчим хүчний хангамж муу • Зам харилцаа хүнд
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Байгалийн үзэсгэлэнт газар нутагтай • Аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой • Төрөл бүрийн үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих бүрэн боломжтой • Сумын төвийн тохижилтийг сайжруулах, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх • Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнг тохижуулах • Мал нядлах, мах хадгалах цэгтэй болох 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн гамшигт үзэгдлүүд • Бизнесийн зээлийн хүү өндөр • Иргэд нийгмийн идэвх сул

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
<ul style="list-style-type: none"> • ААН иргэд ТБ –уудын хамтын ажиллагаа муу /дэмжлэг дутмаг/ 	<ul style="list-style-type: none"> • Иргэд болон боловсон хүчинг чадваржуулах
<ul style="list-style-type: none"> • Хөрш ОХУ-ын Буриадтай мөн Дани улстай уламжлалт харилцаагаа сэргээх 	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа оюутан солилцох, мэргэжилтэн бэлтгэх
<ul style="list-style-type: none"> • Байгальд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Экологийн цэвэр нутгийн брэндтэй болно.

• Ундны усны хангамжийг сайжруулах	• Гүнийн ундны усны худагтай болсон байна.
• Иргэдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулах	• Сумы иргэдийг орон сууцжуулж, эпотекийн зээлд хамруулах
• ААН иргэд ТБ –уудын хамтын ажиллагаа муу /дэмжлэг дутмаг/	• Иргэд болон боловсон хүчинг чадваржуулах
• 3 хороонд хүүхдийн тоглоомын талбайг байгуулах	• Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, иргэдийн оролцоо, дэмжлэг
• “Иргэндээ ээлтэй баг” болох	• Багийн Засаг даргын идэвх, санаачлага, иргэдийн оролцоо, дэмжлэг, хандлага

УДГАН БАГ:

5 дугаар баг

1994 онд 40 орчим өрхтэй, 2000 гаруй толгой малтай, “Удган” баг шинээр зохион байгуулагдаж, багийн Засаг даргаар Дагсангийн Зоригоо ажиллаж байв. Үүнээс өмнө Бөөрөлжийн нэгдүгээр фермд харъяалагдаж байжээ.

Багийн төв анх Сэрүүний голын Богочийн аманд 6х12 хэмжээтэй нэг байшин барьж төвхнөж байсан ба дараа нь Удганы Нарийны аманд зөөж аваачин тохижуулсан бөгөөд 2006 онд Сэрүүний Бүрхээрт гэдэг газар 6х9 хэмжээтэй байшин барьж, өвлийн төв болгон, одоо энэ хоёр төвдөө багийн иргэдийн хурал, цуглаан хийж, урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг юм.

Одоо тус баг нь 78 өрх, 291 хүн амтай, 13400 толгой малтай, 45 сая төгрөгийн хөрөнгөтэй бөгөөд гүний худаг 3, гар худаг 6 ашиглагдаж байна.

Удган нутгаас Боловсролын яамны дэд сайд асан Б.Дамдинсүрэн, АБТА багш Н.Даваадулам нарын эрдэм боловсролтой хүмүүс, П.Жамц, М.Мөнхбат, Т.Эрдэнэбат, С.Хандаахүү, М.Мөнх-Очир, Б.Самданжав, Р.Батсайхан зэрэг сайн малчид төржээ. Мөн П.Жамц, Ж.Нямдорж, М.Гүнтэвсүрэн нарын нутаг усандаа сайн гэгдэх анчид энэ цагт амьдарч байна.

91 настай Н.Нансалмаа, 80-аад насыг зооглож буй Д.Базаргүр, Д.Долгор, П.Норжинсүрэн, М.Орос нарын настан буурлууд амьдарч, үр ач, нутгийн зон олондоо түшиг нөмөр болж, үг сургаалиа хайрлан суудаг билээ.

Манай нутагт Удганы Дамчааравжаалин хийдэд шавилан сууж байсан Г.Дарамрагчаа, түүний эгч Удган ажаа зэрэг мэргэ төлөг тавьж, уул овоогоо аргадан тахидаг, өвдөж зовсон олонд тустай, ид шидтэй хүмүүс ч олон байжээ.

Тус багийн Засаг даргаар Д.Зориг, Сэнгэ, М.Мөнх-Эрдэнэ нар ажиллаж байсан ба 2005 оноос Д.Билэгдэмбэрэл, 2012 оноос М.Мөнх-Эрдэнэ ажиллаж байна.

Удган багийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Аймгийн төвд ойрхон • Газар нутаг нь орон нутгийн чанартай зам дагуу байрладаг • Байгалийн нөөц баялаг ихтэй 	<ul style="list-style-type: none"> • Газар нутгийн маргаан • Бэлчээрийн даац хэтэрсэн • Холбоо харилцаа муу • Зам , даваа ихтэй • Мэдээллийн хүртээмж муу, суваг цөөн • Сүргийн бүтэц алдагдсан • Төрийн үйлчилгээг нэгжид хүргэх ажил сул
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Мал сүргийн үүлдэр угсааг сайжруулах • Бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлд ойрхон • Ойн санг малчны нөхөрлөлүүдэд гэрээгээр эзэмшүүлэх, ашиглуулах 	<ul style="list-style-type: none"> • Гадны хүмүүс байгалийн баялаг ашигладаг • Үйлдвэрлэл явуулах технологийн талаар ойлголт муу

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Газар нутгийн маргаан	
Бэлчээрийн даац хэтэрсэн	Отор нүүдэл хийх, малын чанарыг сайжруулж, тоог цөөлөх
Холбоо харилцаа муу	Дахин дамжуулах станцыг байрлуулах
Зам , даваа ихтэй	Удган давааг засварлах
Мэдээллийн хүртээмж муу, суваг цөөн	
Сүргийн бүтэц алдагдсан	
Төрийн үйлчилгээг нэгжид хүргэх ажил сул	

Эдийн засаг, салбаруудын хөгжил

Эдийн засгийн салбар

Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуйг үр ашигтай хослуулан хөгжүүлэх асуудлыг хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж үзнэ.

Орон нутгийн байгалийн болон бусад нөөцөд суурилсан аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэлийг сумын хөгжилд чухалчилна.

Сумын эдийн засгийн салбарын хөгжлийг хангахад төсөвт байгууллага 7, аж ахуйн нэгж байгууллага 36, хувиараа хөдөлмөр эрхлэгч 41, малчин 391 өрх голлох үүргийг гүйцэтгэж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

ГАЗАР ТАРИАЛАН


Тус сумын эдийн засгийн үндсэн үйлдвэрлэл ХАА-н салбар бөгөөд үүнээс газар тариалангийн үйлдвэрлэл нь 1959 оноос эх үүсвэр нь тавигдаж 55 жилийн түүхэн замыг туулсан, атрын анхны 10 САА-н нэг бөгөөд 1980-аад оны сүүлч хүртэл амжилттай хөгжиж ирсэн билээ. Эрдэнэбулган сум Эг-Үүрийн САА нь 6013 га эргэлтийн талбайтай 2934 мянган тн үр тариа хураан авч бусад аймаг сумдыг гурил, малын тэжээлээр хангаж байсан томоохон аж ахуй байсны дээр, улсын ургацын хошой болон аваргууд олноор төрөн гарсан улсын хэмжээний тэргүүлэх зэргийн аж ахуй байсан болно. 1990-ээд оноос 2000 оныг хүртэл хугацаанд уг салбар ерөнхийдөө уналтанд орсон нь уг аж ахуй нь олон хуваагдсан, мэргэжилтэй боловсон хүчин, удирдлагын арга барил доголдсон, санхүү эдийн засгийн хүчин чадал муудаж техник технологи хоцрогдсоны дээр байгаль цаг агаарын тааламжгүй нөхцлүүд нөлөөлж газрын үржил шим муудсан зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байв. 2000 оноос хойш газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхтэй холбогдсон төрийн бодлого аажмаар сайжирч, олон төсөл, хөтөлбөр хэрэгжиж банк санхүүгийн болон зээл, лизингийн үйл ажиллагааг явуулж байгаа нь уг салбарыг хөгжихөд бодит үр дүнгээ өгч байна. 2008 онд Монгол улсын засгийн газраас газар тариалангийн салбарыг хөгжүүлэх Атрын III аяныг зарлан улс орон даяар бодлогын чанартай олон томоохон ажлууд зохион байгуулж явуулсан нь тариаланч, механикжуулагчдын эрч хүч урам зоригийг сэргээн, уг үйлдвэрлэл дахин хөл дээрээ босон хөгжих хөрс суурь тавигдсан болно. Тус сум сүүлийн жилүүдэд газар тариаланг сэргээн хөгжүүлэх, олон талт арга хэмжээг төрийн бодлогын хүрээнд төр засгийн болон төсөл хөтөлбөрийн шугамаар авч хэрэгжүүлснээр жилээс жилд тариалах талбай, га-н ургац нэмэгдэж, ард иргэдийн өсөн нэмэгдэж буй хүнсний хангамж сайжирч, ажилгүйдэл, ядуурал зохих хэмжээгээр буурч байна.

Нийт ургац-3319,5

Газар тариалангийн үйлдвэрлэлийн өнөөгийн байдал

Нийт ургац графикаар:

1. 2013 онд 2577 га-д үр тариа, 19,8 га-д төмс хүнсний ногоо, 165-н га-д малын тэжээлийн олон наст тариалж 1 га-с дунджаар 12 цн үр тариа, 78,8 цн төмс хүнсний ногоо хураан авч сумын иргэдийн



- хүнсний хэрэглээг дотооддоо хангах таатай нөхцөл бүрдэж атрын 55-н жилийн ойгоо хөдөлмөр бүтээлийн амжилтаар угтан авсан
2. Газар тариалангийн үйлдвэрлэлд 5-аас дээш жил ажилласан 100 гаруй механикжуулагч, дээд мэргэжлийн ХАА-н инженер 10, агрономич 4, тусгай дунд боловсролтой механик 6, агротехникч 7, гидротехникч 4, сангийн аж ахуй, компанийн дарга, захирлаар ажиллаж байсан 8 хүн байна.
 3. Тус суманд СК-5 комбайн 13, foton guesen комбайн 1, ДТ-75 трактор 3, дугуйт трактор 32 , ХАА-н төрөл бүрийн машин механизм байгаагийн дийлэнх нь буюу 80 % нь 1989 оноос өмнө ирсэн ашиглалтын хугацаа дууссан цаашид өнөөгийн шаардлагыг хангаж ажиллах техник эдийн засгийн нөхцөлгүй болсон.
 4. Энэ судалгаанаас гарсан дүгнэлтээр цаашид нэгжээс авах ашиг шимийг дээшлүүлэхийн тулд эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэн цаг агаарын нөхцөлд тохируулан үрийн сортыг сонгон тариалахаас гадна тэжээлийн ургамал тариалан орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай

Газар тариалангийн салбарын SWOT шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<p>Үржил шим сайтай хөрстэй Олон жилийн туршлагатай Орон нутагтаа тарьсан хүнсний ногоог хэрэглэх сонирхолтой</p>	<ul style="list-style-type: none"> • Хүнд шаварлаг хөрстэй • Хүний нөөцийн бодлого алдагдсан • Үрийн бодлого алдагдсан • Хөрөнгө санхүүгийн чадваргүй • Агуулах зоорьгүй • Цахилгааны хангамж муу • МАА, ГТ салбар зохицуулалт байхгүйгээс зөрчилддөг • Жимс жимсгэний аж ахуй хөгжөөгүй
Боломж	Саад бэрхшээл
<p>Тэжээлийн ургамал тарих Эрчимжсэн МАА-тай хослуулах Төр бодлогоор дэмжиж байгаа Жимсний мод тариалах Хүний нөөцийг бэлтгэх</p>	<ul style="list-style-type: none"> • Цаг агаарын тааламжгүй нөхцөлтэй • Банкны зээл өндөр хүүтэй хугацаа богинотой. • Шилмэл сортын үр тариалах боломжгүй

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
МАА, ГТ салбар зохицуулалт байхгүйгээс зөрчилддөг	Хөцөө барих, малчид, тариаланчдын уулзалт зохион байгуулах
Цахилгааны хүчин чадал муу	Дэд өртөө барина.


Техник технологи хоцрогдсон	Техникийн шинэчлэл хийнэ. / хор шүршигч / Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх Ногоо даршлах
Хүний нөөцгүй	Мэргэжилтэн бэлтгэнэ
Үрийн бодлого алдагдсан	Үрийн бодлоготой болно / халтар арвай, богино болцтой улаан буудай, санте төмс, эрт ургацын ногоо тариалах /
Хөрөнгө санхүүгийн чадвар сул	Зээлээр дэмжинэ
Агуулах зоорьгүй	“Зоорь” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ
Банкны зээл өндөр хүүтэй хугацаа богинотой.	Холбогдох байгууллагад уламжилна.
Жимс жимсгэний аж ахуй хөгжөөгүй	Жимсний мод тариалах, боловсруулах

МАЛ АЖ АХУЙ:

Эрдэнэбулган сум нь 2013 оны байдлаар 55423 толгой мал, 391 малчин өрх , 502 малтай өрх байна.

Малын төрөл	2010	2011	2012	2013
Малын нийт тоо Үүнээс	54525	53795	55535	55423
Адуу	3110	3846	3718	4319
Үхэр	11940	13400	12995	13474
Хонь	18923	18064	18934	18877
Ямаа	20552	18485	19888	18753

Малын өсөлт графикаар үзүүлэхэд:



Сүргийн бүтэц графикаар:

- Малын зүй бус хорогдол 1504, үүнээс халдварт өвчнөөр 86 толгой мал хорогдсон ба нийт хорогдлын 90 хувь нь листериоз өвчнөөр хорогдсон байна.
- Нийт төллөсөн хээлтэгч нь 17505 толгой мал, үүнээс гарсан төл нь 17505, хорогдсон төл нь 427, бойжсон төл 17078


толгой мал байна.

- Малын өсөлтийн графикаас үзвэл, малын тоо дүнгээрээ тогтвортой өссөн Үүнээс бод малын өсөлт тогтвортой аажмаар өсч байна. Бог малын өсөлт 2012 -2013 онд шилжих өвөл зуд болсонтой холбоотой буурсан байна.
- Өнгөрсөн 2013 онд нийт 23463 хээлтэгч малаас төл авах төлөвлөгөөтэй байсан боловч цаг агаарын хүндэрлээс шалтгаалан 17505 эх мал буюу 74,8 хувьтай төлөлсөн байна.
Үүнээс: бойжсон төл хүснэгт, графикаар



Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он
Унага	102	549	739
Тугал	1292	2918	3744
Хурга	4331	5624	6900
Ишиг	4513	5651	5695
Нийт төл	10238	14742	17078

Одоогийн байдлаар бэлчээрийн даац 62,6 хувьтай /бэлчээрийн даац байгаа малдаа харьцуулахад 37.4%-аар хэтэрсэн/ байна. Цаашдаа малын өсөлт энэ хэвээр үргэлжилбэл бэлчээрийн ачаалал үлэмж нэмэгдэх төлөвтэй байна.



2013 онд байгалийн хадлан, тэжээл бэлтгэлийн хэмжээ 9053 тн өвс, 132,5 тн ногоон тэжээл, сумын нөөцөд 269 тн өвс тус тус бэлтгээд байна.

Энэ бүх байдлаас уламжлалт бэлчээрийн мал аж ахуйг энэ хэвээр үргэлжлүүлэх нь цаг агаар хүндэрсэн нөхцөлд ихээхэн эрсдэл дагуулж магадгүй гэсэн дүгнэлт хийж байгаа юм.

Иймд бэлчээрийн даац хүрэлцээгүй болсон нөхцөл байдал, хүн ам төвлөрсөн сумын төвийн ойролцоо байршил, газар тариалан эрхлэх дадлага туршлагадаа тулгуурлан мал аж ахуйг эрчимжүүлэх, сүү, махны үхэр, ашиг шим сайн бог мал, хурдан удмын адуу, гахай, тахиа, шувуу зэрэг

туслах аж ахуйг хөгжүүлэх явдлыг мал аж ахуйн талаар баримтлах гол чиглэл гэж үзэж байна.

Энэ зорилтыг хангахын тулд орон нутгийн удирдлагын зүгээс мал аж ахуйг эрчимжүүлэх бодлого зөвлөмж боловсруулах, сайн чанарын хээлтүүлэгчээр хангах ажлыг зохион байгуулах, бэлчээрийн хүрэлцээ, усан хангамжийг нэмэгдүүлэхэд хүчин чармайлт гаргах нь чухал байгаа билээ.

Мал аж ахуйн салбарын SWOT шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Байгалийн хадлан сайн ургадаг. • Мэргэшсэн туршлагатай малчинтай • Үхэр сүрэг ихтэй 	<ul style="list-style-type: none"> • Өвчний голомттой • Мал аж ахуй бүтээгдэхүүний борлуулах нэгдсэн цэг байхгүй • Мал нядалгааны цэг байхгүй • Нэг малаас авах ашиг шим муу • Борлуулалт муу • Бэлчээрийн даац муу • Малын түүхий эд боловсруулах үйлдвэргүй • МAA-н мэргэжилтэн дутмаг
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Туслах аж ахуй хөгжүүлэх боломжтой • Төрийн бодлогоор дэмждэг • Бэлчээрийн мал аж ахуйг суурин маллагааны арга ажиллагаанд шилжүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Зах зээлээс алслагдмал • Цаг агаарын эрс тэс уур амьсгалтай • Хулгай ихтэй • Өвөл усаар дутагддаг

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Өвөл усаар дутагддаг	Гүний худаг гаргана.
Халдварт өвчний голомттой	Ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж, вакцинжуулна.
Мал аж ахуй бүтээгдэхүүн борлуулах нэгдсэн цэг байхгүй	Бодлогоор дэмжиж, нэгдсэн цэгтэй болно.
Мал нядалгааны цэг байхгүй	Нэгдсэн цэгтэй болно.
Малын ашиг шим муу	Сайн үүлдрийн хээлтүүлэгч авна. / Дархадын ууцан сүүлт хонь, Эрчмийн ямаа, Сүхбаатарын адуу, Сэлэнгийн халзан үхэр / Зохиомол хээлтүүлэг хийнэ. / Гефард / Фермерийн аж ахуйг хөгжүүлнэ Туслах аж ахуйг хөгжүүлэх / гахай, тахиа /
Борлуулалт муу	Бүтээгдэхүүний сав, баглаа, боодлыг сайжруулж гадагш нь нийлүүлнэ.

Хулгай ихтэй	Малчдын бүлэг байгуулна.
Цаг агаарын эрс тэс уур амьсгалтай	Тэжээлийн үйдвэртэй болно.
Бэлчээрийн даац муу	Тэжээлийн ургамал тариална. Отор нүүдэл хийнэ
Малын түүхий эд боловсруулах үйлдвэргүй	Анхан шатны боловсруулах үйлдвэртэй болно.
МАН-н мэргэжилтэн дутмаг	Малын эмч, мал зүйч мэргэжилтэн бэлтгэнэ

Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил:

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ:

Тус суманд анх 1933 онд” Ардын хувь нийлүүлсэн хоршоо ” нэртэйгээр худалдааны байгууллага үүсэн байгуулагдсан. Анхны даргаар нь Содовын Дагвадорж ажиллаж байв. Ардын хувь нийлүүлсэн хоршооноос эхлэлтэй Худалдаа бэлтгэлийн анги нь 1992 оны үед хувьчлагдан задарч гүйцэтгэж байсан үүргийг нь хувийн үйлдвэр, дэлгүүрүүд, ченжүүд гүйцэтгэх болоод 20 гаруй жил болжээ

М а н а й
с у м а н д
о д о о г и й н
б а й д л а а р
д а р а а х
г а з р у у д
х у д а л д а а
ү й л ч и л г э э н и й
ч и г л э л э э р ү й л
а ж и л л а г а а г а а
я в у у л ж б а й н а.
Ү ү н д: Х ү н с н и й
д э л г ү ү р - 1 8,
Б а р а а н ы



д э л г ү ү р - 3, З о о г и й н г а з а р - 2, А в т о с э л б э г - 2, б а р и л г ы н м а т е р и а л ы н д э л г ү ү р
- 1, Б и ч и г х э р г и й н д э л г ү ү р - 1, М а л э м н э л э г - 2, Ү с ч и н - 1, Х а л у у н у с - 1, Д у г у й
з а с в а р - 2, Э м и й н с а н - 2, К о м ь п ю т р ы н ү й л ч и л г э э - 1, Г э р а х у й н ц а х и л г а а н
х э р э г с л и й н з а с в а р - 1, А р ь с ш и р, ц а г а а н и д э э х у д а л д а н б о р л у у л а х ц э г - 3,
О ё д о л з а х и а л г а ү й л ч и л г э э - 2, Ш Т С т а н ц - 1 г а з р у у д ү й л а ж и л л а г а а я в у у л а ж
б а й г а а г а а с а р х и х у д а л д а н б о р л у у л а х 7, т а м х и х у д а л д а н б о р л у у л а х 4 ц э г
т у с г а й з ө в ш ө ө р ө л т э й г э э р ү й л а ж и л л а г а а я в у у л ж б а й н а.

Энэ салбарт ажиллаж байгаа иргэд нь өөрөө өөртөө ажлын байрыг бий болгохоос гадна сумынхаа хөгжил дэвшилд ихээхэн хувь нэмэр оруулан ажиллаж байна.



Худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа газрууд хүнс болон бараагаа Улаанбаатар хот, Мөрөн, хилийн дээс алхан Хятад ард улсын Бээжин, Эрээн хотоос бараагаа татан сумынхаа ард иргэдийн

хэрэгцээнд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулан өргөжин тэлсээр байна.

Эдгээр худалдаа үйлчилгээний газруудаас олон жил амжилттай ажиллаж байгаа газруудыг нэрлэвэл: Наранмандал дэлгүүрийн эзэн Я.Юра 1991, Тэнгэр - Бямбасүрэн 1995, Марал - Я. Сүхчулуун, Далай ээж – Доржхүрэл, Д. Эрдэнэчимэг 1998, Одод- М.Амаржаргал 1999 оноос эхлэн тогтвор суурьшилтай олон жил үйл ажиллагаагаа тасралтгүй эрхэлсээр байна.

Анх худалдаа үйлчилгээ эрхлэгчид хамтарч 2009 онд “Худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн холбоо” байгуулж, М.Амаржаргал холбооны даргаар ажиллаж байсан бөгөөд 2013 оноос Я.Сүхчулуун даргаар нь ажиллаж холбооны хүрээнд дараах “Уриалга”, “Зорилго” – ыг дэвшүүлэн ажиллаж байна.

Уриалга: “Та бидэнд ханд. Бид танд шинэлэг бүхнээр үйлчлэх болно”

Зорилго: Сум орон нутгийнхаа амьдрал ахуй, хэрэгцээнд тулгуурласан эрүүл, аюулгүй, цэвэр тав тухтай орчинд тансаг хэрэглээгээр үйлчлэх болно.

Худалдаа, үйлчилгээний салбарын **SWOT шинжилгээ:**

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Сургалтанд хамрагдсан • Ажлын арга барил, дадлага туршлагатай • Зээлийн хэмжээ нэмэгдсэн, хугацаа урт • Хэрэглэгч олон /сэлбэг, барилгын материал, лизинг/ 	<ul style="list-style-type: none"> • Алслагдмал, өртөг өндөр • Зам харилцаа муу • Нэгдсэн халаалтгүй • Цэвэр усны хангамж муу • Мэргэжилтэн дутмаг • Бараа татах тээврийн хэрэгсэлгүй • Иргэдэд зээлээр үйлчилдэг • Тохижилт муу • Дэвшилтэт техник хэрэгсэлгүй • Цайны газар, зочид буудал цөөн
Боломж	Саад бэрхшээл

<ul style="list-style-type: none"> • Зээлд хамрагдах боломжтой • Харилцаа хандлагаа өөрчлөх • Соёлтой үйлчилгээг нэвтрүүлэх • Худалдааны бөөний төв байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Тээврийн хөлс өндөр • Арилжааны банкны зээлийн хүү өндөр • Хувь хүн тендерт оролцох эрхгүй. • Хэрэглэгч цөөн, худалдан авах чадвар муу
---	---

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Эрүүл ахуйн болон үйлчилгээний стандарт хангадаггүй	Гүний худаг гаргана. Мэргэжил арга зүйгээр хангана
Цахилгааны хүчин чадал муу	Дэд өртөө барина.
Энгийн галлагаатай	Нэгдсэн халаалтанд холбоно.
Мэдээ мэдээлэлээр дутмаг	Интернетэд холбогдоно.
Орчины тохижилт муу	Гудамж талбайн гэрэлтүүлэгтэй болно.
Согтууруулах ундааг зөвшөөрөлгүй зарж байна.	Мэдээлэл авч хяналт шалгалтыг сайжруулна
Гэмт хэрэг зөрчил ихтэй	Камержуулна
Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ хууль журам зөрчиж байна.	Сурталчилна.
Зам харилцаа муу	Зам давааг засна.
Санхүүгийн чадамж сул	Зээл ,Төсөл хөтөлбөрт хамруулна.
Тээврийн хөлс өндөр	Зам давааг засварлана.
Арилжааны банкны зээлийн хүү өндөр	Холбогдох байгууллагад уламжилна.
Хэрэглэгч цөөн	Гадагш тээвэрлэнэ. / сав, баглаа, боодлын нь сайжруулах /
Цайны газар, зочид буудал цөөн	Зээлээр дэмжинэ

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

Манай сумын хувьд МАА хөгжүүлэхээс гадна мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, мод модон эдлэл, гурил гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл түлхүү хөгжих боломжтой юм. Тус суманд ЖДҮ-лэл эхлэлийн шатандаа байна. Иймд сумаас ЖДҮ-ийн цар хүрээг өргөтгөх, орон нутгийн эдийн засгийн боломж, түүхий эд, ажиллах хүчний нөөцөд тулгуурлан ирээдүйд үр ашгаа өгөх, зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөтгөх, шинээр байгуулах замаар ЖДҮ-ийг хөгжүүлэх, орон нутгийн бренд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. ЖДҮ-лэлийн чиглэлээр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, мужаан, сүүн бүтээгдэхүүн, ааруул үйлдвэрлэгч, хатуу, зөөлөн оёдлын

үйлчилгээ эрхлэгчид, эсгий урлалын үйлдвэрлэгч тус тус ажиллаж байна. Тэдний үйл ажиллагаанаас товч танилцуулья.

Талх, нарийн боов: Талх, нарийн боовны 7 цех үйл ажиллагаа явуулж, сүүн бүтээгдэхүүн, ааруул үйлдвэрлэгч – 9, сумын иргэд болон гал тогоо бүхий газрууд, сургуулийн “Үдийн цай” хөтөлбөр зэрэгт гэрээгээр нийлүүлэн гурилан бүтээгдэхүүнээр ханган ажиллаж байна. Сумын ИТХ-аар тэргүүлэх чиглэлээ тодорхойлон сум хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон бусад төсөл хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээл олгох зэргээр дэмжлэг үзүүлж байна.

Модны үйлдвэр: Суманд хөрөө рам 8, мод үржүүлэгийн талбай-6, мужаан-5 ажиллаж байна.

Ахуйн үйлчилгээ: Монгол дээл, гутал, өвөл зуны гутал, төрөл бүрийн загварын хувцас, эсгий зарим төрлийн төмөр, модон эдлэл гэрийн нөхцөлд үйлдвэрлэж байна.

Бусад үйлчилгээ, Халуун ус 1, үсчин 1, цахилгаан гагнуур 5, авто машин засвар 2, дугуй засвар 4 ажиллаж байна.

Сумын зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг авч үзвэл дараах байдалтай байна.

Салбар, төрөл 2012 он		Нийт бүтээгдэхүүн, сая.төг			Нийт борлуулалт, сая.төг		
		2013 он	Өсөлт, бууралт	2012 он	2013 он	Өсөлт, бууралт	
Мах, махан бүтээгдэхүүн	ТН	1977350.0	2261190.0	13204.0	1977350.0	2261190.0	283840.0
Арьс шир	ш	45248.0	58452.0	13204.0	45248.0	58452.0	13204.0
Ноос, ноолуур	ТН	404722.0	435969.2	44446.1	404722.0	435969.2	31247.2
Будаа	ТН	447216.0	523479.0	76263.0	495000.0	523479.0	473979.0
Төмс, хүнсний ногоо	тн	60390.0	100500.0	40110.0	12300.0	21000.0	8700.0
Зүсмэл	М2	18705.3	33049.6	14344.3	18705.3	33049.6	14344.3

Манай суманд суудлын авто машин 136, ачааны авто машин 128, пад трактор агергатын хамт 84, мотоцикль 350 гаруй байдаг бөгөөд 2013 онд зорчигч эргэлт, тээвэрлэсэн зорчигч, тээврийн орлого өмнөх онтой харьцуулахад 10.3%-20.5%-иар нэмэгдэж, тээвэрлэсэн ачаа 18.8%-иар буурсан байна

Үзүүлэлт	2012 он	2013 он	өсөлт, бууралт
Зорчигч эргэлт /мян.хүн/км/	98,0	122,0	
Тээвэрлэсэн зорчигч /мян.хүн/			

Тээвэрлэсэн ачаа /тн/	1584	1678	
Тээврийн орлого /сая.төг/			

Жижиг, дунд үйлдвэрлэлийн SWOT шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Тэжээлийн үйлдвэр эрхэлж байсан туршлагатай • Төрөөс үзүүлж буй урамшуулалд хамрагдах • Ард иргэдээ экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах • Байгалийн нөөц баялаг ихтэй • Төвлөрсөн эрчим хүчинд холбогдсон • Хөдөлмөрч • 	<ul style="list-style-type: none"> • Техник технологи хуучирсан, дутагдсан • Зам харилцаа муу • Мэргэжилтэй хүний нөөц дутмаг • Хэрэглэгч цөөн • Мэдээ мэдээлэл дутмаг • Хөрөнгө санхүүгийн чадамж сул • Цахилгаан хангамж муу • Нэгдсэн халаалтгүй • Үйлдвэрлэлийн зориулалттай газар бага • Гар аргаар үйлдвэрлэл явуулдаг • Байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж чаддаггүй • хөрөө рамаас гарсан модны үртэс, хаягдлыг ашигладаггүй
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Зээл ,Төсөл хөтөлбөрт хамрагдах боломжтой • Сургалт сурталчилгаанд хамрагдах боломжтой • Тэжээлийн үйлдвэрийг хөгжүүлэх. • Брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх • Загас үржүүлэх боломжтой • Эсгий, эсгий гутлын үйлдвэр байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн эрс тэс уур амьсгалтай • Эрх зүйн орчин сайнгүй • Хулгай гарах магадлалтай • Мэргэжлийн хяналтын газрын шаардлага хэт өндөр, шат дамжлага ихтэй • Банкны зээлийн хүү өндөр, хугацаа богино • Зах зээлээс алслагдмал, өртөг өндөр

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Цэвэр ус	Гүний худаг
Цахилгааны хүчин чадал муу	Дэд өртөө барих
Халаалт	Нэгдсэн халаалтанд холбох
Мэдээ мэдээллээр дутмаг	Шилэн кабельд холбогдох
Орчны тохижилт муу	Гудамж талбайн гэрэлтүүлэг
Техник технологи хуучирсан, дутагдсан	Зээл тусламжинд хамрагдана.
Хулгай гарах магадлалтай	Камержуулна
Тусгай зөвшөөрөл бүхий ААНБ хууль журам зөрчиж байна.	Сургалт сурталчилгааг зохион байгуулж, хяналтыг сайжруулна.

Хэрэглэгч цөөн	Бусад сумдад борлуулалт хийнэ.
Хөрөнгө санхүүгийн чадамж сул	Төсөл хөтөлбөрт хамруулна.
Эрх зүйн орчин сайнгүй	Холбогдох байгууллагад уламжилна.
Мэргэжлийн хяналтын газрын шаардлага хэт өндөр, шат дамжлага ихтэй	Холбогдох дээд байгууллагад уламжилна.
Хүний нөөц дутмаг	Ой үржүүлэгч, ойн мэргэжилтэн, ахуй үйлчилгээний мэргэжилтэн, барилгын материалын мэргэжилтэн бэлтгэх
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг өөр аймаг, сумаас зөөдөг	Гурилын үйлдвэр барих, хөц будааны үйлдвэр барих
Гар аргаар үйлдвэрлэл явуулдаг	ЖДҮ-ын тоног төхөөрөмж авахад нь дэмжлэг үзүүлнэ
Байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах	Загас үржүүлэг, жимс жимсгэнэ боловсруулах, нутгийн нэрийн цай,
Хөрөө рамаас гарсан модны үртэс, хаягдлыг ашигладаггүй	Шахмал түлш, хавтангийн үйлдвэр байгуулах

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ:

Эрдэнэбулган сум Аймгийн төвөөс 240 км, Улаанбаатар хотоос 710 км бөгөөд МОНГОЛ улсынхаа хоймор сайхан нутаг Хөвсгөл аймгийн зүйн хойд талд ОХУ-тай хил залган оршдог. Аялал жуулчлал хөгжих таатай орчин бүрдсэн ард түмний ёс заншил, үндэстэн ястан, уламжлал, хэл соёл, түүх, хөшөө дурсгал, булш бунхан, ан амьтан, үзэсгэлэнт болон өвөрмөц тогтоц бүхий газар, археологийн олдвор, судлагдаж шинжлэгдээгүй биширмээр сайхан нутаг, хүмүүсийн хүсэл тэмүүлэл, сэтгэлийг татах байгалийн үзмэрээр баялаг юм. Тус суманд аялал жуулчлалын салбар хөгжөөд 18 жил болж байгаа ч богино хугацаанд түргэн хурдацтай хөгжиж таатай нөхцөл боломжийг нээн өгч байна. Өнөөдрийн байдлаар манай суманд АЖ-ын 4 компани улирлын чанартай үйл ажиллагаа явуулж, жилд дунджаар гадаадын 60, дотоодын 110 аялагчийг хүлээн авч үйлчилдэг. Энэ нь тухайн жилд ирж буй аялагчдын 30 орчим хувийг эзэлдэг. Цаашид Эрдэнэбулган суманд АЖ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, ААН болон аялагчдын тоо өсөн нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Дэлхий дахинд түүний дотор манай оронд жуулчдын хүсэл сонирхол жилээс жилд нэмэгдэж байгаа нь тэдэнд халуун дотно, соёлтой үйлчилгээ үзүүлж, жуулчдын сэтгэл ханамжийг улам илүү татаж байгаатай холбоотой юм. Иймд байгаль орчинд сөрөг нөлөөгүй Спорт АЖ-ыг хөгжүүлэх түүнчлэн байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалт эко жуулчлалыг эрхэм зорилго болгон хөгжүүлбэл сөрөг нөлөөлөл багасна. “Эко аялагч”-дын онцлог шинж чанаруудыг дурьдвал:

- Хүрээлэн буй орчны талаар өргөн мэдлэгтэй
- Аялалд их зардал гаргадаг

- Өндөр боловсролтой
- Орон нутгийн үйлчилгээг худалдан авахыг хүсдэг
- Үнэн зөв, чанартай мэдээллийг шаарддаг туршлагтай хүмүүс байдаг.



Аялал жуулчлалын SWOT шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Байгалийн үзэсгэлэнт болон өвөрмөц тогтоц бүхий газар олонтой • Спорт, загасчлал хөгжүүлэх нөөцтэй • Морин аялал болон бусад төрлийн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх нөөцтэй • Даян дээрх орчмын үзэсгэлэнт газар нутагтай • Далийн цэцэг ургадаг 	<ul style="list-style-type: none"> • Дэд бүтэц муу хөгжсөн • Иргэд болон бизнес эрхлэгчид аялал жуулчлалын талаар ойлголт дулимаг • Иргэдийн хандлагыг өөрчлөх, мэдээ, мэдээллийг нэмэгдүүлэх
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Сурталчилгаа хийх- • Харилцаа тогтоох – Вэф сайт, цахим хуудас ажиллуулах • Аялал жуулчлалын үзэсгэлэн, форумд оролцох • Хамтын ажиллагаа /ССАЖ-ын сайд Ц.Оюунгэрэл/ 	<ul style="list-style-type: none"> • Эрх зүйн зохицуулалт хатуу • Зам харилцаа хэцүү

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Байгалийн нөөц баялгийг хамгаалах, ашиглах менежментийн төлөвлөгөө байхгүй.	Сумын ойн нөөцийн менежментийн төлөвлөгөөтэй болно.
Аялал жуулчлалын байгууллагын хөтөч манай нутгийн түүх соёлын тухай мэддэггүй.	Танилцуулга бэлтгэж, гарын авлага материалаар хангана, хөтчийг сургалтанд хамруулах, мэргэшүүлэх

Орон нутаг, аялал жуулчлалын байгууллагууд, иргэд хамтарч ажилладаггүй	Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулна. Аялал жуулчлалын бодлогын баримт бичигтэй болно, аяллын маршрутыг батлах, хэрэгжүүлэх
--	--

А. Хатуу дэд бүтцийн хөгжил

Эрдэнэбулган сумын дэд бүтцийн салбарын хөгжил:

Ерөнхий мэдээлэл:

ЗАМЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ: Улсын чанартай зам 45 км, орон нутгийн чанартай гол зам 200 гаруй км, замын нөхцөл ерөнхийдөө муудсан. 80км яваад Уньт –Мөрөнгийн хатуу хучилттай замд холбогдох боломжтой

Эгийн голын төмөр бетонон гүүр 76м урт 1998 онд ашиглалтанд орсон одоог хүртэл урсгал засвар хийгдээгүй. Бэрх , Асайт, Уртын ам, Цагаан чулуутын модон гүүрнүүдийг засаж шинэчилсэн . Өл, Урт, Удган даваанууд үерт идэгдэж жалга, гав гуу гарч эвдрэлд орсон учир орон нутгаас үе шаттай засварлахаар төлөвлөж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг албан ёсны аж ахуйн нэгж байхгүй. Эг-Үүр, Мөрөн, Эг-Үүр-Эрдэнэт-Дархан-Улаанбаатар чиглэлд хувиараа нийтийн тээврийн үйлчилгээг 7 иргэн тогтмол үзүүлж байна. Ашиглагдаж буй авто машин нь istana-4, УАЗ фурган -2, Дунд оврын автобус-1.

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ:

Дани улсын хөрөнгө оруулалтаар 200кв хүчин чадал бүхий усан цахилгаан станц барьж 2007 онд ашиглалтанд оруулж хоёр жил ашигласан. /өсөн нэмэгдэж буй цахилгааны хэрэглээг хангаж чадахгүй болсон/ 2009 онд Тариалан сумаас агаарын 15кВа-н 80км шугам татаж төвийн эрчим хүчинд холбогдсон. Цаашид сумын төвийн 04-н шугамыг шинэчлэх, дэд өртөөний тоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн.

ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ХАНГАМЖ:

980-д онд САА-н тэжээлийн үйлдвэр, бусад цех, байгууллагуудыг холбосон 600м шугам, хоёр уурын зуух ашиглаж байсан боловч 1992 оноос хойш ашиглагдаагүй тоногдож, цаашид ашиглах боломжгүй болсон. Одоогийн байдлаар төсвийн байгууллагууд нам даралтын зуух ашиглаж байна.

ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ХӨГЖИЛ:

Манай холбооны салбар 1959 онд бригадын холбооны зориулалттайгаар Тариалангаас 80км ган агаарын шугам, 1ш МБ аппараттайгаар ажиллаж



эхэлсэн. 1985 онд Сангийн аж ахуй байгуулагдахад эрхлэгч, залгагчтайгаар ажил нь идэвхжиж энэ ондоо Экран- Кр станц, багуудад шуудан хүргэх машин нэмэгдэж ажилласан байна. 1989 онд одоогийн ашиглаж байгаа барилга ашиглалтанд орж 2 залгагч, 1 монтёр, эрхлэгч, жолоочийн бүрэлдэхүүнтэй 1991 он хүртэл ажиллан, 1991 онд электрон АТС –С1248 35 хэрэглэгчтэй ажиллаж эхэлсэн билээ. 2007 онд Жи мобайлын сүлжээний төхөөрөмж, 2011 онд Юнителын сүлжээний төхөөрөмж, 2012 онд МЦХ-ны ZXJ-10 АТС микомын интернет ажиллаж эхлэв. Дээрх операторууд бүгд висат станцаар дамжуулах асуудлаа шийдсэн. 2012 онд өндөр хурдны шилэн кабель баригдаж эхлээд 2013 онд дууссан боловч ажлын гүйцэтгэл дутуу хийгдсэн шалтгаанаар Агентлаг хүлээж аваагүй байна. Шилэн кабелийн трансин дагуу шавар намаг ихтэй, агаарын шугамтай, гадны нөлөөнд гэмтэх эрсдэл ихтэй. Шилэн кабелийг хүлээж авах, бэхжүүлэх, төсвийн газруудад Шилэн кабель татах, МЦХ ХХК-НЫ АТС-ыг сольж, айл өрхүүдийг интернеттэй болгох зорилт тавин ажиллаж байна.

ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛОН УНДНЫ УСНЫ ХАНГАМЖ:

Сумын төвийн ундны усны хэрэгцээнд улсын төсвийн хөрөнгөөр баригдсан гүн өрмийн худаг 1, хөдөөгийн багт бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор баригдсан 18 худаг, Мөн иргэд хувиараа гаргасан 103 гар худаг, 100 гаруй гол горхи, булгаас хэрэглээний усаа хангаж байна.



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

Инженерийн хийцтэй барилга байгууламжийн 90 хувь нь насжилт өндөртэй, сумын төвийн тохижилт харьцангуй муу. Хотжилтыг хөгжүүлэхэд газар, нутаг дэвсгэрийн хэмжээ хэтэрхий давчуу байна.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг жил бүр ИТХ-ын хуралдаанаар батлуулж мөрдөж ажилладаг боловч газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүйгээс газар олголт эмх цэгц муутай байгаа билээ.



Хатуу дэд бүтцийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Төвийн эрчим хүчний цахилгаан дамжуулах агаарын шугамд холбогдсон • Өндөр хурдны интернетэд холбогдсон • Малчид 100% сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй • Хэрэглээний усан хангамж сайн • Үүрэн холбооны хоёр сүлжээтэй, багууд суурин болон хөдөлгөөнт холбоог хэрэглэж байна • Усан цахилгаан станцтай 	<ul style="list-style-type: none"> • Сумын төвийн эрчим хүчний хүрэлцээ хангамж муу • ШТ материалын хангамжийн өрсөлдөөн байхгүй • Ундны усан хангамж муу /стандартын шаардлага хангасан худаг нэг / • Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө байхгүй • Байгууллага бүр тус тусдаа нам даралтын болон модоор галладаг зуух ашигладаг /ердийн галлагаа/ • Эгийн голын бетонон гүүрний засвар үйлчилгээ огт хийгдээгүй • Шуудан хүргэлт хангалтгүй • АА нэгж, байгууллагууд интернетэд бүрэн холбогдоогүй • Дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулдаг АА нэгж, мэргэжлийн байгууллага байхгүй • Инженерийн хийцтэй барилгын насжилт өндөр • Усан цахилгаан станц эвдэрч гэмтсэн, хүчин чадал нь сумын төвийг хэрэгцээг хангахгүй болсон
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Дулааны нэгдсэн системд холбогдох • Эрчим хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх /ДП-ний тоог нэмэгдүүлэх/ • ШТС-ын тоог нэмэгдүүлэх • Стандартын шаардлага хангасан гүний худгийн тоо нэмэгдүүлэх • Шуудан хүргэлтийг тогтмолжуулах • Бетонон гүүрэнд урсгал засвар хийх, үйлчилгээг тогтмолжуулах • Орон нутгийн чанартай даваа, гүүрнүүдийг ОНХ-ийн сангийн хөрөнгөөр засаж сайжруулах • Төсвийн байгууллага, АА нэгжүүдийг интернетэд бүрэн холбох • Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах • ОНХС-ын хөрөнгийг ашиглах 	<ul style="list-style-type: none"> • Замын нөхцөл муу, даваа, гол горхи олонтой • Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр дутмаг / их хэмжээний хөрөнгө шаардагдах/ • Суурин газрын талбай бага /Эгийн гол, Хүрэн уул, намаг, тариалангийн талбайгаар хүрээлэгдсэн / • Төв суурин газраас алслагдсан

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Цахилгаан эрчим хүчний хангамж муу	04-н шугам шинэчлэх, дэд өртөөний тоог нэмэгдүүлэх
Стандартын шаардлага хангасан ундны усан хангамж муу	Ундны усны хайгуул судалгаа хийлгэх, гүний худгийн тоог нэмэгдүүлэх, зарим гадаргын болон худгийн усыг шинжилгээнд тогтмол хамруулах
Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгүй	Мэргэжлийн байгууллагад захиалга өгч газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх
Интернет орчин хязгаарлагдмал	Төсвийн бүх байгууллагыг интернетэд холбож Wi-Fi төхөөрөмж сурилуулж утасгүй Net-н хамрах хүрээг өргөтгөх
ШТС өрсөлдөгчгүй, үйлчилгээний чанар муу	Өрсөлдөгч компанийг бодлогоор дэмжих
Орон нутгийн чанартай гүүр, даваанууд эвдэрч муудсан	ОНХС-ын эх үүсвэрээр үе шаттайгаар засварлах
Усан цахилгаан станц эвдэрч, шуудуу нь нурж эхэлсэн	Мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах

Б.Зөөлөн дэд бүтцийн хөгжил

БАНК, САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

ХААН БАНК Сумын төсвийн нийт орлогын 86.6%-ийг татварын орлогоор, 13.4%-ийг татварын бус орлогоор бүрдүүлж байна. Анх 1977 онд Эрдэнэбулган сумын Тооцооны касс нэртэй үйл ажиллагаагаа эхэлж байжээ. 1991 онд тооцооны касс татан буугдаж ХАА-н банкны тооцооны төв болж үйл ажиллагаагаа явуулж байсан. 2003 онд хувьчлагдаж



2006.11.22 нд ХААН банк нэртэй болж өдийг хүртэл үйл ажиллагаа нь өргөжин монгол орны өнцөг булан бүрт тархсан сүлжээний ачаар бид өргөн уудам нутагт амьдарч буй бүх харилцагчдадаа санхүүгийн үйлчилгээг бодит цагийн горимд түргэн шуурхай хүргэж нийгмийн бүхий л хүрээ, бизнесийн бүхий л салбарт хүрч ажиллаж байна. Хаан банк нь харилцагчдынхаа алтан цагийг хэмнэх, банкны үйлчилгээг илүү хялбар болгох зорилгоор цахим банкны бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн ажиллаж байна.

Манай тооцооны төв давхардсан тоогоор 3149 харилцагч, 77

байгууллагатай хамтран ажиллаж “Эрхэм таны итгэл анд урианд” дор үйлчилгээгээ үзүүлж байна. Манай тооцооны төв нь сумын хэмжээнд зах зээл эзлэлт 70-80 хувийг эзэлдэг. Бидэнд итгэл хүлээлгэсэн олон мянган харилцагчдадаа талархлаа илэрхийлье.

2013 онд байрандаа өргөтгөл хийж орчин үеийн банкны үйлчилгээний стандартын дагуу тохижуулан дулаан, тав тухтай орчинд үйлчилгээгээ явуулж байна. Ингэснээр харилцагчдын хувийн нууц алдагдах байдал арилж, зээл авах болон бусад үйлчилгээ авахад маш таатай орчныг бүрдүүлсэн. Цаашид байрны гадна болон дотор тохижилтыг улам сайжруулан үйлчилгээгээ улам хялбар, тав тухтай болгож харилцагч олныхоо итгэлийг даан ажиллаж байна.

ЭРДЭНЭБУЛГАН ТӨРИЙН БАНК

Анх 2011.07.21нд Хадгаламж банк “Тооцооны касс” нэртэйгээр, эрхлэгчээр нь Э.Энхтөр теллер Д.Баттуяа гэсэн 2 ажилтантайгаар байгуулагдаж, 2011оны 08 сард суман дахь банкны тооцооны төв болон өргөжсөн. Тооцооны төв болон бие даасан аж ахуйн нэгж болж өөрчлөгдсөнөөр мөнгөн хадгаламж, зээлийн



үйлчилгээ өргөжин тэлж байгууллага, иргэддээ тэргүүн зэргийн шинэ бүтээгдэхүүнээр үйлчилж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны тогтоолоор 100 % төрийн өмчит банк бөгөөд 2013.07.22-ны Монгол банкны шийдвэрээр Хадгаламж банкыг /хуучин нэрээр / Төрийн банкинд шилжүүлсэн, Эрдэнэбулган суманд 2013.07.23 өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байгаа. Одоо банкны эрхлэгчээр Э.Энхтөр ахлах теллер Д.Баттуяа, теллер У.Гансүх нар ажиллаж байна.

Эрдэнэбулган тооцооны төв нь дараах үйл ажиллагааг харилцагчдад үзүүлэн ажиллаж байна.

Бүх төрлийн иргэдийн харилцах, хугацаагүй болон хугацаатай хадгаламжийн үйлчилгээ

Бүх төрлийн байгууллага, ААНэгжийн харилцах болон хадгаламж Цахим бүтээгдэхүүн: Үүнд: Мессеж мэдээ, мессежбанк, мобайлбанк

Бүх төрлийн виза карт

Карт уншигч /Lanpos.pos/ -ийн үйлчилгээ

Бүх төрлийн зээлийн бүтээгдэхүүн

Дотоодын мөнгөн шилжүүлэг

Захиалгат шилжүүлэг

Банк хоорондын мөнгөн шилжүүлэг гэх мэт.

Бүх иргэдэд хүртээмжтэй, чанартай, түргэн шуурхай үйлчилгээг үзүүлэх

Сум орон нутагтаа харилцагчийн үйлчилгээгээр тэргүүлэгч байгууллага болох зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Гадаад харилцаа:

Дани улстай хагас зуун жилийн түүхэн харилцаа, хамтын ажиллагаатай, Сумын удирдлагуудаас 2010, 2011 онд албан айлчлал хийж байсан. Мөн Дани улсаас жил бүр төлөөлөгчид ирж ажиллаж, амардаг. Дани улсын хөрөнгө оруулалтаар усан цахилгаан станц баригдсан. Цаашид хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх шинэ түвшинд гаргахыг зорин ажиллаж байна.

БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ:

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих сургалтын төв болон банк бус санхүүгийн байгууллага одоогоор байгуулагдаагүй байна. Хөвсгөл аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Бизнес инкубатор төвүүдтэй хамтран бизнес эрхлэхийг хүсэгчдийг зуучлан арга зүйн сургалтанд хамруулах, сертификат олгох, ажил эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээл тусламжинд хамруулах зэргээр дэмжлэг үзүүлж ажиллаж байна.



ТӨР, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА:

СУМЫН АХМАДЫН ХОРОО

Манай сумын хувьд 1990 онд ахмадын байгууллагатай болж, Д.Далай анхны даргаар сонгогдож, Ч.Баасан 1990-1992, Д.Ренчинбямбаа 1992-1994, Я.Юра 1994-1997, Б.Наранцэцэг 1997 оноос одоог хүртэл ажиллаж иржээ. 2009 онд аймгийн халамжийн сангийн хөрөнгөөр суманд халамжийн төв баригдаж, Ахмадын хорооны дотоод тохижилтоор “Тогтвортой амьжиргаа-2” төсөлд хамрагдан, 1.510.000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар тохижуулан, аймгийн халамжийн сангаас чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж байрлуулан, тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Сумын нийт ахмад настан 216, үүнээс эр 62, эм 154



Насны байдлаар:

1. 100-аас дээш настан-1
2. 90-100 хүртэлх настан-4
3. 80-89 хүртэлх настан-26
4. 70-79 хүртэлх настан-52
5. 69 хүртэлх настан-131
6. Хосоор амьдарч буй өрхүүд-60 байна

СУМЫН УЯАЧДЫН ХОЛБОО



Тус сумын морин спорт, уяачдын холбоо нь анх Я.Эрхэмбаярын

санаачилгаар 2006 онд даргаар нь Я.Эрхэмбаяр, нарийн бичгийн даргаар Г.Шарав нарыг сонгож үүсэн байгуулагдсан ба 2007 оны 4 дүгээр сарын 10-нд тухайн үеийн Засаг дарга Д.Бат-Эрдэний санаачилгаар уяачдын хурлыг зохион байгуулж, МСУХ-ны даргаар Н.Энхбаярыг сонгосон байна. Энэ үеэс хойш сумын уяачдын холбооны тэргүүлэгчдээр Б.Пүрэвдорж, Д.Батдэлгэр, Я.Лхагва, Д.Алтанхундага нар ажиллаж байна.

Тус холбоо нь жил бүрийн 3 дугаар сарын 18 нд хурлаа хийхийн зэрэгцээ их нас, азарга, соёолон насны морьдын хаврын уралдааныг жил бүр зохион байгуулж байна.

Зөөлөн дэд бүтцийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Арилжааны хоёр банк үйл ажиллагаа явуулдаг • Дани улстай олон жил найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай • Төр иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа сайн • ИТХ-ын байгууллагаас бизнес эрхлэгчдийг дэмжсэн тогтоол шийдвэр гаргадаг 	<ul style="list-style-type: none"> • Бизнесийг дэмжих үйл ажиллагаа явуулдаг байгууллага байхгүй /бизнес инкубатар төв, ББСБ/
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Бизнес мэдээллийн төв, инкубатор төв байгуулах • ББСБ байгуулахыг дэмжих 	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө санхүүгийн нөөц хяцгаарлагдмал

Тулгамдаж буй асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Ажил олгогч, ажил хайгчийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй	Хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг зохион байгуулах
Шинээр болон үйл ажиллагаа нь тогтмолжоогүй бизнес эрхлэгчдийн зөвлөгөө өгөх, бойжуулах төв байхгүй	Бизнесийг дэмжих төв байгуулах, сургалт суртчилгаа явуулах

Нийгмийн үйлчилгээний салбарын хөгжлийн байдал

ХҮН АМ ЗҮЙ:

Тус сум нь 2013 оны эцсийн байдлаар 784 өрхийн 2733 хүн амтай. Үүнээс эрэгтэй- 1390, эмэгтэй- 1343 байна. 0-15 насны хүүхэд – 822, хөдөлмөрийн насны -1621, өндөр настан-204, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн – 123, бүтэн өнчин хүүхэд – 9, хагас өнчин хүүхэд – 22 байна. Нийт хүн амын 60% орчим нь халх, 40% -ийг урианхай болон бусад ястан эзэлж байна. Ажилгүйдлийн түвшин 5.3 %-тай байна. Амьжиргааны түвшний судалгааг багуудаар гаргавал :

№	Баг	Нэн ядуу өрх		Ядуу өрх		Дундаж өрх		Чинээлэг өрх		2013 оны нийт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Бөөрөлж	16	11.5	21	15.1	101	27.3	1	0.7	139	465
2	Чичин	12	9.8	19	15.5	88	72.3	3	2.4	122	449
3	Зэрлэг	8	7.3	10	9.0	90	81.9	2	1.8	110	368
4	Дуурга	46	13.9	62	18.8	203	61.6	19	5.7	330	1157
5	Удган	10	12.0	14	16.8	57	68.8	2	2.4	83	294
БҮГД		92	11.7	126	16.0	539	68.9	27	3.4	784	2733

Сумын нийт өрхийн 27.7 % нь ядуу байгаа нь хувь хүний сэтгэлгээний хөгжил, хандлагаас гадна тус суманд үйлдвэрлэл үйлчилгээ, ЖДҮйлдвэрлэлийн хөгжил эхлэлийн шатандаа байгаа, ажлын байр хангалтгүй байгаатай холбоотой юм.

Хүн ам зүйн байдлын SWOT

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Дотоодын Их, дээд сургуулиудад 130 орчим оюутан суралцаж байна. • Хүүхдийн дархлаажуулалт 100% хийгддэг. • Сумын нийт хүн амын 70% нь залуу буюу дунд насныхан, 25% нь хүүхэд байна. • Нэг хүнд ноогдох газар нутгийн хэмжээ 171.7 га 	<ul style="list-style-type: none"> • Хувиараа эрхлэх бололцоотой иргэд ажил хийхгүй байна. • Сэтгэлгээгээ өөрчилж чадахгүй байна. • Урьдчилан сэргийлэх үзлэгт сайн дураараа бүрэн хамрагддаггүй. • Цэцэрлэгийн хүрэлцээ хангамж сул. 383 хүүхдээс зөвхөн 149 хүүхэд үндсэн сургалтанд хамрагдаж байна.
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Нутгийн мэргэжлийн боловсон хүчнийг дэмжих, бүрэн хангагдах • Хөдөлмөр эрхлэлтийн албаар дамжуулан мэргэжил эзэмших, ажлын байраар хангагдах • Хувийн компани, аж ахуйн нэгжүүдэд ажил эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх • Хувиараа газар тариалан, төмс хүнс тариалах 	<ul style="list-style-type: none"> • Хүн амын 38% нь алслагдсан багт амьдарч байна.

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
1.Хувиараа хөдөлмөр эрхлэх бололцоотой иргэд ажил хийхгүй байна.	Иргэдийг хувиараа хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх талаар сургалтуудыг зохион байгуулах, олон төрлийн урамшууллын аян зарлах, хэрэгжүүлэх
2.Сэтгэлгээгээ өөрчилж чадахгүй байна	Сургалт зохион байгуулах, иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах

3. Урьдчилан сэргийлэх үзлэгт сайн дураараа бүрэн хамрагддаггүй	Сургалт, суртчилгааг чанаржуулах, тоог нэмэгдүүлэх
4. Цэцэрлэгийн хүрэлцээ хангамж сул. 383 хүүхдээс зөвхөн 149 хүүхэд үндсэн сургалтанд хамрагдаж байна.	Бүлгийн болон хамрагдагчийн тоо, багшлах боловсон хүчний тоо, чанарыг нэмэгдүүлэх
5. Хүн амын 38 орчим хувь нь алслагдсан багт амьдарч байна.	Хөдөөгийн алслагдсан багт үзүүлэх төрийн үйлчилгээний тоо, чанарыг нэмэгдүүлэх

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ:



Өнөөдөр тус байгууллага нь сургалтын 2 байртай, 5 бүлэгт 140 гаруй хүүхдийг хүлээн авч, 20 багш ажиллагсадтайгаар СӨБ олгох үйлчилгээг удирдан явуулж байна. Мэргэжлийн багш болон туслах багшаар 100% хангагдсан ба СӨБ-ын үндсэн болон хувилбарт сургалтын ажлыг жилийн туршид зохион байгуулж, хамран сургах тойргийн хүүхдийг 100% хамруулан сургаж, сумын хөгжил дэвшилд болон бодлогын чанартай ажил үйлчилгээнд өөрсдийн хувь нэмрийг оруулан нэр хүндтэйгээр ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газар, Боловсролын яамнаас хэрэгжүүлж буй “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн “Авьяас”, “Ном”, “Багшийн хөгжил” дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхэд нэг бүрийг судлан хөгжүүлэх томоохон ажлыг эхлүүлж, бүлэг бүрийг номын сантай болгох, тоглоомжуулах, багш бүрийг компьютержүүлэх, интернэт үйлчилгээ буюу цахим хичээлийг нэвтрүүлэх, эцэг эхийн оролцооны чанарыг дээшлүүлэхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Уг ажлын үр дүнд багш нарын хэрэглээнд иж бүрэн 4 компьютер, проектор, самбартай болсон ба “Ном” хөтөлбөрийн

хүрээнд 2 сая төгрөгийн өртөг бүхий номын фондтой болсон байна.

Мөн өнгөрсөн хугацаанд 100 хүүхдийн сургалтын шинэ барилгын ажлыг хөөцөлдөж, УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэнгийн дэмжлэгээр 2012 онд 100 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын суурь тавигдаж, 2013 онд 500 сая, 2014 онд 383 сая төгрөгийн өртөгтэйгээр баригдаж, ашиглалтанд орох гэж байна.

Өнөөдрийн байдлаар манай сум СӨН-ны буюу 2-5 насны 277 хүүхэдтэй ба үүний 149 хүүхэд нь /53.7%/ цэцэрлэгийн үндсэн сургалтанд, 128 /46.2%/ хүүхэд нь хувилбарт сургалтанд хамрагдаж байна. Мөн эрхлэгч-1, арга зүйч-1, багш-6, туслах багш-5, нярав-1, нягтлан-1, тогооч-2, угаагч-1, үйлчлэгч-1, галч хамгаалагч-2, нийт 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Үүнээс гадна манай цэцэрлэг нь үзэсгэлэнт Эгийн голын хөвөөн дээр оршдог ба орчин үеийн хийц бүхий 2 давхар барилга сүндэрлүүлж, техник технологийн хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж, тоглоом наадгайгаар хангагдсан "Хүүхдэд ээлтэй, шилдэг менежменттэй, эко цэцэрлэг" болох зорилгын дор уг хөтөлбөрийг боловсрууллаа.

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний SWOT

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн багшаар хангагдсан • Хүүхдийн тоо өсөн нэмэгдэж байгаа ба хамран сургалтаараа сүүлийн 5 жил 100%-ийн амжилтыг гаргасан. • Шинэ сургалтын байр, дагалдах хөрөнгө оруулалт хийгдэнэ. • Ажлын байран дээрээ хөгжих боломжоор хангагдсан • Чадварлаг боловсон хүчинтэй • Эцэг эхийн хамтын ажиллагаа маш сайн • Хамт олон сайн төлөвшсөн, багаар ажиллах чадвар сайн 	<ul style="list-style-type: none"> • Хөдөөгийн алслагдсан багуудад хүрч ажиллах, хүүхдээ цэцэрлэгт хамруулахад хүндрэлтэй • Багш нарын бие даан суралцах идэвх сул • Багш хөгжлийн төв байхгүй • Гал тогооны цахилгаан тоног төхөөрөмж байхгүй • Багш нар компьютер, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаагүй • Интернет орчин бүрдээгүй • Байгууллагын онцлогт тохирсон дүрэмт хувцас байхгүй, мөн нормын хувцас, зөөлөн эдлэлээр бүрэн хангагдаагүй • Хүүхэд бүрийг судлах, хөгжүүлэх ажилд ахиц гарахгүй байгаа • Нэгдсэн халаалтгүй, цэвэр бохир усны системд холбогдоогүй, гүний худаггүй тул усны эрүүл ахуй баталгаагүй • Бүлгүүд тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангагдаагүй • Хүүхдийн бие засах газрын суултуурын тоо хангалтгүй

	<ul style="list-style-type: none"> • Тоглоомын болон биеийн тамирын талбай, өрөө тасалгаа байхгүй • Гадна орчны тохижилт, гэрэлтүүлэг хангалтгүй • Бие даасан, орон тооны эмч байхгүй
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Шинэ байр ашиглалтанд орсноор бусад тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, гал тогооны цахилгаан хэрэгслээр бүрэн хангагдах • Гүний худгийн асуудлыг шийдвэрлэснээр цэвэр бохир усны асуудлыг бүрэн шийдвэрлэх • Дуу хөгжмийн болон биеийн тамирын танхимтай болох • Шаардлага хангасан ариун цэврийн өрөө, эмчийн болон өвчтэй хүүхдийг тусгаарлах өрөөтэй болох ба угаалтуур, суултуурын тоог нэмэгдүүлэх • Шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, номоор хангагдах • Багш хагжлийн төвтэй болно. • Байгууллагын стандартыг боловсруулж мөрдөж ажиллах • Хамран сургалтыг 100%-аас бууруулахгүй байна. • Бүлгийн тоог нэмэгдүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Төсөвт ном, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, бичиг хэрэг, зөөлөн эдлэлийг худалдан авах мөнгө хөрөнгө тусгагддаггүй • Бүлэгт хамрагдах хүүхдийн тоо хэтэрхий олон • Багш нарт өөртэйгөө ажиллах цаг гардаггүй, багш хөгжлийн төв байдаггүй • Анги танхимын хүрэлцээ муу, угаалтуурын болон суултуурын тоо хэтэрхий цөөн • Зарим багш, ажилтны харилцаа, хандлага муу, хувийн эрх ашгийг дээдэлдэг • Заримдаа байгууллагын дотоод журам зөрчигддөг • Удирдлагын зүгээс хариуцлага тооцох тал дээр сул ажилладаг • Эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт хангалтгүй • Хүүхдийн болон ажиллагсдын хэрэгцээний ширээ сандал, шүүгээ, сейф хүрэлцээгүй. • Явуулын болон нүүдлийн цэцэрлэгийн шатахууны зардал хүрдэггүй

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
1.Хичээлийн шинэ барилга ашиглалтанд ороход бүх эд хогшил, хивс дэвсгэр, тоглоом, тоног төхөөрөмж шинэчлэгдэх шаардлагатай байгаа ба төсвийн зардлын хүрээнд шийдвэрлэх боломжгүй	1.Шаардлагатай тоног төхөөрөмж, ширээ сандал, эд хөрөнгийн захиалгыг хийж, яаманд, УИХ-ын гишүүдэд хүргүүлэх, шийдвэрлүүлэх
2.Интернэт орчин бүрдээгүйгээс багш нарын бие даан хөгжих боломж хязгаарлагдмал байна. Мөн багш хөгжлийн төв байхгүй.	2.Интертэд холбогдож, дотоод сүлжээг холбогдон, багш, ажилчдыг компьютер, тоног төхөөрөмжөөр бүрэн хангах -Багш хөгжлийн иж бүрэн төвтэй болно

<p>3.Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн тоо жилээс жилд өсөж байгаа боловч бүлэг нэмэх асуудлыг шийдүүлэхэд хүндрэл гардаг төдийгүй нэг багшид ноогдох хүүхдийн тоо нормативаас давснаас хүүхэд бүртэй тулж ажиллах боломжгүй болж байна.</p>	<p>3.Судалгаанд үндэслэсэн бүлэг нэмэх хүсэлтийг аймгийн БСГ-т тавьж, 6 бүлгээр ажиллах боломжийг гаргана. Үүнийг дагаж, боловсон хүчний орон тоо нэмэгдэнэ.</p>
<p>4. Зуны нүүдлийн цэцэрлэгийн гэр, байр байхгүйгээс баг дээр ажиллахад хүндрэл гардаг ба зарим жил түрээсийн гэр ашигласнаас төлбөр гарах, мөн шатахууны зардал хүрэхгүйн улмаас эцэг эхээс мөнгө хураах асуудал гардаг.</p>	<p>4. Удган, Бөөрөлж багууд дээр багийн залуучуудын дэмжлэгтэйгээр зуны цэцэрлэгийн 5x5 хэмжээтэй байртай болох ба НҮБ-ын санхүүжилтээр зуны цэцэрлэгийн 2-4 гэрийг хөөцөлдөж авна. Уг гэрүүдийг хөдөөгийн 4 багт ашиглах ба төв дээр зуслангийн төсөл хийж, ойн мэргэжлийн ангиудын дэмжлэгтэйгээр барьж ашиглалтанд оруулна. Мөн шатахууны зардлыг төсөвт тусган, бодитоор батлуулахыг зорино.</p>
<p>5.Эрүүл мэнд, эрүүл ахуйн тоног төхөөрөмж, хүүхдийн жин, хэмжүүр, өвчтэй хүүхдийг тусгаарлах өрөө, эмийн сан, орон тооны эмчийн ажлын байр байхгүйгээс халдварт өвчлөл гарах, өдрийн дэглэмтэй холбоотой зөрчил дутагдал гарах, эцэг эх-багш нарын хооронд үйл ойлголцол гарах магадлал өндөр байдаг.</p>	<p>5. Орон тооны эмчтэй болж, эмчийн өрөөний тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байна.</p>
<p>6.Осолаюулгүйажиллагаатайхолбоотой гарц, орц, шат, галын аюулгүй байдлыг хангах багаж хэрэгсэл, мэргэжлийн туслалцаа дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байдаг.</p>	<p>6. Галын хор, багаж хэрэгсэл, аваарын шат, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан хаалга, шат зэргийг бүрэн шийдвэрлэж, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулсан байна.</p>
<p>7. Дуу хөгжмийн болон биеийн тамирын танхим байхгүйгээс гадна мэргэжлийн багш байхгүй байна.</p>	<p>7. Шинэ байр ашиглалтанд орсноор дуу хөгжмийн кабинет, биеийн тамирын заалтай болох ба шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдана. Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжиж ажиллах боломжтой болно.</p>
<p>8. Бага насны хүүхдийн номын сан байхгүйгээсбүлэгбүрбагаханхэмжээний номоо жижиг булан дээр байрлуулдаг ба хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх ажил хангалтгүй хийгдэж байна. Мөн төсөвт ном хэвлэл худалдан авах зардал дээр маш бага мөнгө тавигдаж байна.</p>	<p>8. Номын болон үлгэрийн танхимтай болох ба зарим төсөл хөтөлбөрүүдэд хандах, сумын хөгжлийн сангаас дэмжлэг авах зэрэг арга замаар шийдвэрлэнэ. ” Үлгэрийн өргөө” төслийг Соёлын яамны санхүүжилтээр шийдвэрлэнэ.</p>

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ:

1.1 Өнөөгийн нөхцөл байдал¹:


- Анги бүлгийн тоо, хичээллэх ээлжийн хувь авч үзвэл:
 - Бага боловсрол: I анги -2, II анги 2, III анги 2, IV анги-2, V анги-2, нийт 10 бүлэг
 - Суурь боловсрол: VI анги-2, VIII анги-2, IX анги-2, нийт 6 бүлэг,
 - Бүрэн дунд боловсрол: X анги-2, XI(12 жил)-1, XI анги-1, нийт 4 бүлэг байгаа бөгөөд нийтдээ 20 бүлэгт 472 сурагч суралцаж байна.1-р ээлжинд хичээллэх бүлгийн тоо 16, хүүхдийн тоо 387, 2-р ээлжинд хичээллэх бүлгийн тоо 85 , Дотуур байранд 80 хүүхэд амьдарч байна.
 - Бүлэг дүүргэлт өнгөрсөн хичээлийн жилд 32,18 байсан. Өмнөх онтой харьцуулан авч үзвэл 0,89 –өөр буурсан дүн харуулж байна.

Бүлэг дүүргэлт		
2011-2012	2012-2013	Зөрүү
33,07	32,18	-0,89

Суралцагчдын хувьд нийт 472 сурагч байгаагаас 220 нь эмэгтэй сурагчид байна.

- Бага боловсрол нийт 214 суралцагч байгаагаас 97 нь эмэгтэй сурагч, үүнээс 1-р ангид 43, 2-р ангид 45, 3-р ангид 46, 4-р ангид 42, 5-р ангид 38 сурагч,
- Суурь боловсролд 153 сурагч байгаагаас 70нь эмэгтэй сурагч, үүнээс 6-р ангид 45, 8-р ангид 64, 9-р ангид 44 сурагч,
- Бүрэн дунд боловсролд 105 сурагч байгаагаас 53 нь эмэгтэй сурагч, үүнээс 10-р ангид 44, 12 жилийн 11-р ангид 30, 11-р ангид 31 сурагч байна.
- Сургуулийн ажилчдын мэдээлэл:

Нийт 60 ажиллагсад ажиллаж байна. Үүнээс сургалтын менежер-2,нийгмийн ажилтан 1, үндсэн багш 30, бага ангийн 10, дунд, ахлах ангийн 20 багш байна. Цагийн багш 2, нягтлан бодогч-1, нярав-1, бичиг хэрэг-0, номын санч-1, эмч-1, сантехникч-1, мужаан-0, цахилгаанчин-0,үйлчлэгч-4, галч үндсэн-3, гэрээт галч-3, байрын багш-1, байрын жижүүр-3, тогооч-4, угаагч-1 манаач-1 байна.
- Үндсэн багш нарын мэдээлэл / нас ажилласан жил, боловсролын зэрэг гэх мэт/




Бага анги-10, монгол хэл уран зохиол-3, орос хэл-1, англи хэл-2, мэдээлэл зүй-1, математик-2, физик-1, хими-1, биологи-1, түүх нийгэм-2, газар зүй-1, биеийн тамир-3, хөгжим-1, технологийн-2 багш байна. Мэргэжлийн багшийн хангалт-100 хувь, мэргэжлийн бус багш байхгүй. Боловсролын зэргээр авч үзвэл доктор-0, магистир-2, бакалавр-27, дипломын боловсролтой багш 1 байна. Магистир болон бакалавр зэрэгтэй багш нар ихэнх хувийг /29 багш/ бүрдүүлж байна.

Нийт багш нарыг насаар авч үзвэл 30 хүртлэх насны багш нар-15, 30-39 настай-7, 40-49 настай-5, 50-59 настай-3, 60-аас дээш настай-0 багш байна гэсэн судалгаа байна. Эндээс харвал залуу, дунд үе, ахмад үе гээд үе үеийн багш нарын төлөөлөл оролцсон хамт олон болох нь харагдаж байна. Хамтрах, бие биедээ зөвлөх, арга туршлагаа хуваалцан ажиллах боломж нээлттэй байна.

Багш нарыг ажилласан жилээр нь авч үзвэл:

Анхны жилдээ багшилж буй багш-2, 1-5 жил ажиллаж буй багш-10, 6-10 жил ажиллаж байгаа багш-8, 11-15 жил ажилласан багш-2, 16-20 жилдээ ажиллаж буй багш-2, 21-25 жил ажилласан багш-1, 25-аас дээш жил ажилласан багш-4 байна.



1-15 жил ажилласан багш нар нийт багш нарын /22 багш/ дийлэнх хувийг бүрдүүлж байна.

Мэргэжлийн зэргээр авч үзвэл:

- Зөвлөх зэрэгтэй багш-0,
- тэргүүлэх зэрэгтэй багш-2,
- заах аргач зэрэгтэй багш-12 байна.

Энэ нь нийт багш нарын 14 нь буюу 37,8% нь мэргэжлийн зэрэгтэй гэдгийг харуулж байна.

2012-2013 оны хичээлийн жилд аймагт зохион байгуулсан сургалтуудад 32 багш, сургуулийн хэмжээнд зохиогдсон сургалт, суртчилгаанд 64 багш хамрагдаж нийт давхардсан тоогоор 96 багш мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн байна.

Сургалтын орчин

Тус сургуулийн хичээлийн байр 4 байдгаас стандартын-2, стандартын бус-2 байр байна. Хичээлийн төв байрнаас бусад байрнуудад их засвар хийх шаардлагатай. Хичээлийн байрууд нь төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон, хамгийн сүүлд 2011 онд өргөтгөл хийгдсэн бөгөөд хүчин чадлын хувьд 160 суудалтай, 9 анги кабинеттэй. Мэдээлэл зүйн кабинетэд нийт 30 компьютер байрлуулан сургалтад ашиглаж байна.

Байгууллагын хэрэгцээнд 2,284 га эдэлбэр газар, туслах аж ахуйд 80 толгой мал байдаг. Номын сан, технологийн хичээлийн кабинетууд тусдаа байранд үйл ажиллагаа явуулдаг..



Ерөнхий боловсролын үйлчилгээний SWOT шинжилгээ:

2.1 Сургуулийн дотоод орчин		
Орчны үзүүлэлт	S-Давуу тал:	W-Сул тал:
Материаллаг орчин	<ul style="list-style-type: none"> - Хичээлийн байрны тоо-4, зориулалтын анги танхим, биеийн тамирын 1 заалтай, - 2011 онд их засварт орсон - Сургуулийн анги танхим тохилог, дулаан, сантехникийн шугам шинэчилсэн - Хими, физик, математик, мэдээлэл зүй, гадаад хэл, монгол хэл, технологийн хичээлийн кабинет - Интернэтэд холбогдсон. - Анги танхимын 80% нь сургалтад ашиглах ухаалаг самбар, LCD зурагтай - Хэвлэлийн тоног төхөөрөмж - Багш, сурагчдын мэдээллийн баазтай 	<ul style="list-style-type: none"> - 4 хичээлийн байрны 2 нь стандартын бус, - Сургалтад ашиглах компьютерүүд, хөгжмийн зэмсэг тоо цөөн, хүчин чадал бага - Сургалтын хэрэглэгдэхүүн,сурах бичиг, туршилтын багаж төхөөрөмж дутагдалтай, - Мэргэжлийн хичээлүүдийн кабинетын хүрэлцээ муу, - Анги танхимыг орчин үеийн шинэлэг сургалтын материал

Сэтгэл зүйн орчин	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн багш нарын хангалт 100 хувь. - ЗАН тус бүрдээ үйл ажиллагаагаа төлөвлөн ажилладаг. - Нийт багш нарын 78 нь буюу 71,1% нь мэргэжлийн зэрэгтэй - Багш сурагчдыг идэвхжүүлэх залуу багш нарын клуб, мэтгэлцээний клубууд идэвхтэй ажилладаг 	<ul style="list-style-type: none"> - Багш нарын нийгмийн асуудалд анхаарал бага хандуулдаг - Багш сурагчдын мэдээллийн бааз дээр тулгуурлан тэднийг хөгжүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх ажил зохиогддоггүй - Багш хөгжлийн төвийн байр, тоног төхөөрөмж хангалтгүй
Үйлийн орчин	<ul style="list-style-type: none"> - Математик байгалийн ухааны хичээлийн чанар тогтворжиж байгаа - Хичээлийн судалгаа хийх арга зүйд нийт багш нарын 55 хувь суралцсан, - Хамран сургалт 1,2-3,5 хувь болж өссөн. - Аймаг, улсын олимпиад, ур чадварын уралдаан, спортын уралдаан тэмцээнд тогтмол амжилттай оролцож ирсэн 	<ul style="list-style-type: none"> - ЭЕШ-ийн хэмжээст онооны дундаж буурсан - Сургалтын үр дүнг хянах хяналтын тогтолцоо сул - Бага, монгол хэл, гадаад хэлний хичээлийн чанарт анхаарах - Хичээлээс гадуур зохиогдох ажлын чанарыг дээшлүүлэх, хүүхдийн хүмүүжил төлөвшилд онцгой анхаарал хандуулах
2.2 Сургуулийн гадаад орчин		
Орчны үзвэлэлт	О-Боломж:	Т-Аюул, эрсдэл :
Эдийн засгийн	<ul style="list-style-type: none"> - Сургуульд хөрөнгө оруулалт хийх - Аймаг, сумаас болон, ДЗОУБ ОНХХ-ийн орон нутаг хөгжүүлэх төсөл хөтөлбөрт хамрагдах - Мал аж ахуй эрхлэх, төмс хүнсний ногоо тарих - Төсвийг хэмнэлттэй захиран зарцуулах 	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн төсөвт шаардлагатай байгаа эд зүйлс, тоног төхөөрөмж худалдан авах, урсгал болон их засвар хийх хөрөнгө мөнгө тусгагдаггүй - Төсвийн бодит хэмнэлт болон өөрийн үйл ажиллагааны орлогыг захиран зарцуулах эрх үүсдэггүй
Өрсөлдөөн	<ul style="list-style-type: none"> - Чадварлаг мэргэжлийн багш нар олонтой - Багш, ажиллагсад, суралцагчдын ажиллаж сурахад ая тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх боломжтой - Анги танхимыг орчин үеийн шинэлэг сургалтын материал хэрэглэгдэхүүнээр хангах - Багш нарын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх бололцоотой 	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн чадварлаг багш нарын шилжилт хөдөлгөөн - Сургалтын орчин буюу анги танхим, гадна дотно талбайн эрүүл аюулгүй байдлыг хангах талаар санал санаачилга гаргахгүй байх

ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

- Сургуулийн зөвлөлийг шинэчлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах,
- Хүүхэд, эцэг эх, олон нийтийн байгууллагын оролцоонд тулгуурласан сургуулийн өөрийн үнэлгээг хийх,
- Сургууль хөгжлийн төлөвлөгөөг өөрийн үнэлгээн дээр тулгуурлан боловсруулах,
- Боловсролын чанарын шинэчлэлийн бодлогын хүрээнд сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн гаргах,
- Хамтран ажиллах, арга туршлагаа солилцох ажил сургуулийн хэмжээнд тогтмол хийгддэггүй,
- Хүүхэд, багш нэг бүрийг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх
- Сургуулийн хүний нөөцийн бодлого төлөвлөлт ил тод, нээлттэй болгох / багшийн сонгон шалгаруулалт, багш нэг бүрийн хөгжлийг дэмжих/,
- Багш ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг, хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан ажил үүргийн гүйцэтгэлийг хангуулах, ажлын хариуцлагыг нэмэгдүүлэн үр дүнг тооцож ажиллах
- Багш нарыг чадваржуулах, арга зүйн шинэчлэлийг түргэтгэх, ажлын байран дээрээ хөгжих нөхцөл бололцоог нээж өгөх, хэрэгцээт сургалтуудыг зохион байгуулах
- Сургалтын чанар, ахиц, амжилтыг тооцох чиглэлийн ажлуудыг чанартай зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах
- Сургалтын орчны үнэлгээ хийж цаашид анхаарах, сайжруулах зүйлсийг тодруулах, холбогдох арга хэмжээ авах /анги танхимын хүрэлцээ хангамж, тохижилт, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, стандартын бус хичээлийн 2 байр, номын сан, технологийн кабинетүүд/
- Сурагчдын шилжилт хөдөлгөөн их байдаг нь сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.
- Сургуулийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг ажлууд бидний тулгамдсан асуудал болоод байна.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОЛ АРГА ХЭМЖЭЭ:

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга зам, стратеги
1.	Багшийг ажлын байран дээрээ хөгжих боломжийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Багш нараас авсан судалгаа, ярилцлага, санал асуулга дээр үндэслэн тэдний хөгжих хэрэгцээг тодорхойлж ажлын байран дээрээ хөгжих боломжийг нэмэгдүүлэх - Шинэчилсэн эрх зүйн орчинд багшийн ажлыг бодитой үнэлж дүгнэх, хүүхэд нэг бүрийг хөгжүүлдэг арга туршлагатай багшийг сурталчлах

2.	Хүүхэд нэг бүрийг судлан авьяас, чадварыг нээн хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Хүүхэд, эцэг эхчүүдээс авах ШУ-ны үндэслэлтэй судалгаан дээр үндэслэн хүүхдийг оношлон, авьяас чадварыг нээх хөгжүүлэх арга замаа тодорхойлох
3.	Сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> - Сургалтын шинэ арга зүйг судлан хэрэгжүүлж хичээлийн судалгааг үр дүнтэй хийн багаар ажиллах менежментэд суралцах замаар сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах - Суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журмын дагуу суралцагчдын эзэмсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтыг үнэлж түүнд үндэслэн сургалтын чанарыг сайжруулах
4.	Хүүхдийн эрхийг дэмжсэн сурч хөгжихөд ээлтэй орчин бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Багш, ажиллагсад, суралцагчдын ажиллаж сурахад ая тухтай, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх - Шинээр хичээлийн байр бариулах талаар холбогдох газруудад санал хүргүүлэх, шийдүүлэх
5.	Сургуулийн бүтэц, зохион байгуулалт, менежмент, хүний болон санхүү, материаллаг нөөцийн хөгжлийг хангах	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн бүтэц, ЗАН-үүдийн зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн бодлогыг боловсруулан чадварлаг баг хамт олныг бүрдүүлэх - Багш хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих, сургалтын таатай орчныг бүрдүүлэхэд шаардагдах санхүү, материаллаг нөөцийг үр ашигтай зарцуулах бодлого төлөвлөлтийг боловсруулах
6.	Багш, удирдах ажилтнуудын ёс зүйт манлайлал, байгууллагын соёлыг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Багшийн ёс зүйн дүрмийг удирдлага болгон ажлын хариуцлага, ил тод, нээлттэй, шударга байдлыг эрхэмлэх - Удирдах ажилтнуудын манлайллыг нэмэгдүүлж хамт олны төлөвлөлийг хангаж, оролцоог нэмэгдүүлэх

7.	Эцэг эх, олон нийтийн оролцоо, хандлага хамтын ажиллагааг идэвхжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, олон нийтийг татан оролцуулах сургалт, уулзалт хэлэлцүүлэг, сургууль сурталчлах үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулах - Сургуулийн үйл ажиллагааг дэмжин ажиллах төрийн болон төрийн бус байгууллагуудтай байнгын холбоо тогтоох
----	---	--

ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын эмнэлэг нь анх 1939 онд 2 орон тоотоогоор бага эмчийн салбар байгуулагдаж эмчээр нь тэр үедээ бичиг үсэг сайтай олондоо Од хүү доктор хэмээн алдаршсан Содовын Гиваа сүрэн , асрагч санитар нь Махбуриад нар ажиллаж эхэлжээ.

Анх жижиг модон байшинд үйл ажиллагаагаа эхэлж 1940 оод оны эхээр нутгийн нэртэй мужаан Чоймбол, Ядам, Санжаасүрэн, Өвгөнхүү нар орос маягийн хийцтэй анхны эмнэлгийн барилгыг барьсан нь тэр үедээ манай сумын хамгийн гоё байшин болсон гэдэг.

1959 онд 10 ортой их эмчийн салбар байгуулагдаж анхны их эмчээр одоогийн Ар булаг сумын мянгат малчин Равдансамбуу эмч, эх баригч Пэлжээ, сувилагч С.Занданхүү, Б.Цэрэндулам, Л.Банзай, Өнөр, тогооч Долгоржав, нярав Санжаа, асрагч Даваа, Долгор, Чагнаабадам, Дуламсүрэн, галч Цогт очир нар ажиллаж байлаа.

1959 онд түргэн тусламжийн машинтай болж анхны жолоочоор Василь, Самбуу нар ажиллаж байв. Үүнээс хойш их эмч Цэрэндулам, Цэрэндорж, Б.Пүрэвдорж, Доржжанцан, Дариймаа, Х.Чагцалмаа, Оюунцэцэг, Баярмагнай, Б.Доржрагчаа, Д.Цолмон, Р.Түмэнжаргал, Э.Ганхуяг,

Б.Чинзориг нар ерөнхий эмчээр ажиллаж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирлээ.

1989 онд 15 ортой эмнэлэг шинээр баригдаж ашиглалтанд орсноор эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тав тухтай орчин бүрдсэн .

Одоо тус эмнэлэг нь 30 ажилтантай, их эмч -3, статистикч бага эмч -1, эх баригч -1, лаборант -1, багийн эмч-4, сувилагч-6, НЭМА-1, эмийн санч -1, тогооч -1, жолооч-1, нярав-1, үйлчлэгч-3, угаагч -1, галч-4, ЧБЭ-1, ня-бо -1 зэрэг орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус хамт олон нь ажил үйлсээрээ

2005 онд – “Сумын тэргүүний хамт олон”

2006 онд – Аймгийн “Шилдэг эмнэлэг”, сумын “Шилдэг төрийн байгууллага”

2009, 2010 онуудад – Аймгийн “Шилдэг эмнэлэг”

2014 онд – Сумын “Шилдэг үйлчилгээтэй байгууллага”-аар тус тус шалгарсан.

Эрүүл мэндийн салбарын SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • ЭЭС- ийн үйл ажиллагаа тогтмолжсон.Эргэлтийн хөрөнгөтэй. • Боловсон хүчний чадавх сайн, тогтвор суурьшилтай ажиллах боломжтой. • МСС- тогтмолжсон. • Уламжлалт эмчилгээний боловсон хүчин хангалттай • Эмийн бус эмчилгээг нэвтрүүлж эхэлсэн. • Эрүүл мэндийн чиглэлийн сургалтанд байнга хамрагддаг. • Түргэн тусламжийн автомашин шинэчлэгдсэн. • Эхо болон зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангагдсан 	<ul style="list-style-type: none"> • Тогтвор суурьшилтай ажиллах их эмчийн нөөцгүй, нарийн мэргэжлийн их эмч нар бэлтгэгдээгүй. -Мэргэжилтэй боловсон хүчний нөөцгүй. • Эмнэлэгт нөхөн сэргээх эмчилгээний багаж тоног төхөөрөмж байхгүй, эмийн бус эмчилгээ хөгжөөгүй. • Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж тогтолцоо сул • Багийн эмч нар мотоциклоор хангагдаагүй. • Эмнэлэг, лабораторийн багаж тоног төхөөрөмж дутагдалтай • Гал тогооны тоног төхөөрөмж байхгүй.
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Хууль эрх зүйн нөхцөл бүрдсэн, мэдээлэл авах, өгөх систем сайжирсан ./цахимд холбогдсон/ • Боловсон хүчнийг шилж сонгох, мэргэшүүлэх, тогтвортой ажиллуулах • Төсөв хөрөнгийг үр дүнтэй ашиглах боломжтой. • Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө хэрэгжиж байгаа • Эрүүл мэндийн чиглэлийн төсөл хөтөлбөрт хамрагдах боломжтой • Орон нутгийн дэмжлэг сайн 	<ul style="list-style-type: none"> • Барилгын чанар муудаж чанарын шаардлага хангахгүй болсон. • -Батлагдсан төсөв хүрэлцэхгүйгээс өр үүсэх • Эргэлтийн эмийн сангийн байр муудсан тул цаашид ажиллах нөхцөл муу • -Иргэдийн оролцоо идэвх муу • -МСС явуулах техник, хэрэгсэл байхгүй. Байр хангалтгүй. •

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дутмаг	-Лаборатори, физик эмчилгээ, зайн оношилгооны болон бусад тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах -Эхний ээлжинд ариутгалын тоног төхөөрөмжөөр хангах
Нарийн мэргэжлийн эмч бэлтгэгдээгүй	-Хүүхдийн болон нарийн мэргэжлийн эмч нарыг бэлтгэх
ЭМТ-ийн байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй, чанар муудсан	ЭМТ-ийн барилгыг шинээр барих
Эмийн сангийн стандартын байргүй, эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангахгүй болсон.	Эмийн сангийн байрыг шинээр барих
Иргэдийн эрүүл мэндийн боловсрол тааруу	Сургалт суртчилгааг өргөтгөх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, чийрэгжүүлэлтийн олон талт арга хэмжээ авах

СОЁЛ, УРЛАГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Соёлын байгууллага нь 1939 онд Улаан гэр нэртэйгээр анх байгуулагдаж тухайн үеийн төр засгийн бодлого, шийдвэр, орон нутгийн цаг үеийн ажил байдлыг ухуулан таниулж, соёлын үйлчилгээ, дуу хуур, жүжиг, кино, концертыг иргэдэд хүргэх ажлуудыг зохион байгуулдаг байжээ.



1963 онд 150 хүний суудалтай шинэ улаан булан баригдаж Эг - Үүрийн

САА - н Ажилчны клуб нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд анхны эрхлэгчээр Ч.Баасан ажиллаж байжээ.

1966–2000 он хүртэл тус клубын эрхлэгчээр Туваан, Чулуунбаатар, Загал, Ч.Банзай, Б.Дашдорж, П. Орсоонов, Д.Дөл, Н.Сэлэнгэ, М.Нарангэрэл, Л.Дамдиндорж, Г.Баатар, О.Батхишиг нар ажиллаж ирсэн бөгөөд 2001 оноос одоог хүртэл Д.Тулга ажиллаж байна.

Дээрх хугацаанд хөгжмийн багшаар Дэмбэрэл, Шүхэрт, Батчулуун, А.Оюунцэцэг, Магсар, С.Цэдэнгалсан, Г.Төмөрхаан, О.Оюунбилэг, Г.Энхбаатар, Д.Борхүү, Г.Баатар, Л.Дамдиндорж нар, кино механикчаар

Ойдов, Чойжоо, Бямбажав, Доржготов, Ганхуяг, Мягмарсүрэн, Н.Маамаа нар, номын санчаар Аяхуу, Ч.Банзай, Даваахүү, Г.Зооёо, Д.Долгор, Ц.Гантөмөр, Ц.Энхцэцэг нар ажиллаж байв.Тухайн үед ахмадуран сайханч Ж.Янжинлхам, Д.Уртнасан, Н.Гомбосүрэн, Д.Цэен, С.Бямбажав, Д.Цэрэндулам, Г.Рэнцэндорж, Х.Аюушжав, Ч.Банзай, Бямбажамц, П.Орсоонов, Д.Долгор, Н.Долгор нар болон С.Цэдэнгалсан, Ц.Хургаа, М.Тунгалаг, Ц.Эрдэнэ –Уул нарын олон залуу ардын авьяастнууд ардын болон уртын дуу дуулж, ерөөл, магтаал хэлж, хуучир, шанз, ёочин, ятга, лимбэ зэрэг үндэсний хөгжим хөгжимдөж, бүжиглэж байв.

Тус Соёлын төв нь 2008 оноос 5 орон тоотойгоор ажиллаж байгаа бөгөөд эрхлэгчээр МУСТА Д.Тулга, хөгжмийн багшаар МУСТА Г.Энхбаатар, дуу бүжгийн багшаар МУСТА Л.Дамдиндорж, номын санчаар Д.Лхагваа, үйлчлэгч, сахиулаар Т.Тайванжаргал, галчаар Ц.Ганбаатар, Д.Энхболд нар ажиллаж байна. Соёлын төв нь жилдээ шинэ уран бүтээл 5- 6, урлаг соёлын бусад арга хэмжээнүүд 50 гаруйг зохион явуулж давхардсан тоогоор 3000 гаруй хүнийг хамруулан үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн урлагийн байгууллага юм.

Соёлын үйлчилгээний SWOT шинжилгээ:

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Хөгжмийн зэмсэг, техник хэрэгслэлээр бүрэн хангагдсан. • Үндэсний урлагийг сурталчлан зааж сургаж байгаа • Иргэдийн нийгэм ахуйн болон хувийн соёл дээшилсэн • Дуу хөгжмийн,бүжгийн дугуйлан хичээллүүлж байгаа • Компьютер, техник хэрэгсэлийг ашиглан иргэдэд соёл урлагийн үйлчилгээг түргэн шуурхай өгөх, сурталчлах нөхцөл бүрдсэн • Ардын авьяастнуудын ур чадвар, идэвх санаачлага сайн 	<ul style="list-style-type: none"> • Соёлын төвийн барилга стандартын шаардлага хангаагүй • Явуулын үйлчилгээний унаа, санхүүгийн байдал хомс • Эртний үнэт эд зүйлсээ хадгалж өвлөн сурталчилах зан үйлээ өвлүүлэх ажиллагаа дутмаг • Нүүдэлчний соёл иргэншил орхигдож байгаа • Номын сангийн тохижилт, номын фонд бүрдүүлэлт тааруу • ОНСудлах кабинет байгуулан эд өлгийн зүйлээр баяжуулах санхүү дутмаг • Ажлын байр хүрэлцээгүй, нөхцөл тааруу • Мэргэжлийн боловсон хүчин дутмаг • Байрны халаалт шаардлага хангахгүй байгаа
Боломж	Саад бэрхшээл

<ul style="list-style-type: none"> • Төрөөс баримтлах соёлын бодлого ЗГ-ын тогтоол шийдвэр үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа • Хөтөлбөр төсөлд хамрагдах боломжтой • Иргэд урлаг соёлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох 	<ul style="list-style-type: none"> • Хүн ам цөөн • Явуулын үйлчилгээ үзүүлэхэд багийн айл өрх алслагдсан байрлалтай • Төсөв санхүү дутагдалтай • Түлш халаалтын зардал хавар, намар хуваагдаж ирдэг
--	---

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдсан асуудлууд	Хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
-Шинэ соёлын төвийн барилга барих	ССАЖЯ –нд хандах
-Явуулын үйлчилгээний машинтай болох	ССАЖЯ, УИХ-ын гишүүдэд хандах, төсөл хөтөлбөрт хамрагдах
-Номын фондыг нэмэгдүүлэх	Төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.
-Урлагийн хувцас, хөгжим, техник хэрэгслэлийн хангалт	Өөрийн орлого, ОНХСан, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

ХИЛ ХАМГААЛАХ АЛБА

Хилийн 10 дугаар застав

Тус сумын нутаг “Зэрлэг”-ийн голд 1993.10.01-нд Хирвэстэйн хээрийн застав байгуулагджээ. Тус застав нь Хөвчийн долоон нуураас Булган аймгийн Тэшиг сумтай хил залгадаг Илэнх гол хүртэл улсын хилийн дагуух битүү уул, ойгоор хүрээлэгдсэн 48 километр газрыг хариуцан хамгаалах үүрэгтэй.

Одоо хошууч Н.Мөнхбат даргатай, сургалт эрхэлсэн орлогч а/д Б:Батмөнх, СЗСС-ийн орлогч хошууч Ц.Батбаяр, ХХЗА хариуцсан тагнуулын ажилтан а/д Г.Цоодол, жагсаалын дарга а/а Д.Эрдэнэбилэг, механик жолооч а/а Ц.Ганзориг нар болон бусад хилчдийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Төр, нийгмийн халамж, хөдөлмөрийн үйлчилгээ

Эрдэнэбулган сумын нийгмийн халамжийн үйлчилгээ нь нийгмийн даатгалын салбарын нэг хэсэг байсан бол Нийгмийн халамжийн тухай хууль 1996 оны 2-р сарын 01-нээс хэрэгжиж, бие даан тустай орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Тус суманд нийгмийн халамжийн үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн төрлөөр үйлчилгээгээ явуулж байна. Тус суманд нийгмийн халамжийн сангаас 2013 онд 897 иргэнд 260376,6 мянган төгрөгийг зарцуулсан. 2014 онд 304891.2 мянган төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Эрдэнэбулган сумын нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллага нь 1995 оноос эхлэн Нийгмийн даатгалын багц хуулиудыг хэрэгжүүлж эхлээд даруй 19 жил өнгөрч байна.

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, даатгуулагч, ажил орлогыг бүртгэж даатгалд хамруулах, шимтгэл орлогыг хурааж сан бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангаж, уг сангаас иргэдэд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоолгох ажлыг сумын хэмжээнд явуулж ирлээ. Энэ хугацаанд УИХ-аас даатгалын хуулиудыг боловсронгуй болгох үндсэн дээр уг хуулиудыг 5 удаа нэмэлт өөрчлөлт орсон. Үүнийг тухайн бүрд нь хэрэгжүүлж иргэдэд өргөн хүрээтэй сурталчилж ирлээ.

Нийгмийн даатгалын тухай ойлголт нь хувь хүний орлого олж амьдрах чадвар нь ямар нэгэн хэмжээгээр буурч, нийгмийн баталгаа алдагдах зайлшгүй тохиолдлоос холбогдсон харилцаа юм.

Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар нийгмийн даатгал гэдэг нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, даатгуулагч арга хэмжээ мөн гэж тодорхойлсон байдаг энэ агуулгын хүрээнд сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж ирлээ.

Манай сум 350 тэтгэвэр авагчтай үүнийг цаг хугацаанд тэтгэвэр, тэтгэмж зэрэг 5 сангаас олгож байна.

Төр, нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн үйлчилгээний SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • НД-ын тухай хуулийн сурталчилгаа сайн, иргэн бүрт хүрч ажилладаг. • Сумын хөдөлмөрийн насны бүх хүн НД-ын нөхөн төлөлтөнд хамрагдаж чадсан • Тэтгэвэрт гарах хүний тоо нэмэгдэж байгаа. • Халамжийн төсөв хүрэлцээтэй • Суманд хөдөлмөр үйлчилгээний мэргэжилтэй болсон • Нийгмийн бүх давхаргаас бүрдсэн АДЗ-ийн гишүүдийн шийдвэрээр халамжийн үйлчилгээг орон нутагтаа шийдвэрлэдэг 	<ul style="list-style-type: none"> • Сайн дурын даатгалын хураамжийг сар бүр төлөх боломж иргэдэд тэр бүр байдаггүй тул төлөлтөөс хоцордог. НД-ын шимтгэлийн төлөлт тасардаг. • Төсөв хүрэлцээтэй боловч хуулийн хүрээнд зарцуулдаг болохоор зорилтот бүлгийн иргэдэд зарцуулж чадахгүй буцаадаг • Иргэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаар мэдээлэл муу
Боломж	Саад бэрхшээл

<ul style="list-style-type: none"> • Цаашид бүх иргэнийг НД-д хамруулах боломжтой. • Судалгаанд тулгуурлан иргэн бүрт хүрч ажиллах • ХЭД Сан, ЖДҮ хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сангаас иргэд, ААН байгууллагууд төсөл хэрэгжүүлж, орлогоо нэмэгдүүлэх боломжтой • Ажил хайгч иргэн нь хөдөлмөрийн биржид бүртгүүлж, ажлын байраар хангагдах • Зорилтот бүлгийн иргэд бүлэг болж, сургалтын төсөлд хамрагдаж, оюуны хөрөнгө оруулалтыг дэмжих боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Иргэдийн хугацаат төлбөр хийх чадвар сул, тогтмол орлогогүй байдаг • Олон шат дамжлагаар хөрөнгө шийдэгддэг тул иргэдэд хурдан шуурхай хүргэх боломжгүй • Иргэдийн идэвх, санаачилга, оролцоо сул • Үйлчлүүлэгчийн зан харилцаа, хандлага, мэдлэг боловсрол харилцан адилгүй байдаг нь ажилтанд хүндрэлтэй байдаг
---	--

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:


Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
<ul style="list-style-type: none"> • Сайн дурын даатгалын хураамжийг сар бүр төлөх боломж иргэдэд тэр бүр байдаггүй тул төлөлтөөс хоцордог. НД-ын шимтгэлийн төлөлт тасардаг. 	<p>Хуулинд өөрчлөлт оруулснаар, орлогыг жилдээ 1-2 удаа төлдөг болохоор зохицуулалт хийгдэнэ</p>
<ul style="list-style-type: none"> • Төсөв хүрэлцээтэй боловч хуулийн хүрээнд зарцуулдаг болохоор зорилтот бүлгийн иргэдэд зарцуулж чадахгүй буцаадаг 	<p>ИТХ болон АДЗ-ийн хурлаар зарцуулж болох халамжийн үйлчилгээний төрлүүд дээр журам боловсруулах ба шийдвэр гаргаж, орон нутагтаа зарцуулдаг болох</p>
<ul style="list-style-type: none"> • Иргэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний талаар мэдээлэл муу 	<p>Сургалт суртчилгаа, мэдээллийг тасралтгүй хүргэх</p>

Байгаль орчны салбарын хөгжил:

Сумын нутаг дэвсгэр нь нийт 469,4 мян.га талбайтай. Үүнээс газрын нэгдмэл сангийн ангиллаар нь авч үзвэл хөдөө аж ахуйн газар нь 116283.6 га, хот тосгон бусад суурины газар 309 га, зам шугам сүлжээний газар 195.4 га, ойн сан бүхий газар нь 350815 га, усны сан бүхий газар 1835 га-г тус тус эзэлж байна. Сумын ой нь



гарал үүслийн хувьд аясаараа сэргэн ургасан байгалийн ой бөгөөд ойн хэлбэрийн хувьд ихэвчлэн энгийн ой байх ба хөгшин



моддын

доогуур залуу модод ташинга үүсгэж ургаснаас нийлмэл ой үүссэн. Үүнийг ой үүсгэгч үндсэн мод тус бүрээр авч үзвэл 281375 га-г буюу 87,2 %-ийг шинэс, 28 га-г буюу 0,008%-ийг нарс, 16676 га-г буюу 5,2%-ийг хуш, 22167 га-г буюу 6,8%-ийг хус, 249 га-г буюу 0,07%-ийг улиас, 42 га-г буюу 0,013 %-ийг улиангар, 2081 га-г буюу 0,64%-ийг бургас тус тус эзэлдэг. Ойн сангийн нийт нөөцийн 84,5% буюу 41655610 шоо метр нь болц гүйцсэн хөгшин ой, 10,24% буюу 5072840 шоо метр нь болц гүйцэж яваа ой, 5,56% буюу 2757410 шоо метр нь дунд насны ой, 0.15% буюу 73890 шоо метр нь залуу ойг эзэлдэг.

Нөөц: Ойн сангийн нийт нөөц нь 49.559.750 мянган шоо метр байна гэж тогтоогдсон.

Аж ахуйн төрөл тус бүрийн нөөцийн эзлэх хэмжээ

Д/д	Аж ахуйн төрөл	Нөөц /шоо.метр/
1	Цармын бүсийн ой	5606170
2	Ногоон бүс	1630690
3	Хориотой зурвасын ой	4905700
4	30 хэмжээнээс дээш налуу газрын ой	18501110
5	Улсын хилийн дагуух ой	1418290
6	Ашиглалтын бүсийн ой	17497790
Дүн		49559750

“БАЙГАЛЬ ОРЧИН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТАСАГ” нь сумын Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 173 тоот захирамжаар байгуулагдан тасгийн даргаар - Засаг даргын орлогч Б.Эрдэнэнаран, тасгийн нарийн бичгийн дарга газрын даамал Б.Энхмаа, БОУБайцаагч -



С.Баярсайхан, ойн мэргэжилтэн - Д.Дагва, байгаль хамгаалагч - Я.Лхагваа, Н.Жавхланта, Б.Цэрэнлхам, Цаг-Уурын өртөөний хамт олон - Н.Энхцэцэг, С.Батцэцэг, А.Түмэнсайхан, Б.Ариунболд, О.Оюунтуяа, И.Нямдорж, ХАА-н мэргэжилтэн - Э.Идэр, Тул сангийн менежер – М.Амараа нар ажиллаж байна.

Тасгийн зорилго: Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэн ажиллах, эрх бүхий албан тушаалтныг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахад оршино.

Цаг уурын өртөө: Монгол орны уур амьсгалыг судлах зорилгоор цаг агаарын элемент үзэгдлийг нүдэн баримжаа ба багажаар ажиглаж, тэмдэглэж, боловсруулах, мэдээллэх, тойм мэдээгээр малчид, аж ахуйн нэгж байгууллагад үйлчлэх, ус цаг уурын урьдчилан мэдээлэх албанд өдөр бүрболж буй аюултай, онц аюултай үзэгдлийн мэдээг тогтоосон журмын дагуу мэдээлэх, монгол орны уур амьсгалын судалгаа сар жилийн эмхтгэл, лавлах боловсруулахад шаардагдах мэдээ материалыг цуглуулах гэсэн үндсэн зорилготой.

Бидний уриа:

Хүйтэн бороо , цасан шуурга, ган гачиг
Хуй салхи, аянга цахилгаан, үер уснаас
Хүн ард, түмэн олноо сэрэмжлүүлэх Хүндтэй
үүргээ умартаж үзээгүй



ЦАГ УУРЧИД БИД.

Анх цаг уур нь 1967 онд Агроцаг уур харуул нэртэйгээр анхны суурь нь тавигдаж, орон нутгийн цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, цаг агаарын аюултай үзэгдэл, элемент, ХАА-н цаг уур, бэлчээрийн ургамлын болон хөнөөлт хортон шавьж, мэрэгчдийн ажиглалт зэргийг хийж мэдээ мэдээллийг дотоодын болон олон улсын сүлжээнд оруулах үүргийг



хүлээхийн зэрэгцээ цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг улирал, сар, 7 болон 5 хоногоор хүлээн авч орон нутгийн иргэд, байгууллага, малчдад түгээн ажиллаж байна. 1974 оноос Ус судлалын харуулын ажиглагчаар Шаравын Загдаа, Дамчаагийн Баасан, Мэндбаярын Оюумаа, Балингийн Наранцэцэг нар тус тус ажилласан. 2013 оны 1 дүгээр сарын 1-ээс Цаг уурын станц болон өргөжиж Н.Энхцэцэг Б.Ариунболд О.Оюунтуяа, С.Батцэцэг, А.Түмэнсайхан, Ус судлалын харуулын ажиглагч И.Нямдорж нарын 6 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.



ТУЛ САНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Байгаль хамгаалах “Монголын Тул” сан нь дэлхийд судлагдаагүй тул загасыг анх судлан хамгаалах үйл ажиллагааг эхлүүлсэн нь бидний ажлын бахархал юм. Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган, Тариалан, Алаг-Эрдэнэ, Чандмань-Өндөр, Цагаан-Үүр, Хатгал, Булган аймгийн Хутаг-Өндөр, Тэшиг сумдын нутаг ялангуяа тэдгээр сумдын нутгаар дайрч урсдаг Эг,Үүрийн голуудын сав газрын байгаль орчин Монголд төдийгүй дэлхийд ховордож байгаа тул загасыг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа явуулахаар 2003 оноос үүсгэн байгуулагдан ажиллаж байна.

Хамтран ажилладаг байгууллагууд: Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Свийтватер трейвель, Хөвсгөл трейвель, Трибутари Сан, Биологийн хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн, АНУ-ын Висконсин-Мадисоны их сургууль, Невада-риногийн их сургууль, Калифорина-Дависын их сургууль зэрэг болно.

Төслийн хүрээнд: Тул загасны судалгаа шинжилгээ /ус болон ой бусад загас/, байгаль хамгаалах ажил, төслийн хамрагдаж буй сургуулиуд дээр байгальд ээлтэй сурагчдын Эко-клуб байгуулсан, сав газрын хэмжээнд байгаль орчны хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хэрэг зөрчлийг бууруулах зорилгоор дээр дурдсан сумдын улсын байцаагч нарт мотоцикль, дүрэмт хувцсаар ханган ажиллаж байна.

Цаашид хийгдэх ажил: Эг-Үүрийн голуудын сав дагууд байгаль орчин болон, байгаль хамгаалах, загасны судалгаа, үржүүлгийн ажлыг үргэлжлүүлэн явуулах, спорт загасчлалын бүс нутаг болгон хөгжүүлэн ажиллах зорилго тавин ажиллаж байна. Нутгийн иргэд болон аж ахуй нэгж, байгууллага, нутгийн удирдлага, БОТХБТасагтай хамтарч үйл ажиллагаа явуулна. Цаашдаа тус голын ай савд загасны нөөц хомсдвол үржүүлгийн ажлыг идэвхжүүлэн ажиллах болно.

Байгаль орчны **SWOT** шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Ой модны нөөц их • Байгалийн дагалт баялагтай • Спорт загасчлал хөгжүүлэх • Байгалийн унаган төрх • Рашаан болон гадаргын усны нөөцтэй • Байгалийн хадлан, тэжээл бэлтгэх боломжтой • Ан амьтан элбэгтэй 	<ul style="list-style-type: none"> • Мод боловсруулж эцсийн бүтээгдэхүүн хийх үйлдвэрлэл хөгжөөгүй • Иргэдийн эдийн засгийн чадавхи муу • Иргэдийн идэвх оролцоо сул, хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл муу сургалт сурталчилгааны ажил хангалтгүй. • Рашаан усны судалгаа бүрэн гүйцэд хийгдээгүй • Бэлчээрийн нөөц багатайгаас тодорхой газруудад бэлчээрийн даац хэтэрсэн

<ul style="list-style-type: none"> • Мод үржүүлэг хийх хөрсний чанар сайн. • Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн урт хугацааны төсөл хэрэгжиж байгаа. /2013-2023 он/ 	<ul style="list-style-type: none"> • Сумын хог хаягдлын цэг стандарт шаардлага хангагдгүй. • Байгаль дэлхийтэй харьцах хандлага муу • Нэгдсэн халаалтын систем байхгүй..... • Хүний буруутай үйлдлээс болж ой хээрийн түймэр гарч ойн санд их хэмжээний хохирол учруулдаг
Боломж	Саад бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Мод боловсруулах үйлдвэр байгуулах • Байгалийн болон спорт загасчлал усан аялал хөгжүүлэх • Байгалийн тодорхой төрлийн баялгийг иргэд, нөхөрлөлийн хэлбэрээр нэгдэн эзэмших, хамгаалах, ашиглах • Тарьц суулгац бэлтгэн зах зээлд нийлүүлэх боломжтой • Байгаль орчныг хамгаалах ерөнхий хуульд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн дагуу нөхөрлөлийн журмаар иргэн, аж ахуй нэгж, байгууллага гэрээгээр эзэмших эрх нээгдэж оролцоо сайжирсан. • Тусгай зөвшөөрлийн эрхийг орон нутгаас олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн тогтоц бүтэц нь бартаа саад ихтэй /ойн санг ашиглах боломж хязгаарлагдмал/ • Хөрөнгө оруулалтын эх үүсвэр мөнгөн дүн нь их, хүү багатай, урт хугацаатай зээлийн эх үүсвэр байхгүй /мод боловсруулах үйлдвэр/ • Бизнесийн орчин төлөвшөөгүй. • Улсын нийслэл болон аймгийн төвөөс алслагдсан • Тусгай зөвшөөрлийн эрх шат дамжлага ихтэй, олголт хязгаарлагдмал.

Тулгамдсан асуудлууд ба хэрэгжүүлэх гол арга хэмжээ:

Тулгамдаж буй асуудлууд	Шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэх гол арга хэмжээнүүд
<ul style="list-style-type: none"> • Ан амьтан, загасны нөөц тогтоолгох, түүний дагуу ашиглах эрх зүйн орчин бүрдээгүй 	<ul style="list-style-type: none"> • Нөөц тогтоолгох • Дээд шатны байгууллагад санал хүсэлт тавьж ан амьтан агнах эрх зүйн орчин бүрдүүлэх
<ul style="list-style-type: none"> • Улирлын байдлаас шалтгаалж бэлчээрийн усан хангамж мууддаг 	<ul style="list-style-type: none"> • Тухайн газар нутагт худаг, уст цэгийн тоог олшруулах
<ul style="list-style-type: none"> • Байгаль хамгаалах төсөв санхүүгийн боломж хязгаарлагдмал 	<ul style="list-style-type: none"> • Байгаль хамгаалах сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрт хамрагдаж тодорхой хөрөнгө татах
<ul style="list-style-type: none"> • Зарим газарт бэлчээрийн даац хэтэрсэн 	<ul style="list-style-type: none"> • Малчин өрхүүдийг бэлчээрийн нөөцтэй газруудаар шилжин суурьшуулах
<ul style="list-style-type: none"> • Хүний буруутай үйлдлээс болж ой хээрийн түймэр гарч ойн санд их хэмжээний хохирол учруулдаг 	<ul style="list-style-type: none"> • Эргүүл шалгалтыг тогтмолжуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэн хулгайн ан агнуурыг багасгах

Эрдэнэбулган сумын эдийн засгийн чадавхийн үнэлгээ

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

д/д	Үүргүүд	Үнэлгээ					Сумын дундаж
		1	2	3	4	5	
1	Маркетинг	8	20	36	4	0	2,5
2	Хөрөнгө, оруулагчтай холбоо тогтоох	2	22	26	14	4	2,9
3	Орон нутгийн бизнес эрхлэгч нартай холбоотой байх	2	8	34	20	4	3,2
4	Стратеги төлөвлөлтийн үйл явцыг дэмжих	0	20	32	12	4	3,0
5	Урамшуулал бий болгох санхүүжилт олгох	4	22	22	20	0	2,8
6	Ажиллах хүчний хөгжил	2	8	40	10	8	3,2
7	Эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх хянах	2	22	30	12	2	2,8
8	ОНЭЗХ-н төслүүдийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	2	14	26	20	6	3,2
9	Засаг дарга болон Иргэдийн хурлын зөвлөгөө мэдээллээр хангагдах түвшин	8	8	20	22	10	3,2
10	Эдийн засаг хөгжлийн асуудал хариуцсан төв байгууллагатай харилцаа тогтоон ажиллах	6	14	32	12	4	2,9
11	Мэдээллийн сан байгуулах	8	6	32	18	4	3,0
12	Үйл ажиллагаагаа тайлагнах	4	6	32	24	2	3,2
13	Олон нийтийн харилцаа	4	8	30	22	4	3,2
Д Ү Н							3.0

Тайлбар;

- 1- Маш бага чадавхтай, эсвэл тухайн үүрэг огт биелэгддэггүй
- 2- Тухайн үүрэг маш бага түвшинд биелэгддэг
- 3- Энэ чиглэлд хүчин чармайлт гаргаж байгаа, гэхдээ цаашид улам сайжруулах шаардлагатай
- 4- Энэхүү үүрэгт хамаарах сумын чадавх нь сайн
- 5- Сум нь энэхүү үүргийг маш сайн биелүүлдэг, өндөр хөгжсөн чадавхтай

Тус сумын өнөөгийн удирдлагад чадавхийн үнэлгээ хийхэд сум нь хөгжлийн стратеги төлөвлөлтийн үйл явцыг ач холбогдол өгч дэмжиж байгаа нь харагдаж байна. Мөн ажиллах хүчний хөгжил сайжирсан, урамшууллын болон санхүүгийн дэмжлэг нэмэгдсэн, хөрөнгө оруулагч болон орон нутгийн бизнес эрхлэгч нартай холбоо тогтоох, тэднийг дэмжих, олон нийтийн харилцаа сайжирсан гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Харин Засаг дарга болон Иргэдийн хурлын зөвлөгөө мэдээллээр хангагдах түвшин доогуур, мэдээ мэдээллийг хүргэх ажиллагаа хангалтгүй, орон нутгийн эдийн засгийн хөгжлийн төслүүдийг бэлтгэх, хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх ажиллагаа хангалтгүй байна гэсэн дүгнэлт гарч байна. Энэхүү үнэлгээний

дүнд цаашид дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Сумын чадавхийн үнэлгээний голлох дүгнэлтүүд:

1. *Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр төслүүдийг маш нарийн боловсруулж бэлтгэх*

2. Бэлтгэсэн төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийг татах, холбоо тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх

3. Иргэдэд мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, шуурхай хүргэх арга технологи нэвтрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлж ажиллах


4. Иргэд, *олон нийтийн санал санаачилгыг ач холбогдлоор нь дүгнэж, дэмжих, хамтран ажиллах, хамтын ажиллагааг хөгжүүлэх*

Эрдэнэбулган сумын бизнесийн орчны судалгааны үр дүн ба дүгнэлтүүд

Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад олон нийтийн оролцоог хангах, орон нутгийн үйлдвэрлэгчид, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн санал бодлыг тусгах, төр – бизнесийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхэд бэрхшээлтэй болон давуу тал юу байгааг тодорхойлоход энэхүү судалгааны ач холбогдол оршино.

Эрдэнэбулган сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд бизнес эрхлэгчид, малчдыг оролцуулан **25 хүнээс** бизнесийн орчны судалгааг авч дүн шинжилгээ хийв.

Бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл




Судалгаанд оролцогчдын 56% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 40% нь компани, 4 % нь хоршооны хэлбэрээр ажиллагсад байна. Эрхэлж буй бизнесийн төрөл хэлбэрээр нь харуулбал дараах байдалтай байна.



Судалгааны нэгтгэлээс харахад хугацааны хувьд бизнес эрхлэгчдийн 48% нь 0-3 жил ажиллаж байгаа шинэ бизнес эрхлэгчид, 16% нь 3-10 жил, 36% нь 11-ээс дээш жил үйл ажиллагаа явуулж байгаа дүнтэй байна.

Бизнесийн орчин, ирээдүйн байдлыг хэрхэн төсөөлж буйг тодруулахад Бизнес эрхлэгчид 100% бизнесийн ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж байна гэсэн хариулт өгсөн нь, 24% нь хэмжээг нь нэмэгдүүлэх, 24% нь эрчимжүүлэх, 40% чанарыг сайжруулах, 12% нь зах зээлээ өргөтгөх хүсэлтэй байна.


Бизнесийн өнөөгийн нөхцөл байдал




Графикаас харахад холбоо хүрэлцээтэй, зам, эрчим хүч, инженерийн байгууламж, түүхий эд материал, газар, санхүүгийн эх үүсвэр, мэргэжилтэй ажиллах хүчин дутагдалтай гэсэн байна. Иймд эдгээр асуудалд орон нутаг анхаарлаа хандуулж, дэмжлэг үзүүлэх, бодлого боловсруулж ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлт гарч байна.

Бизнес эрхлэгчид борлуулалтаа яаж нэмэгдүүлэх бэ?

гэсэн асуултанд Чанарыг сайжруулах-19%, захилагчаа зөв олох-16%, нэр төрлийг олшруулах-14%, борлуулах цэгээ нэмэгдүүлэх-12, шинэ зах зээл



Бизнесийн саад бэрхшээл



Судалгаанд оролцогчид бизнес эрхлэхэд хамгийн их саад болж буй хүчин зүйл нь зах зээлээс алслагдмал, мөнгө санхүүгийн дутмаг байдал, банкны өндөр хүү, хөнгөлөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамрагдах боломж муу, ажлын туршлага, мэргэжлийн ажиллах хүч дутмаг, шаардлагатай техник тоног төхөөрөмж, зориулалтын ажлын байр хүрэлцээгүй, иргэдийн орлого багассан, бараа бүтээгдэхүүний үнэ ханшийн өсөлт гэж хариулжээ.

Тэгвэл бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх, мэдлэг мэдээллийг нь дээшлүүлэх зорилгоор хэрэгцээт сургалтыг нь тодорхойлоход чадавч бэхжүүлэх, санхүү бүртгэл, менежмент, чанар, технологи, компьютерийн сургалтанд хамрагдах сонирхол ихтэй байна. Иймээс төр захиргааны зүгээс дээрх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулах шаардлагатай байна. Мөн ХАА-н чиглэлийн мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх шаардлагатай байна.


Бизнесийн үйл ажиллагаанд нийгмийн үйлчилгээ ямар нөлөөтэй вэ?

Тухайн бизнесийн үйл ажиллагаанд нийгмийн үйлчилгээ хэрхэн нөлөөлж байгааг тодруулахад Эмнэлэг, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээ, байгаль орчны хамгаалалт, байр орон сууцны хангамж их нөлөөтэй буюу



40–иас дээш хувийн нөлөөтэй банк санхүүгийн үйлчилгээ 50-аас дээш хувийн нөлөөтэй гэж хариулжээ. Сумын төр захиргааны үйл ажиллагааны нөлөөлөл болох дүрэм журмын зохицуулалт, албан тушаалтны чирэгдэл, авилга, хууль бус ажиллагааны талаар 60-аас дээш хувь нь нөлөөгүй гэж хариулсан байна. Ийм учраас манай сумын хувьд төр захиргааны байгууллага болон бизнес эрхлэгчид хамтран ажиллах боломж харагдаж байна.


Төрийн байрууллага, албан тушаалтан бизнес эрхлэгчидтэй хэрхэн харилцаа холбоотой ажилладаг вэ?



Сумын удирдлага, албан тушаалтнуудтай хэрхэн харилцаа холбоотой ажиллаж байгааг тодруулахад ихэнх албан тушаалтнуудтай дунд зэрэг, татварын байцаагч, сайн харилцаатай гэж хариулсан байна. Цаашид төр захиргаа болон бизнес эрхлэгчдийн хоорондын харилцааг сайн түвшинд хүртэл хамтарч ажиллах шаардлагатай байна.

Төр захиргаанаас авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээ

Орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд нэн түрүүнд төр захиргааны зүгээс хатуу зөөлөн дэд бүтэц сайжруулах мөн ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх байдлаар ажлын байр гаргах, төр бизнесийн хамтын ажиллагааг




сайжруулах, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах, дэмжих, мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэхэд анхаарч мэдээлэл сургалтыг байнга зохион байгуулах, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, иргэдийн ухамсар, бэлэнчлэх сэтгэлгээг өөрчлөх тал дээр түлхүү анхаарч ажиллах шаардлагатай байна.

Сумын эдийн засгийн хөгжлийн өсөлтийн талаархи үзэл бодлыг нь тодруулахад

Үүнээс үзэхэд сүүлийн 5 жилд бизнесийн орчин сайжирсан нь харагдаж байгаа боловч цаашид бизнесийн таатай орчин бий болгоход төр захиргааны байгууллага болон бизнес эрхлэгчид хамтран ажиллах шаардлагатай байна.



Сумын хөгжилд оруулах таны хувь нэмэр



“Орон нутгийн эдийн засгийн хөгжилд оруулж чадах таны хувь нэмэр юу вэ?” гэсэн асуултанд хариулсан байдлаас дүгнэхэд бизнес эрхлэгчид цаашид үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөжүүлэх, ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын

байр гаргах, мал сүргээ өсгөн үржүүлэх, татвараа төлж, хандив өргөх, төрийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээг дэмжиж хамтран ажиллах замаар орон нутгийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулахад бэлэн байна гэсэн сэтгэлийг нь идэвхжүүлэн төр захиргаанаас дэмжин хамтран ажиллаж бизнесийн таатай орчин бүүрдүүлж болох боломж харагдаж байна.

Бизнес орчны судалгааны ерөнхий дүгнэлт

Бизнес орчны судалгаанаас харахад бизнес эрхлэгчид нь 100% бизнесийн ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж, цаашид үйл ажилгаагаа өргөжүүлэх хүсэлтэй байна. Бизнесийн гол саад бэрхшээл нь мөнгө санхүүгийн дутмаг байдал, зах зээлээс алслагдмал, газар хүрэлцээ муу, ажлын туршлага, мэргэжлийн ажиллах хүч дутмаг, шаардлагатай техник тоног төхөөрөмж дутагдалтай гэж хариулсан байна.

Бизнес эрхлэгчдээс сумын эдийн засгийн хөгжлийн өсөлтийн талаарх үзэл бодлыг нь тодруулахад сүүлийн 5 жилд бизнесийн орчин сайжирсан гэж дүгнэж болохоор байна.

Цаашид төр захиргаанаас хатуу зөөлөн дэд бүтэц сайжруулах, ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх байдлаар ажлын байр гаргах, төр бизнесийн хамтын ажиллагааг сайжруулах, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах, дэмжих, мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэхэд анхаарч мэдээлэл сургалтыг байнга зохион байгуулан бизнес эрхлэгчидтэйгээ хамтран ажиллаж бизнесийн таатай орчинг бүрдүүдэх боломж байна.

_____ оОо _____

Гурав. СУМЫН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ЭРДЭНЭБУЛГАН сумын хөгжлийн АЛСЫН ХАРАА

ЭРҮҮЛ, ЧИНЭЭЛЭГ, ОЮУНЛАГ ИРГЭД БҮХИЙ БАЯЛГИЙГ БҮТЭЭГЧ, ЭКО СУМ БОЛНО.

Сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл

Уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуйг үр ашигтай хослуулан хөгжүүлэх асуудлыг хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж үзнэ. Орон нутгийн байгалийн болон бусад нөөцөд суурилсан аялал жуулчлал, жижиг, дунд үйлдвэрлэлийг сумын хөгжилд чухалчилна.

Хөгжлийн тэргүүлэх чиглэлд баримтлах бодлого, үзэл баримтлал

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд:

- Сумын бэлчээрийн даац боломжид тохируулан уламжлалт болон эрчимжсэн хэлбэрээр зохистой хослуулан хөгжүүлэх
- Тус сумын онцлог болсон үхэр, хонин сүргийг тогтвортой өсгөн ноос, сүүний ашиг шимийг нэмэгдүүлэх
- Адуун сүргийг хурдны угшлаар сайжруулах
- Нутгийн онцлогт тохирсон шилмэл сүргийг үржүүлэн нутагшуулж, нутгийн сайжруулсан хэвшлийг бий болгох

Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд:

- Стандарт шаардлагад нийцсэн гурил, тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, тойргийн сумдыг хангах
- Усалгаатай газар тариалан хөгжүүлэх эхлэлийг тавих
- Орчин үеийн шаардлага хангасан дунд оврын ХАА-н техникийн (үр тариа, төмс, хүнсний ногоо, нарийн ногоо тариалах) паркийг бий болгох
- ХАА-н мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх асуудлыг бодлогоор дэмжих
- Хүнсний аюулгүй байдлыг хангасан төмс, хүнсний ногоо хадгалах зоорины тоог нэмэгдүүлэх
- Эрдэнэбулган сумын хөрсөнд нутагшсан сайн чанарын үр (үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал)-тэй болох
- Далд хөрсний аж ахуйг дэмжих (хүлэмж)

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд:

• Бүс, нутгийн аялал жуулчлалын хөгжлийн чиглэл, мастер төлөвлөгөөнд тулгуурлан түүний бүрэлдэхүүн хэсэг байхаар бодож зохион байгуулж явуулах

- Эг, Үүрийн голын ай савын байгалийн үзэсгэлэнт газар, түүх, соёлын дурсгалыг түшиглэсэн аялал жуулчлалыг нэгдмэл иж бүрэн цогцолбор хэлбэрээр үе шаттай хөгжүүлэх

- *Сумын онцлогийг харуулсан байгальд ээлтэй, явган ба морин аялал, усан аялал, малчдын ахуйтай танилцуулах аялал зэрэг шилдэг бүтээгдэхүүнийг бий болгож, Хөвсгөлийн аялал жуулчлалын “Мөнгөн цагираг” сүлжээнд холбогдох*
- *Аялал жуулчлалыг дагасан төрөл бүрийн угтвар үйлчилгээг сайжруулах /соёл урлаг, хүнс, гар урлалын үйлчилгээ г.м/ Аялал жуулчлалын баазуудыг түшиглэн ахмадын сувилалтай болох*

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд:

- *Орон нутгийн нөөцийг ашигласан, аль болох нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнтэй байх*
- *Нутгийн брэнд болох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг голчлох*
- *МАН-н гаралтай бүтээгдэхүүнийг орон нутагтаа боловсруулан нутгийн брэндийн түвшинд хүргэх*
- *Мах, сүү, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ зэрэг хүнсний голлох нэрийн бүтээгдэхүүнээр сум өөрийнхөө хэрэгцээг бүрэн хангаж, зах зээлд нийлүүлэх*

Төлөвлөгөөний хамрах хугацаа, үе шатууд

Сумын хөгжлийн энэхүү стратеги төлөвлөгөө нь 2013-2021 оныг хамран хэрэгжих бөгөөд дараах үе шатуудтай байна. Үүнд:

1-р үе шат	2013-2015 он
2-р үе шат	2016-2019 он
3-р үе шат	2020-2021 он

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ: Хөгжлийн төлөвлөгөөг сурталчлан таниулах, хөгжилд шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, хөгжлийн суурь нөхцлийг хангах үе шат **2013-2015 он**

- Хөгжлийн төлөвлөгөөг сурталчлан таниулах, олны хүртээл болгох
- Тодорхой төслүүдийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх, хөрөнгө босгох
- Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт, эрх зүйн болон мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтэрч, бүтээн байгуулалтын суурь орчин бүрдүүлэх

ХОЁРДУГААР ҮЕ ШАТ : Хөгжлийн төлөвлөгөөний эрчимтэй хөгжлийн үе шат 2016-2018 он

- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөх, иргэдэд хурдан шуурхай, хүртээмжтэй, мэргэжлийн, ур чадвар, сэтгэл ханамжийн өндөр түвшинд үйлчлэх тав тухтай орчин бүрдүүлэх
- Монгол мал хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, МАН-н тогтвортой өсөлтийг хангасан, бүтээгдэхүүний чанар, үнэлэмж сайжирсан, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих ажиллагаа
- Бизнес эрхлэх эрх зүйн болон санхүүгийн таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг сайжруулах замаар бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх

- Байгалийн нөөцийн судалгаа, ашиглалт, хамгаалалт, байгалийн баялагт түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийг дэмжих
- Орон нутгийн нөөц, онцлог давуу талд түшиглэсэн ЖДҮ-лэл, үйлчилгээг өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх
- Харилцан ашигтай гадаад, дотоод харилцааг хөгжүүлэх

ГУРАВДУГААР ҮЕ ШАТ : Нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хөгжлийн ололт амжилтыг бэхжүүлэх, хөгжүүлэх үе шат 2019-2021 он

- Алсын хараанд хүрэхэд тэмүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах
- Эдийн засгийн тогтвортой өсөлт бий болсон, санхүүгийн хувьд бие даах
- Үйлдвэрлэл үйлчилгээний ажиллагаа тогтмолжиж, үр ашиг дээшилсэн, гадаад, дотоод зах зээлд нийлүүлэх
- Сумын хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан зорилтот түвшинд хүргэх

Төлөвлөгөөний хүрээний зорилго, зорилт, хөтөлбөр, төслүүд:

Сумын хөгжлийн хэтийн түвшинг тодорхойлсон Алсын хараанд хүрэхийн тулд дор дурдсан зорилго, зорилтыг хангах, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

ЭРДЭНЭБУЛГАН сумын хөгжлийн зорилго, зорилтын нэгдсэн матриц

ЗОРИЛГО		ЗОРИЛТ	
1.	ОРОН НУТГИЙН НӨӨЦӨД СУУРИЛСАН ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАЖ, ИРГЭДИЙН АМЬЖИРГААГ ДЭЭШЛҮҮЛЭХ	1.1.	Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлж үр ашгийг дээшлүүлэн нэгжийн ашиг шимийг тогтвортой өсгөх
		1.2.	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, нутгийн бренд бүтээгдэхүүний нэр, төрлийг олшруулан ДНБ-ийг 3 дахин нэмэгдүүлэх
		1.3.	Эрэлт хэрэгцээнд нийцсэн худалдаа, үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх
2.	БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН-ТАЛ ДҮҮРЭН ХӨГЖИЛ	2.1.	Хөгжилд шаардлагатай хатуу дэд бүтцийн сүлжээг хөгжүүлэх
		2.2.	Бизнесийг дэмжсэн зөөлөн дэд бүтцийг сайжруулах

3.	НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТАВ ТУХТАЙ ОРЧИНД ЦОГЦООР НЬ ЧАНАРТАЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭЖ ЭРҮҮЛ, ЧИЙРЭГ, ОЮУНЛАГ ИРГЭДИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ	3.1.	СӨБ-ын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн хамран сургалтыг 100 хувиас бууруулахгүй байх
		3.2.	ЕБ-ын үйлчилгээний орчинг сайжруулж, стандарт хангалтыг 80 хувьд хүргэх
		3.3.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж, өвчлөлийг 2 дахин бууруулах, дундаж наслалт, амьдралын чанарыг дээшлүүлэх
		3.4.	Соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж соёлтой, хүмүүнлэг иргэдийг төлөвшүүлэх
		3.5.	Иргэдээ хүндэлсэн, хуулийг дээдэлсэн төрийн үйлчилгээг ил тод, тэгш, шуурхай хүргэх
4.	БАЙГАЛЬ, ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨӨЦ, БАЯЛГИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ	4.1.	Хөрсний эвдрэлийг багасган орчны бохирдлыг бууруулах
		4.2.	Усны нөөцийг хамгаалж, хангамжийг сайжруулах
		4.3.	Биологийн төрөл, зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх

Энэхүү төлөвлөгөө нь тус сумын удирдлага, иргэд, хөдөлмөрчдөөс гадна аймаг, бүс, улсын хэмжээний бодлого боловсруулж шийдвэр гаргагчид, ТББ, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагч, хандивлагчдын дэмжлэгтэйгээр хэрэгжих үндэстэй тул дараах байдлаар хамтран ажиллах, оролцох, үүрэг хүлээх боломжтой.

<u>Хамтран ажиллах субъект</u>	<u>Хамтран ажиллах чиглэл, хүрэх үр дүн</u>
<u>Сумын төр захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагууд</u>	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөөг дэмжигч, хэрэгжүүлэгч байгууллага, сонирхогч иргэд, хуулийн этгээдийг зохион байгуулалт, арга зүйгээр дэмжих - • Хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын чуулга уулзалтыг зохион байгуулах, хандивлагчдад танилцуулах ажлыг чанартай зохион байгуулах - • Төлөвлөгөөнд туссан зорилго, зорилт, хөтөлбөр, төслүүдийг жил жилийн ажлын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах - • Төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, хурдан шуурхай, хүртээмжтэй хүргэх

<p><u>Сумын төр захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагууд</u></p>	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн төлөвлөгөөний тендер шалгаруулалтыг хуулийн дагуу ил тод нээлттэй, чанартай зохион байгуулах, хөтөлбөрийг дэмжигчдийн хувь, хандивийг зохистой зарцуулж, үр дүнг нийтэд мэдээлж ажиллах • Бусад аймаг, хотуудад амьдарч байгаа нутгийн иргэдийн нутгаа зорих, тус нутагт амьдран суугаа аав ээж, ахан дүүсээ дэмжихэд орон нутгийн төрийн байгууллагуудаас бүх талаар дэмжих, хамтран ажиллах
<p><u>Эрдэнэбулган сумын уугуул болон тус суманд ажиллаж амьдарч байсан хүмүүс, нутгийн зөвлөлүүд</u></p>	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн цахим сан үүсгэн хөгжлийн төлөвлөгөөг сурталчлах, мэдээлэх. • Өөр аймаг, сум, хотод ажиллаж амьдарч байгаа иргэдийн хамтран ажиллах санаачлагыг нэмэгдүүлэх, иргэдийг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагч, хандивлагч нарыг татах, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах
<p><u>Банк санхүү, хувийн хэвшлийн ААНБ, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагч, төсөл хэрэгжүүлэгч нэгж</u></p>	<ul style="list-style-type: none"> • Мэдээллийн цахим сан үүсгэн хөгжлийн төлөвлөгөөг сурталчлах, мэдээлэх. • Өөр аймаг, сум, хотод ажиллаж амьдарч байгаа иргэдийн хамтран ажиллах санаачлагыг нэмэгдүүлэх, иргэдийг идэвхжүүлэх, хөрөнгө оруулагч, хандивлагч татах, төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах
<p>ТББ, иргэд</p>	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санал санаачлага гаргах, дэмжлэг үзүүлэх • Хөтөлбөр төслөөс сонгон авч хэрэгжүүлэх, төрийн байгууллагатай хамтарч ажиллах, хөндлөнгийн хяналт тавих • Тайлан мэдээлэл сонсож, зөв мэдээлэл түгээх
<p>Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөр, сургалт мэдээллийн байгууллагууд</p>	<ul style="list-style-type: none"> • Сургалт, сурталчилгаа заавар зөвөлгөө өгч хамтран ажиллах • Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар цаг тухайд нь иргэдэд үнэн зөв бодит мэдээлэл өгөх • Хөтөлбөрт тодорхойлогдсон төслүүдийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд бусад аймаг, сум, байгууллагатай хамтран ажиллах

№	АЙМАГ СУМЫН НЭР	ХАМТРАН АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ	ХӨРШ АЙМАГ, СУМАНД САНАЛ БОЛГОХ БҮТЭЭГДЭХҮҮН	ХӨРШ АЙМАГ, СУМААС АВАХ БҮТЭЭГДЭХҮҮН
1	Булган аймгийн Тэшиг сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт	Жимс, жимсгэнэ, байгалийн дагалдат бүтээгдэхүүн	Загас, гахайн мах, рашаан

2	Хөвсгөл аймгийн Тариалан сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, бэлчээр ашиглалт	Хадлан, тэжээл, банз, палк	Цагаан гурил, бөөний бараа бүтээгдэхүүн, цахилгаан дамжуулах эх үүсвэр, өндөр хурдны интернет
3	Хөвсгөл аймгийн Их-Уул сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт	Зүсмэл модон материал, малын тэжээл, хадлан,	Бөөний бараа бүтээгдэхүүн,
4	Хөвсгөл аймгийн Түнэл сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, бэлчээр ашиглалт	Малын тэжээл	
5	Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, бэлчээр, сум дундын бүс нутаг тогтоох	Төмс, хүнсний ногоо, цагаан болон халтар арвайн бор гурил, малын тэжээл	
6	Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сум	Төсвийн болон бизнесийн байгууллагууд туршлага солилцох, сумдын спорт урлагийн нөхөрсөг уулзалт, нутаг бэлчээр, сум дундын бүс нутаг тогтоох	Төмс, хүнсний ногоо, цагаан болон халтар арвайн бор гурил, малын тэжээл	Нарсан банз
7	ОХУ-ын Буриад улсын Закаменск	Бизнесийн байгууллагууд туршлага солилцох, спорт урлагийн нөхөрсөг уулзалт	Малын тэжээл	Хөдөө аж ахуйн запас сэлбэг, үрийн төмс

**Дөрөв.ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ,
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ**

4.1.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээний төслүүд ба хөрөнгө санхүүгийн тооцоолол

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт **15379.0** сая төгрөгийн эх үүсвэр шаардлагатай бөгөөд үүнийг дараах эх үүсвэрээр хангахаар тооцоолж байна. Үүнд:

- Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр **9794.0** сая төгрөг буюу 63.7 хувь
- Орон нутгийн хөрөнгөөр **2009.4** сая төгрөг буюу 13.1 хувь
- Хөрөнгө оруулагчид, хандивлагчдын зардлаар **3575.6** сая төгрөг буюу 23.2 хувийг тус тус хангана.

Нийт **41** хөтөлбөр, **180** төсөлт үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд үүнийг салбараар авч үзвэл:

Дэд бүтцийг хөгжүүлж, бизнесийн орчин бүрдүүлэх **35** төсөл, **4377.0** сая төгрөгийн

Эдийн засгийн салбарыг хөгжүүлэх **55** төсөл, **3207.5** сая төгрөгийн

Төр, нийгмийн үйлчилгээг сайжруулах **68** төсөл, **7170.5** сая төгрөгийн

Байгаль орчныг хамгаалах хүрээнд **20** төсөл, **589.0** сая төгрөгийнх

Нэмэлт үйлчилгээний хүрээнд 2 төсөл, 35.0 сая төгрөгийнх байхаар төсөөлж байна.

Төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг төлөвлөгөөний холбогдох бүлэг болон төлөвлөгөөний хавсралт, хүснэгт, танилцуулгуудаас үзэж болно.

№	Зорилго	Хөтөлбөрийн тоо	Төслийн тоо	Төслийн нийт өртөг сая, төг/	Үүнээс		
					Орон нутгийн төсвийн хөрөнгөөр	Улсын төсвийн хөрөнгөөр	Хөрөнгө оруулагчид дэмжигч, хандивлагчдын хөрөнгөөр
1	Эдийн засгийн ажлын хэсэг	11	55	3207.5	183.0	945.0	2079.5
2	Бизнесийн ажлын хэсэг	11	35	4377.0	1379.7	2157.5	839.8
3	Нийгмийн салбарын ажлын хэсэг	14	68	7170.5	233.7	6586.5	350.3
4	Байгаль орчны ажлын хэсэг	4	20	589.0	200.0	85.0	304.0
Д Ү Н		40	178	15344.0	1996.4	9774.0	3573.6

4.2. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнгийн нэгдсэн шалгуур үзүүлэлтүүд

Сумын хөгжлийн төлөвлөгөөний үр дүнг тооцохдоо дараах ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэл болгож байна. Үүнд:

№	Гол үзүүлэлт	Хэмжих нэгж	Одоогийн түвшин	Хүрэх түвшин		
				2015 он	2018 он	2021 он
	Нэг хүнд ноогдох ДНБ	Мян.төг	1200.0	1250.0	1400.0	1700.0
	Сумын хүн ам	Тоо	2745	2770	2959	3148
3.	Сургуулийн суралцагчдын сурлагын амжилт	Хувь	75	78	80	85

4.	Сургуулийн мэргэжлийн зэрэгтэй багшийн хувийн жин	Хувь	40.6	46.8	50.0	56.2
5.	Бичиг үсэг үл мэдэгч	Тоо	49	44	29	10
6.	Сургуулийн өмнөх боловсролын стандарт хангалт	Хувь	78	84	90	95
7.	СӨБ-ын хамран сургалт	Хувь	100	100	100	100
8.	СӨБ-ын мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувийн жин	Хувь	50	66.0	100	100
9.	Соёлын мэргэжлийн боловсон хүчний хангалт	Хувь	50.0	60.0	100.0	100.0
10.	Соёл, урлагийн явуулын үйлчилгээний тоо	Тоо	9	15	20	25
11.	Соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдагчдын тоо	Хүн/тоо	3210	4000	4500	5000
12.	Соёл, урлагийн чиг баримжаат дугуйлан	Тоо	3	4	6	6
13.	Хүн амын өвчлөлийн түвшин	Хувь	31,6	30,0	28,2	27,5
14.	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт	Хувь	48,6	50,1	54,2	66,5
15.	Эрх зүйн төвөөр үйлчлүүлэгчдийн тоо	хүн	340	500	750	900
16.	Төрийн үйлчилгээний ажлын тайлан тавилтанд хамрагдагчид	хүн	1352	1364	1456	1548
17.	Ажилгүйдлийн түвшин	Хувь	25.6	20.0	15.0	10.0
18.	Ядуурлын түвшин	Хувь	6.2	5.0	4.2	3.5
19.	Нийгэм зүй, амьдрах ухааны сургалтанд хамрагдагчид	Хүн	165	200	250	300
20.	Сайжруулсан ба хатуу хучилттай зам	Км	23.0	35.0	45.0	80.0
21.	Инженерийн хийцтэй гүүр	Тоо	1	1	1	1
22.	Төвийн болон сэргээгдэх эрчим хүчний хангамжтай өрх	Хувь	90	95	100	100
23.	Үүрэн телефон хэрэглэгчид	тоо	1500	1950	2200	2350
24.	Бизнес эрхлэгчид (малчид ороогүй)	Тоо	41	55	65	80
25.	Бизнесийг дэмжих болон эрх зүйн үйлчилгээ үзүүлэгч цэгийн	Тоо	15	17	19	21
27.	Гадаад харилцаанд оролцох чиглэл	Тоо	1	1	3	6
28.	Малын тоо	Толгой	55423	55977	57085	58798
29.	Үхрийн тоо	Толгой	13474	13608	14017	14437
30.	Нэг ямаанаас авах ноолуур	Гр	0.240	0.240	0.260	0.300
31.	Хонины ноос	Кг	1.2	1.2	1.2	1.2
32.	Тариалангийн талбай	га	5090.0	5090.0	5090.0	5090.0
33.	Тариалсан талбай	га	2577.0	2577.0	2600.0	2700.0
34.	Нийт ургац	цн	2934.0	3100.0	3200.0	3400.0
35.	Нэг га-гаас авах ургац	цн	12.0	12.5	13.0	13.5

36.	Хүлэмжийн тоо	Тоо	6	6	7	9
37.	Төмс, хүнсний ногоо тариалалтын талбай	Га	12.4	12.4	14.0	16.0
38.	Нийт ургац	цн	115.0	120.0	130.0	140.0
39.	Жижиг, дунд үйлдвэр	Тоо	113.0	113.0	120.0	130.0
40.	Аялал, жуулчлалын баазын тоо	Тоо	4	4	5	7
41.	Аялал, жуулчлалын үйлчилгээ авагчид	Тоо	-	200	1000	2000
42.	Эрэлтэнд нийцсэн худалдаа, үйлчилгээний томоохон цэг	Тоо	-	1	3	6
43.	Ашиглагдахгүй байгаа бэлчээр	Га				
44.	Ойн нөхөн сэргээлт	Га	11.0	15.0	40.0	80.0
45.	Инженерийн хийцтэй худгийн тоо	Тоо	19	20	21	22
46.	Хог бүхий талбайн хэмжээ	Га	21.0	15.0	10.0	5.0
47.	Хадлангийн хашсан талбай	Га	70.0	300.0	800.0	1500.0

Төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт, үнэлгээ

Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын болон төгсгөлийн хяналт үнэлгээг ИТХ, ТХХ-оос хамтран зохих журмын дагуу зохион байгуулж байна. Хяналт үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний хэрэгжилт биелэлтийн явцыг үе шаттайгаар тодорхойлох, явцыг эрчимжүүлэх явдал мөн.

Сумын хөгжлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн явцад сумын ИТХ болон ЗДТГ, сумын төлөвлөлт хяналтын хорооны зэрэгцээ сумын төрийн бус байгууллага, иргэд хяналт зохих хэмжээгээр тавьж оролцоно.

Хяналт, үнэлгээг төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний үе шат, дунд хугацааны үе шат, төгсгөлийн үе шатны гэсэн үе шаттайгаар хянаж дүгнэлт гаргах ба энэ үйл ажиллагааг зохион байгуулахдаа сумын төлөвлөлт, хяналтын хорооны үйл ажиллагааны журмыг удирдлага болгоно..

Төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатны үнэлгээг 2016, 2019, 2022 оны эхний улирлуудад тус тус зохион байгуулна. Үе шатны үнэлгээний зэрэгцээ төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын үнэлгээг жил бүрийн эцэст болон тухайн төслийн хэрэгжилтийн дунд хугацаанд хэрэгжүүлж байна.

Хяналт, үнэлгээг явуулахдаа төсөл тус бүрийн танилцуулгад тодорхойлсон болон ерөнхий шалгуур үзүүлэлттэй жишиж харьцуулах ба тогтоосон баталгаажилтын эх үүсвэрүүдийг үндэслэл болгож байна.

Сумын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжлийн хяналт, үнэлгээ явуулсан тухай бүр иргэд, олон нийтэд ил тод мэдээлж байх ба мэдээллийн тусгай самбарыг тогтмол ажиллуулна.

Хяналт, үнэлгээний дүнг үндэслэн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулах асуудлыг сумын ИТХ, ТХХ хамтран шийдвэрлэж байна. Энэ ажиллагаанд зохих журмыг удирдлага болгоно.

**ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТЫН ХОРОО,
АЖЛЫН ХЭСЭГ**

2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр

ХӨВСГӨЛ аймгийн ЭРДЭНЭБУЛГАН сумын 2013-2021 оны хөгжлийн стратеги төлөвлөгөөг боловсруулах график
(Сумын Төлөвлөлт, хяналтын хороо, зөвлөх баг хамтран хэлэлцэж тодорхойлов. 2013.07.28. БУЛГАН ТАЛ)

№	Хийх ажил	Гүйцэтгэх хугацаа	Хариуцах эзэн
1	Сумын засаг даргатай харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ) байгуулах, Сум хариуцлагатай хандах, мэдээллийг зохих шатанд түгээх ажлыг заавал хийх	2013-05 сард	Аймгийн зөвлөх-хөтөч, сумын чиглүүлэгч Б.Эрдэнэнаран, сумын Засаг дарга Д.Батхүрэл
2	Олон нийтэд мэдээлэл түгээх, оролцогч талуудыг тодорхойлж идэвхжүүлэх	Байнга	Сумын ЗД, ЗДТГ, чиглүүлэгч болон бусад манлайлагчид, АХ, ТХХ-ны багийнхан
3	Төсөөллийн семинар хийж ажлын хэсэг (АХ), төлөвлөлт, хяналтын хороо (ТХХ)-г байгуулах, албан шийдвэр хариуцлагатай гаргах	2013.07.10	Сумын удирдлагууд, оролцогчид, чиглүүлэгч Б.Эрдэнэнаран
4	СМТ боловсруулах бүтэц (АХ, ТХХ-ны гишүүд)-ийг оролцооны арга зүйд сургах	2013.07.24-28	Сумын ЗД, сургагч багш зөвлөх, аймгийн зөвлөх-хөтөч, чиглүүлэгч Б.Эрдэнэнаран, ТХХ-ны дарга Г.Батчулуун
5	Эхлэлийн семинарийн бэлтгэлийг ханган зохион байгуулж, тулгамдсан асуудлыг тогтоох	2013.07.27	Ажлын хэсэг, ТХХ-ны гишүүд, Иргэний танхим Х.Гэрэлтуяа
6	Тулгамдсан асуудал бүрээр “Асуудлын болон шийдлийн мод”-ны үнэлгээ хийх	2013.07.25-27	Ажлын хэсэг болон ТХХ-ны гишүүд
7	Оролцооны үнэлгээ хийх дүнг нэгтгэн СЭЗХТ-д тусгах	2013.07.25-2013.08.31	Ажлын хэсэг-Б.Эрдэнэнаран, ТХХ-ны гишүүд Бүлгийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар

Үүнд: а/ Сумын ЭЗХ-ийн одоогийн байдлыг тогтоох, судалгаа хийж мэдээлэл цуглуулах, төлөвлөлтөнд ашиглах	2013.07-08 сар	Ажлын хэсэг голлох, ТХХ-ны гишүүд Бүлгийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар
б/ Бизнес орчны судалгаа (БОС) хийх. 60-70 хүнээс авах, нэгтгэн дүгнэлт хийх	2013.07-08 сард багтаан авч, нэгтгэлийг хийж дуусгана.	Ажлын хэсэг-Э.Батбаатар, Э.Идэр, С.Баярсайхан, Ө.Батжаргал нарын баг зохион байгуулж, бусад оролцогчид тусгай хуваариар хариуцах ба бизнесийн болон бусад бүлгүүд дүгнэлт гаргаж төлөвлөгөөний хэсэг тус бүрт ашиглах
в/ SWOT шинжилгээ хийх, хослолын стратеги гаргах, байгууллага, салбар бүрээр гаргах	2013.07-08 сар	Г.Батчулуун, Б.Анхбаяр, Б.Мандахбаяр нар голлох ба хуваарийг сайжруулан гаргаж, ТХХ-ны бүлгүүд материалыг ашиглах, салбар, албан байгууллагын эрх баригч нар, багийн дарга нар оролцоно. ЗДТГ зохион байгуулалтанд оролцоно.
г/ Олон нийтийн хэлэлцүүлэг 3-аас доошгүй удаа явуулах	2013.07-08 сар	Чиглүүлэгч Б.Эрдэнэнаран, Ажлын хэсэг, ТХХ-хон Бүлгийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар иргэний танхим-Х.Гэрэлтуяа
д/ Фокус бүлгийн ярилцлага хийх. Хуваарийг дахин нарийвчлан гаргаж, тэр дагуу гүйцэтгэх.	2013.07-08 сар	Г.Батчулуун, Б.Анхбаяр, Б.Мандахбаяр голлож тусгай гаргасан хуваариар ажиллах. Байгууллага, салбарын төлөөлөл, олон нийтийн байгууллагуудыг оролцуулах. Зарим хэсэгт Иргэний танхим Х.Гэрэлтуяа хамтрах
е/ Ганцаарчилсан ярилцлага хийх, Нэр, хариуцах хүмүүс хуваариар хийнэ, Факс, утас, Майл хаягийг олох	2013.07-08 сар	О.Нанжид, Д.Батхүрэл, Ж.Оюунбилэг, А.Мөнхтөр, М.Эрхбаяр нар голлон хариуцаж зохион байгуулах
ж/ Бичил семинар хэлэлцүүлэг. БИНХ-ын дарга, ИТХ-ын төлөөлөгчид баг бүрт зохион байгуулан дүнг өгнө	2013.07-08 сар	Ажлын хэсэг, ТХХ-ны гишүүд, ИТХ-аас чиглүүлэх
з\Сумын чадавхийн үнэлгээ хийх-100 хүнээс	2013.07сар	О.Нанжид, Д.Батхүрэл, Ж.Оюунбилэг, А.Мөнхтөр, М.Эрхбаяр нар хариуцан авч нэгтгэх

	и\Саналын хуудас гарган санал авах. Нийт 400-аас доошгүй хүнээс авна.	2013.07-08 сар	Б.Эрдэнэнаран, Б.Цэцэгмаа, Ч.Оюунчулуун, Б.Ням-Осор, Б.Давааням нар голлож багийн Засаг дарга нар хариуцах
	к/ Өсвөр үеийнхэн, оюутнуудын зохион бичлэгийн уралдаан дунд арга хэмжээ зохион байгуулах. Сумаас бодлого гаргаж, урамшууллын асуудлыг шийдэх	2013.07-08 сар	Хүний хөгжил, нийгмийн ажлын бүлэг зохион байгуулж, сургууль, цэцэрлэг, оюутны байгууллага Б.Анхбаяр, Б.Ням-Осор нар хамтрах
	л\ Бичил семинар-бизнес эрхлэгчдийн уулзалт ярилцлага	2013.07-08 сар	Бизнесийн болон эдийн засгийн ажлын бүлэг –Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл
	м\ Аймгийн салбар хариуцсан хэлтсүүд, агентлаг, аймаг, Улаанбаатар дахь нутгийн зөвлөлтэй санал солилцох ажлыг хийх	2013.07-09 сард	Засаг дарга Д.Батхүрэл, ИТХ-ын дарга П.Ариунсан нар голлож бусадтай хамтрах
	н\Багийн өдөрлөг, бусад арга хэмжээнүүд зохион байгуулж санал солилцох, хайрцаг аялуулах, дэвтрээр санал авах	2013 оны 07-08 дугаар сард багтааж	Засаг дарга, ИТХ-ын дарга, багийн Засаг дарга нар, Бүлгийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар
	о\Сум, орон нутгийн сонин, телевиз, FM ашиглан мэдээлэл, суртчилгаа хийх, мэдээлэл авч ажиллах	2013.07-08 сард	Иргэний танхим Х.Гэрэлтуяа, ажлын хэсэг Б.Эрдэнэнаран
8	Оролцооны үнэлгээ, судалгааны үр дүнг нэгтгэх болон мэдээлэл боловсруулах, сайжруулах	2013.07-08 сард	Ажлын хэсэг, ТХХ-ны ажлын бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар
	Стратеги төлөвлөгөөний бүлгүүд болон Алсын хараа, зорилго, зорилт, хөтөлбөр, төслүүдийг боловсруулах	2013.07-08 сард	Ажлын хэсэг, ТХХ-ны ажлын бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар
	Үүнд: а/ Стратеги төлөвлөгөөний алсын хараа, зорилгыг тодорхойлон бичих, өөрчлөн сайжруулах	2013.07-08 сард	Ажлын хэсэг, ТХХ-ны ажлын бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар

б/ Стратеги төлөвлөгөөний зорилтуудыг тодорхойлон бичих	2013.07-08 сард	Ажлын хэсэг болон ТХХ-ны ажлын бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар
в/ Стратеги төлөвлөгөөний хөтөлбөр, төслүүдийг тодорхойлон бичих	2013.07-08 сард урьдчилсан байдлаар бэлэн болгох	Ажлын хэсэг, ТХХ-ны ажлын бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар дотроо хуваарь гаргах
г/ 1-р бүлэг, ИТХ-ын болон засаг даргын үг ба оролцооны үнэлгээний үйл явцыг дүгнэн бичих, аймгийн Засаг даргын илгээлт	2013.07-08 сард	Засаг дарга Д.Батхүрэл, ИТХ-ын дарга П.Ариунсан, чиглүүлэгч Б.Эрдэнэнаран нар хариуцаж, бусад бүлгүүдийн оролцоотой бэлтгэх
д\Удиртгал хэсгийг боловсруулах	2013.07-08 сард	Засаг дарга Д.Батхүрэл
е\Төлөвлөгөөний хураангуйг бэлтгэх	2013.07-08 сард	Ажлын хэсэг, ТХХ-хон Бүлгийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар
ж/ 2-р бүлэг, Сумын товч танилцуулга бичих	2013.07-08 сард	ИТХ-ын дарга П.Ариунсан, О.Нанжид
з\Байгууллага, салбарууд, баг тус бүрийн СВОТ, таницуулгууд, зургийн хамт бэлтгэх	2013.07-08 сард	ЗДТГ Г.Батчулуун, чиглүүлэгч-Б.Эрдэнэнаран голлон хариуцаж зохион байгуулан Ажлын хэсэг хүлээж авах ба байгууллагуудын удирдлага, ТХХ-ны бүлгүүд, багийн засаг дарга нар голлоно
и/ 3-р бүлэг, Стратеги төлөвлөгөөний хүснэгтүүд-матрицуудыг боловсруулан бичиж оруулах	2013.07-08 сард	ТХХ-ны ажлын бүлгүүд гаргаж Ажлын хэсэг нэгтгэх, Бүлгийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар нар голлон хариуцаж ажиллах
к\ Стратеги төлөвлөгөөний төслүүдийн танилцуулгыг бэлтгэх	2013.07-08 сард	ТХХ-ны бүлгүүд тодорхойлж, дотооддоо хуваарийг хүн нэг бүрээр гарган хийлгэж хэлэлцүүлэх ТХХ-ны бүрэлдэхүүнээр хэлэлцүүлэхийг ажлын бүлгүүд-ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар хариуцна. Нэгтгэлийг Ажлын хэсэг хийнэ.

10	Үр дүнгийн семинар бэлтгэн зохион байгуулах	2013-09 сарын 25-30-ны хооронд	ТХХ, МНУХ-той хамтрахаар тохиролцох, зөвлөхтэй холбоотой ажиллах. Чиглүүлэгч голлон аймгийн зөвлөх хөтөчтэй тохиролцох. Иргэний танхим Х.Гэрэлтуяа оролцох
11	Стратеги төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг бүрэн хэмжээгээр эцэслэж боловсруулан олон нийтэд танилцуулж санал авах	2013 10 сарын 15	Засаг дарга, ИТХ-ын дарга нар, Иргэний танхим голлон зохион байгуулж, Ажлын хэсэг, ТХХ-бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар нар хариуцан, зөвлөх баг оролцоно. Аймгийн зөвлөх-хөтөч мониторинг хийх
12	Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө (Төлөвлөгөөг хэрэгжүүлэх матриц)-г боловсруулах, сайжруулах, эцэслэн боловсруулах	2013 10 сарын 15	Ажлын хэсэг, ТХХ, бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар, орон нутгийн зөвлөх-хөтөч, чиглүүлэгч нар
13	Стратеги төлөвлөгөөний хяналт үнэлгээ хийх төлөвлөгөөг боловсруулах, өөрчлөн сайжруулах, эцэслэн боловсруулах	2013 10 сарын 15	Ажлын хэсэг, ТХХ, бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар, орон нутгийн зөвлөх-хөтөч, чиглүүлэгч нар
14	Стратеги төлөвлөгөөний олон нийтийн харилцаа хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, өөрчлөн сайжруулах, эцэслэн боловсруулах	2013 10 сарын 15	Ажлын хэсэг, ТХХ, бүлгүүдийн ахлагч Б.Эрдэнэнаран, Д.Батхүрэл, П.Ариунсан, Э.Батбаатар, орон нутгийн зөвлөх-хөтөч, чиглүүлэгч нар
15	Стратеги төлөвлөгөөний баримт бичгийн бүрдлийг эцэслэн хянаж, ИТХ-д хүлээлгэн өгөх, ИТХ-ын тусгай хуралдаанаар хэлэлцүүлэх	2013.10 сард ИТХ-д хүлээлгэн өгч, 2013 оны 10-11сард багтаан хэлэлцүүлж батлах	Сумын Засаг дарга Д.Батхүрэл, ИТХ-ын дарга П.Ариунсан, ТХХ-ны бүлгүүдийн ахлагч нар болон чиглүүлэгч-Б.Эрдэнэнаран голлоно
16	Төлөвлөгөөний боловсруулалтын явц, үр дүнгийн талаар иргэдэд тогтмол мэдээлж байх	Байнга	Ажлын хэсэг, ТХХ, чиглүүлэгч-Б.Эрдэнэнаран, сумын иргэний танхим, ТХХ-ны гишүүд бүгд

17	Төлөвлөлт, хяналтын хороо, ажлын хэсгийн ажил хэрэгч байдлыг дээшлүүлэх, идэвхжүүлэх	Боловсруулалтын явцад	Засаг дарга Д.Батхүрэл, ИТХ-ын дарга П.Ариунсан нар болон ажлын бүлгүүдийн бусад ахлагч нар
18	Аймгийн зөвлөх-хөтөчтэй байнгын холбоо тогтоон мэдээлэл солилцож төлөвлөгөө боловсруулах явцыг чиглүүлж ажиллах	Байнга	Сумын чиглүүлэгч, Ажлын хэсэг-Б. Эрдэнэнаран
19	Сумын дүрмийг ажил хэрэгчээр хэлэлцүүлэн ИТХ-аар батлуулах ажлыг удирдан зохион байгуулах	2013.07-10 сард	Засаг дарга Д.Батхүрэл, ИТХ-ын дарга П.Ариунсан нар хариуцаж баг, байгууллагын дарга нар хамтрах

ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙН НЭГДСЭН ХҮСНЭГТ

Хөтөлбөрийн хувийн дугаар, нэр	№	Төсөл, үйл ажиллагааны хувийн дугаар, нэр	Хугацаа			Төсвийн тооцоо (сая. төг)	Санхүүжилтийн эх үүсвэр			Орлонгч талууд
			Эхлэх	Дуусах	Үргэлжлэх		Орон нутгийн төсөв	Улсын төсөв	Хандив, төсөл хэрэгжүүлэгчид зардал	
Хөтөлбөр 1.1.1 Малын үржлийн ажлын үр дүнг дээшлүүлж, үйлдэр угсааг сайжруулах	1	1.1.1.1 Шилмэл омгийн хээлтүүлэгч дархадын ууцан сүүлт хонь авна	2015	2021	7	20,0	10,0	10,0	10,0	ИТХ, ЭДТГ, ТХХ, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	2	1.1.1.2 Шилмэл омгийн хээлтүүлэгч эрчмийн хар ямаа авна	2015	2021	7	20,0	10,0	10,0	10,0	ИТХ, ЭДТГ, ТХХ, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	3	1.1.1.3 Шилмэл омгийн хээлтүүлэгч сэлэнгэ үүлдрийн халзан бух авна	2014	2021	8	30,0	20,0	10,0	10,0	ИТХ, ЭДТГ, ТХХ, малчид, төсөл хэрэгжүүлэгч
	4	1.1.1.4 Адууны угшил, үүлдрийг сайжруулж, хурдан удмын адуутай болно	2015	2021	7	20,0	10,0	10,0	10,0	ИТХ, ЭДТГ, ТХХ, малчид, МСУХ, уяачид
Хөтөлбөр 1.1.2 Мал эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах	5	1.1.1.5 Бод малд зохиомол хээлтүүлэг хийнэ	2015	2021	7	10,0			10,0	ИТХ, ЭДТГ, ТХХ, малчид, төсөл хэрэгжүүлэгч
